



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-48</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>49-142</i>
<hr/>	
<i>1. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>50 -65</i>
<i>2. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>65-102</i>
<i>3. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	<i>102-113</i>
<i>4. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>113-122</i>
<i>5. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>122-131</i>
<i>6. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>131-137</i>
<i>7. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	<i>137-140</i>
<i>8. Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох</i>	<i>140-141</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 32 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Х.Баделхан, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Х.Болорчулуун, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ц.Туваан, Н.Учрал, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Э.Бат-Амгалан, Б.Баярсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Одонтуяа, Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: С.Батболд;

Хоцорсон: С.Бямбацогт-06 минут, С.Ганбаатар-51 минут, Ц.Даваасүрэн-3 цаг 09 минут, Д.Өнөрболор-17 минут, Ш.Раднаасэд-4 цаг 01 минут, Ч.Ундрам-26 минут, Ж.Чинбүрэн-02 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Л.Мөнхбаатар нараас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг хойшлуулах тухай Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаас ирүүлсэн 1521 тоот албан бичгийг танилцуулж, хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хариуцсан сайд байхгүй тул хойшлуулав.

Нэг. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням, мөн газрын Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Судалгаа шинжилгээний албаны ажилтан Л.Хангарди, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, “Трансперенси Инернэйшнл-Монгол” НҮТББ-ын гүйцэтгэх захирал Л.Төр-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ж.Батжаргал, Л.Мөнхбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга Д.Дуламсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Энхбаяр, Н.Энхболд нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын

Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Пүрэвдорж, А.Адъяасүрэн, С.Ганбаатар, Ч.Ундрам, Д.Өнөрболор, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч П.Анужин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 13 цаг 22 минутаас хуралдааныг даргалав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “даатгуулагч” гэсний өмнө “нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор” гэж нэмж, мөн заалтын “заасан хувь хэмжээгээр” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасаж, мөн зүйлийн 7.2.3 дахь заалтын “гадаад орноос Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар” гэснийг “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар” гэж өөрчилж, 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад байрладаггүй өөрийн төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, Монгол Улсаас эх

үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтын “ганц гишүүнтэй ажил олгогчийн захирал,” гэснийг, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “эсхүл эцэг” гэсний дараа “, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч эх, эсхүл эцэг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.4.10 дахь заалт нэмж, мөн зүйлийн 7.5.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах.

“7.4.10.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.10 дахь хэсэг нэмэх:

“7.10.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд энэ хуулийн 19.1.2-т заасан гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол энэ хуулийн 7.9 дэх хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 12
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4, 12.1.5 дахь заалт нэмэх:

“12.1.4.энэ хуулийн 13.3-т заасан зөвлөлийн гишүүний урамшуулал, үйл ажиллагааны зардал;

12.1.5.нийгмийн даатгалын сангаас төлөх шимтгэлийн төлбөр;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “үүрэг бүхий” гэсний дараа “орон тооны бус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хувь хэмжээ,” гэсний дараа “хэрэглэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “бүсийн болон хээрийн нэмэгдэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн 19.1.4 дэх заалтын “зүйлийн 19.1.1, 19.1.2-т “ гэснийг “хуулийн 19.1.1-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.28 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 21.31 дэх хэсгийг хасах:

“21.28.энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын зохих санд төлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 12
Бүгд: 42
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “4 дүгээр” гэснийг “8 дугаар” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “төлсөн” гэсний дараа “тэтгэврийн даатгалын” гэж нэмж, мөн зүйлийн 27.4 дэх хэсгийн “тусгай дансанд” гэснийг “тусгайлан” гэж, 27.7.2 дахь заалтын “системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 10
Бүгд: 42
76.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “орлогыг” гэснийг “орлогын тодорхой хувийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож зөрүүг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 13 минут үргэлжилж, 13 цаг 45 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 34 минутад эхлэв.

Г.Занданшатар: 14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын “ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон” гэснийг “ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ болон энэ хуулийн 21.1-д заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “үйлдвэрчний эвлэлээс” гэснийг “байгууллагаас” гэж өөрчилж, мөн зүйлийн 35.3 дахь хэсэг, 35.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.15, 35.16 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 35.9 дэх хэсгийг хасах:

“35.3.Ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллага нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

35.15.Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-т заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

35.16.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17

Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.17 дахь хэсгийн “тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын” гэснийг, мөн зүйлийн 35.20 дахь хэсгийн “Энэ зүйлийн 35.14-т заасан” гэснийг тус тус хасаж, 35.17 дахь хэсгийн “аудитын” гэсний дараа “орон тооны бус” гэж, 35.19 дэх хэсгийн “35.17-д заасан” гэсний дараа “мэргэжлийн хорооны ажиллах журам,” гэж тус тус нэмж, 35.17 дахь хэсгийн “ажиллуулж, урамшуулал олгоно” гэснийг “ажиллуулна” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 35.20 дахь хэсэг нэмэх:

“35.20.Энэ хуулийн 35.19-т заасан урамшууллыг мэргэжлийн хорооны гишүүний ажлын үр дүнг харгалзан Үндэсний зөвлөл олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалтын “нормативыг” гэснийг “дээд хязгаарыг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.9, 37.12 дахь хэсгийн “өвчин судлалын” гэсний дараа “төрөлжсөн мэргэшлийн” гэж, мөн зүйлийн 37.12 дахь хэсгийн “нийгмийн хамгааллын” гэсний дараа “болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтын “, хууль тогтоомж зөрчихийг зөвлөх, тулгах, шаардах” гэснийг хасаж, мөн зүйлийн 39.1.7 дахь заалтыг “39.1.7, 39.1.8, 39.1.9” дахь заалт болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалтын “хорогдуулах” гэснийг “богиносгох” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “үүссэн үүргийн дагуу” гэснийг “тогтоосон” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “343 дугаар зүйлд заасан ажил гүйцэтгэх, мөн хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах” гэснийг “343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээ” гэж, 29 дүгээр зүйлийн 29.5.2 дахь заалтын “тусгай” гэснийг “тухайлсан” гэж, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “хуулиар тогтоосон” гэснийг “хуулийн 25.1-д заасан” гэж, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 35.6 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Төв” гэснийг “Магадлалын төв” гэж тус тус өөрчилж, 44 дүгээр зүйлийн 44.6, 44.7 дахь хэсгийг 44.8, 44.9 дэх хэсэг болгон шилжүүлэх.

2.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “(цаашид "Итгэмжит зөвлөх" гэх), (цаашид "Зөвлөх" гэх), (цаашид "Тэргүүлэх" гэх)” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтын “0-16” гэснийг “0-18” гэж, 37.2.2 дахь заалтын “16” гэснийг “18” гэж, 37.2.2, 37.2.3 дахь заалтын “эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж, 37.3 дахь хэсгийн “комисс” гэснийг “зөвлөл” гэж, 37.4 дэх хэсгийн “37.2.1, 37.2.2-т” гэснийг “37.2.1-д” гэж, 37.5 дахь хэсгийн “37.2.1-37.2.3-т заасан комиссын” гэснийг “37.2.1, 37.2.2-т заасан зөвлөлийн” гэж, 37.9 дэх хэсгийн “комиссоос” гэснийг “зөвлөлөөс” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн “37.2.2” гэснийг, 37 дугаар зүйлийн 37.5 дахь дэх хэсгийн “-37.2.3” гэснийг тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 12
Бүгд: 41
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “татварын өрөө барагдуулаагүй татвар” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өрөө барагдуулаагүй татвар, шимтгэл” гэж, мөн заалтын “татварын” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “73.1.4¹” гэснийг “73.1.4.а” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйл болгох:

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн тайлбар хэсгийг хассугай.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 8.2, 8.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалтын “тэтгэвэр, тэтгэмжийн” гэснийг “тэтгэврийн” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 10
Бүгд: 41
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсэг,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “гарчиг” гэснийг “нэрийн “ДААТГАЛЫН ТУХАЙ” гэснийг “ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ” гэж, мөн зүйлийн “45 дугаар зүйлийн 45.1.3” гэснийг “44 дүгээр зүйлийн 44.1.3” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 12
Бүгд: 41
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “44 дүгээр зүйлийн 44.6-д” гэснийг “43 дугаар зүйлийн 43.5-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 11
Бүгд: 41
73.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах шинжээч А.Цолмон, мөн хэлтсийн шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан референт Н.Монголмаа нар байлцав.

Г.Занданшатар: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “3-5” гэснийг “2-5” гэж өөрчилж, 4.7 дахь хэсгийн “сургуульд” гэсний өмнө “ерөнхий боловсролын” гэж нэмж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Сургуулийн өмнөх боловсролыг 4, бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 10

Бүгд: 41

75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу сургалтыг танхимын бус хэлбэрээр үргэлжлүүлэн” гэснийг “сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.3-т заасан хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 10
Бүгд: 41
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “**ГУРАВДУГААР БҮЛЭГ**”-ийн нэрийг “**ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ**” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “хөгжлийн онцлог” гэснийг “онцлог” гэж, 6.3 дахь хэсгийн “саналыг” гэснийг “санал, зөвшөөрлийг” гэж, 6.5 дахь хэсгийн “Энэхүү тогтоосон хугацаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байна” гэснийг “Энэхүү тогтоосон хугацаа нь ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөгөөр судлах хичээлийн цагийг өөрчлөх үндэслэл болохгүй.” гэж, 6.7, 6.9 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 6.7 дахь хэсгийн “сувилагчтай” гэснийг “сувилагч болон сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтантай” гэж өөрчилж, 6.1 дэх хэсгийн “Тайлбар”-ыг төслөөс хасаж, 6.4, 6.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Боловсролын ерөнхий хуулийн 8.4-т заасан ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “монгол хэлээр” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 6.1-д заасан хэлээр” гэж өөрчилж, 7.4 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 7.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.5 дахь хэсэг нэмэх:

“7.4.Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Боловсролын ерөнхий хуулийн 6.6-д заасан суралцагч ерөнхий боловсролыг бичгийн болон монгол дохионы хэлээр эзэмшинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 10
Бүгд: 39
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “математикийн” гэсний дараа “болон цахим технологийн” гэж нэмж, 8.3 дахь хэсгийн “хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт хөтөлбөр” гэснийг “энэ хуулийн 8.2-т зааснаас гадна нэмэлт үйл ажиллагаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 8

Бүгд: 40
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ”-ийн нэрийн “сургалтын” гэснийг “боловсролын” гэж өөрчилж, 9 дүгээр зүйлийн гарчиг, 9.1 дэх хэсгийн “сургалтын” гэснийг, 9.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Ерөнхий боловсролын агуулгыг математик, байгалийн ухааны, нийгэм, хүмүүнлэгийн, хэл, харилцааны, бие бялдрын, урлаг, гоо зүйн, цахим болон зохион бүтээх технологийн, иргэний боловсрол, амьдрах ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 8
Бүгд: 40
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “сайжруулж болно” гэснийг “сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн сайжруулж болно” гэж өөрчилж, 10.1, 10.2, 10.4, 10.6, 10.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслөөс 10.7 дахь хэсгийг хасах.

“10.1.Сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлалтай байна. Үзэл баримтлалыг Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан Үндэсний зөвлөл хэлэлцэж, Засгийн газар батална.

10.2.Сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 10.1-д заасан үзэл баримтлалд үндэслэн энэ хуулийн 8.2, 9.2-т заасан агуулгын хүрээнд боловсруулна.

10.4.Энэ хуулийн 7.4, 10.2, 10.3, 10.10-т заасан сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, Боловсролын ерөнхий хуулийн 14.8-д заасан цахим сургалтын хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөл нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, хичээлийн жилийн бүтцийн талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Зөвлөл нь багш, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөллийн оролцоог хангасан байна.

10.8.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой тохируулга хийж болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 5
Бүгд: 40
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэснийг “3 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэж, мөн хэсгийн тайлбарын “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэснийг “Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэж, “0-2 настай” гэснийг “3 хүртэлх насны” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.11, 10.12 дахь хэсэг нэмэх:

“10.11.Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байна.

10.12.Энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт тухайн орон нутгийн түүх, соёл, байгаль, газар зүйн онцлогийг тусган хэрэгжүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 7
Бүгд: 40
82.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3, 11.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Энэ хуулийн 10.6-д заасан мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн ерөнхий боловсролын сургалтад хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3.Сурах бичиг зохиоход багш, эрдэмтэн, судлаач, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, мэргэжлийн холбооны төлөөллөөс санал авна.

11.9.Харааны бэрхшээлтэй, энэ хуулийн 7.2-т заасан суралцагчид зориулан сурах бичгийг хөрвүүлнэ. Үндэстний цөөнх, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эх хэлний сурах бичгийг зохионо.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 9
Бүгд: 40
77.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “сурах бичиг зохиох турших, сургалтад ашиглахтай” гэснийг “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээхтэй” гэж, 11.6 дахь хэсгийн “хөтөлбөрийн хэрэгжилтийн” гэснийг “сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, 11.7 дахь хэсгийн “үнэ төлбөргүй” гэснийг “төлбөргүй” гэж, “ашиглуулна” гэснийг “ашиглуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол сурах бичгийг худалдан авч болно.” гэж, 11.12 дахь хэсгийн “танин мэдэхүйн” гэснийг “сэтгэхүйн” гэж өөрчилж, 11.4 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмж, 11.10, 11.11 дэх хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 6
Бүгд: 40
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “ахиулах зорилгоор” гэснийг “ахиулахад чиглэсэн” гэж өөрчилж, 12.1.3, 12.1.5 дахь заалт, 12.1.6 дахь заалтын “тайван амьдрах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 5
Бүгд: 40
87.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь хэсгийн “дэг журмыг” гэснийг “дүрэм, журмыг” гэж өөрчилж, 13.1.1, 13.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.1.бие даан суралцах, хувь хүн, бүлэгтэй хамтран ажиллах, харилцааны ур чадвараа хөгжүүлэх;

13.1.3.бусад суралцагчийг эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 6
Бүгд: 40
85.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 14.2 дахь хэсгийн “хүүхдийн тооноос” гэснийг “хүүхдийн тоо, ялгаатай хэрэгцээнээс” гэж, мөн хэсгийн “бусад” гэснийг “холбогдох хууль тогтоомжид заасан” гэж, 14.4 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах болон холбогдох хууль тогтоомжид заасан ажилтан” гэж өөрчилж, 14.1 дэх хэсгийн “үйлчилгээний” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эмч” гэсний дараа “номын санч” гэж, мөн доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх.

“14.6.Цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйч ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 8
Бүгд: 40
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “сургуулийн багш” гэснийг “ерөнхий боловсролын сургуулийн багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 15.1.1 дэх заалтын “сургалтын” гэснийг “боловсролын” гэж, 15.1.3 дахь заалтын “төлөвшил, авьяас чадварыг хөгжүүлэх, амжилттай суралцахад” гэснийг “мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд” гэж өөрчилж, 15.1.5 дахь заалтын “байгуулах” гэснийг, 15.1.1 дэх заалтын “бүрэн” гэснийг, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Багш нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 9
Бүгд: 39
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15.1.2, 15.1.6 дахь заалт, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.6 дахь хэсэг нэмэх:

“15.1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу арга хэмжээ авахтай холбоотой бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

15.1.6.хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах.

15.5.Багш нь суралцагчийн хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

15.6.Энэ хуулийн 27.2-т заасан суралцагчийн үнэлгээг бусдад задруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 8
Бүгд: 39
79.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Багш нь” гэсний дараа “дээд боловсролтой” гэж, 16.6 дахь хэсгийн “мэргэжил дээшлүүлсэн” гэсний дараа “магистр зэрэгтэй” гэж нэмж, 16.2 дахь хэсгийн “Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж, 16.7 дахь хэсгийн “түвшин” гэснийг “мэдлэг” гэж, “3-5 жил” гэснийг “3 жил” гэж өөрчилж, мөн зүйлийн гарчгийн “гасралтгүй” гэснийг, 16.5 дахь хэсгийн “үндэсний, орон нутгийн түвшинд болон ажлын байранд” гэснийг хасаж, 16.4, 16.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.4.Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, орон нутаг, үндэсний түвшинд зохион байгуулна.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн түвшинд зохион байгуулах багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 12.12-т заасан нэгж зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 8

Бүгд: 41

80.5 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг томилсон этгээд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан байгууллагад хичээлийн жилд тайлагнах, хариуцах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 9

Бүгд: 41
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас найруулгыг анхаарах чиглэл өгөв.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ЗУРГААДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийн “СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА” гэсний өмнө “БОЛОВСРОЛЫН” гэж нэмж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “боловсролын болон төсвийн” гэснийг “боловсролын” гэж, 18.3 дахь хэсгийн “үйл ажиллагаандаа баримтлах” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.23-т заасан үлгэрчилсэн дүрэмд нийцсэн” гэж, 18.7 дахь хэсгийн “өөрийн” гэснийг “өөрийн болон хөндлөнгийн” гэж өөрчилж, 18.1 дэх хэсгийн “хүүхдийн” гэснийг, 18.9, 18.10 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.11, 18.12, 18.13, 18.14 дэх хэсэг нэмэх:

“18.11.Ерөнхий боловсролын сургууль дотуур байртай байж болно. Дотуур байрын орчин, үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж, мөрдөнө.

18.12.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа суралцагчид зориулан энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааны хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

18.13.Энэ хуулийн 18.12-т заасан хөтөлбөрийг Боловсролын ерөнхий хуулийн 43.1.2-т заасан зардлаас санхүүжүүлнэ.

18.14.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь номын сантай байх бөгөөд Номын сангийн тухай хуулийн 10.3-т заасан үйлчилгээ үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 10
Бүгд: 41
75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон холимог бүлгээр зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 9
Бүгд: 41
78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийг төслөөс хасаж, 20.14 дэх хэсгийн “энэ хуулийн 8.7-д” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 8.1-д” гэж өөрчилж, 20.4, 20.11, 20.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.4.Энэ хуулийн 20.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг тогтооход хөгжлийн бодлого, төлөвлөлт, хүн амын нягтаршил, газар зүйн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзана.

20.11.Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.

20.16.Энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааг үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэдтэй хамтран зохион байгуулна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	9
Бүгд:	41

78.0 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.17 дахь хэсэг нэмэх:

“20.2.3.1-12 дугаар ангитай, эсхүл 6-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль;

20.2.4.10-12 дугаар ангитай ахлах сургууль.

20.17.Энэ хуулийн 20.11-д заасан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	31
Татгалзсан:	10
Бүгд:	41

75.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь заалтын “сургалт” гэсний дараа “, үйл ажиллагаа” гэж нэмж, 21.1.2 дахь заалтын “дэмжигч /явуулын/ багшийн” болон “нүүдлийн бүлгийн” гэснийг “хувилбарт” гэж, 21.3 дахь хэсгийн “боловсролын болон санхүү, төсвийн” гэснийг “боловсролын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 21.4 дэх хэсэг нэмэх:

“21.4.Хувилбарт сургалтад энэ хуулийн 5.1-д заасан хугацаа хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	27
-------------	----

Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрээр эзэмшүүлж болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Боловсролын ерөнхий хуулийн 39.2-т заасан” гэж нэмж, 23.2.1 дэх заалтын “хөгжил, бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх явцад санал, дүгнэлт гаргах” гэж өөрчилж, 23.2.5 дахь заалтын “бүх талын оролцоог хангах” гэснийг, 23.2.4 дэх заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.8, 23.2.9 дэх заалт нэмэх:

“23.2.8.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийг эрэмбэлэх, шийдвэрлүүлэх, санал өгөх;

23.2.9.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.3 дахь заалтыг нэгтгэн 23.2.2 дахь заалт болгон өөрчлөн найруулж, мөн зүйлийн 23.2.6, 23.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.2.2.суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагын хоцрогдол үүсэхээс сэргийлэх, сургалтын аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг энэ хуулийн 18.8-д заасан зөвлөлтэй хамтран зохион байгуулах;”

23.2.6.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх;

23.2.7.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан гэрээнд тусгах саналыг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралд хүргүүлэх, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 10
Бүгд: 39
74.4 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.4 дэх хэсэг нэмэх:

“25.4.Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг энэ хуулийн 16.5-д заасан нэгжтэй хамтран зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 8
Бүгд: 37
78.4 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн мэргэжлийн” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан” гэж, 26.6 дахь хэсгийн “18.8-д заасан өөрийн” гэснийг “18.7-д заасан” гэж, 26.7 дахь хэсгийн “боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн санд” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага боловсролын цахим мэдээллийн санд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 7
Бүгд: 38
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “1-2” гэснийг “1-3” гэж, 27.4 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны”

гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд заасан орон нутгийн” гэж, 27.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.6.Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг үндэслэн давтан сурах боломжийг суралцагчид олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 8
Бүгд: 38
78.9 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг төслөөс хасаж, 28.3 дахь хэсгийн “заавал хамруулах үүрэг хүлээнэ” гэснийг “хамруулахад захиргааны дэмжлэг үзүүлнэ” гэж, 28.6 дахь хэсгийн “мэдээллийн” гэснийг “цахим” гэж өөрчилж, 28.4 дэх хэсгийн “орон нутгийн” гэсний дараа “цэцэрлэг” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.10, 28.11 дэх хэсэг нэмэх:

“28.10.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.5.2, 27.5.3-т заасан үйлчилгээг төлөөлөн хэрэгжүүлэхээр томилсон этгээдтэй байгуулах гэрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, боловсролын чанарыг ахиулах талаар тусгана.

28.11.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлэх, холбогдох хуульд заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг эрх бүхий этгээдийн баталсан журмын дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 5
Бүгд: 38
86.8 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 4
Бүгд: 38
89.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, 1.Төслийн 4.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.7.Хөдөө аж ахуйн салбарт ажилладаг өрхийн хүүхэд болон хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдал бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүүхдийг 7 настайд сургуульд элсүүлж болно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 7
Бүгд: 38
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Ганбаатар, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Нийгмийн даатгалын ерөнхий газрын

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Уг асуудлын санал хураалтыг 16 цаг 29 минутад түр хойшлуулав.

Тав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрх үүсэх нөхцөл, хэмжээ, хугацаа,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн “хөнгөлөлт” гэсний дараа “, шимтгэлийн төлбөр” гэж нэмж, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “тэтгэмжийг”

гэснийг “тэтгэмж, шимтгэлийн төлбөрийг” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.1.4 дэх заалт нэмэх:

“2.1.4. Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, мөн хэсгийн “3-60” гэснийг “3-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Энэ зүйлийн 9.1-д заасан нөхцөлийг” гэснийг хасаж, мөн хэсгийн “нөхцөлийг” гэснийг “эрхийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан” гэснийг “Даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн” гэж, мөн хэсгийн “24-60” гэснийг “24-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж, мөн зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүсэлтээ” гэснийг “хүсэлт, ажил идэвхтэй хайж байгаа тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын тодорхойлолт болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 11
Бүгд: 38
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 12
Бүгд: 38
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг суурь болгож, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нараас өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан 2.1.6 дахь заалт нэмэх:

“2.1.6.“хүндэтгэн үзэх шалтгаан” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн ”ТОГТОЛЦОО” гэснийг “ТӨРӨЛ” гэж өөрчилж, төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэвэр

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болно.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон дугаарыг өөрчилж зүйлийн гарчгийн “тэтгэвэр” гэснийг “тэтгэврийн төрөл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “55” гэснийг “50” гэж, “50” гэснийг “45” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.4 дэх заалтад хамаарах тайлбарыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Даатгуулагч” гэснийг хасаж, “төрсөн,” гэсний дараа “мөн энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан даатгуулагч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн томьёоны “НДс₂” гэснийг “НДс₃” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “04” гэснийг “01” гэж өөрчлөн, мөн зүйлд доор дурдсан 27.2 дахь хэсэг нэмэх:

“27.2.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.1.Энэ хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 15

Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан 29.3 дахь хэсэг нэмж, 29.3 дахь хэсгийн дугаарыг “29.4” болгож, мөн хэсгийн “25.1-д” гэснийг “25.1, 29.3-т” гэж өөрчлөх.

“29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “10” гэснийг “20” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 31
Бүгд: 38
18.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан 29.3 дахь хэсэг нэмэх:

“29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодож зөрүүг буцаан олгоно гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” болон “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар” гэж, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-г” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д” гэж, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, 24 дүгээр зүйлийн “нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн” гэснийг “Нийгмийн

даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг “4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Тав.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зургаа.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Долоо.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найм.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, “Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Ес.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн холбогдох техникийн засварыг хийж, төслийн 2 дугаар зүйлийн “заалтыг” гэсний өмнө “хэсэг, “ гэж нэмэн “өөрчилсүгэй:” гэснийг “өөрчлөн найруулсугай:” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38

65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	1
Татгалзсан:	37
Бүгд:	38

2.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Орхон, Судлаач, зөвлөх Г.Ганчимэг, Ц.Дашдондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэг, мөн зүйлийн 3.1.3, 3.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Даатгуулагч дараах нөхцөл байдалд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:”

3.1.3.ажлын цагаар ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд ажил үүргээ гүйцэтгэхээр явж байх үед;

3.1.5.ажилдаа ирэх, буцах зам, ажил үүргийн дагуу сургалтад оролцох болон Хөдөлмөрийн тухай хуулийн 93.1.1-д заасан амрах, хооллох завсарлагын үед;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “ноцтой” гэснийг хасаж, 3.1.8 дахь заалтын “зэрэглэлтэй дотоодын спортын тэмцээн, уралдаанд”

гэснийг “хэмжээний спортын тэмцээнд” гэж, 3.2 дахь хэсгийн “тохиолдолд үйлдвэрлэлийн осолд тооцохгүй” гэснийг “нь нотлогдсон тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй” гэж, 3.3 дахь хэсгийн “ослыг” гэснийг “осол, хурц хордлогыг” гэж, 3.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас” гэснийг “дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос” гэж, 5.3 дахь хэсгийн “Эрүүл мэндийн магадлалын” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн, 5.4.1, 5.4.2, 5.4.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 5.4.1 дэх заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 12-т хуваасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар, 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 0.167 хувиар тооцон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “6 сарын дотор” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “17.1-д” гэснийг “16.1-д” гэж, мөн зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж, 7.7 дахь хэсгийн “тэтгэврийн ердийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “6.1.1-д заасан хэмжээтэй” гэснийг “21.1.1, 21.2-т заасан хэмжээтэй тус тус” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийн, 9.3.2, 9.3.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 9.3.1 дэх заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “дундаж цалин хөлс” гэж, мөн заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 3-т хуваасан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “Даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэмж бодох” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “/байцаагч/-д” гэснийг хасаж, 11.1.3 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг “хөдөлмөрийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38

52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Шимтгэлийн” гэснийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “хэмжээгээр тооцож” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “даатгалын” гэсний өмнө “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 13.3 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16

Бүгд: 38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно.”

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “сэргээн засах болон” гэж, 14.1.3 дахь заалтын “рашаан,” гэснийг “сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн “Даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг нийгмийн даатгалын” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж, 14.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид протез” гэснийг “Протез” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч” гэж, 14.6 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид” гэснийг “Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “Сэргээн засах болон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэснийг “хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан” гэж, мөн хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 15.7 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 16.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь заалтыг хасах:

“16.3.1.ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, холбогдох бусад мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, мөн зүйлийн 16.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “биелүүлэх үед” гэснийг “гүйцэтгэх явцад” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “тогтоолгоход” гэж, 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “авахад” гэж тус тус өөрчлөх.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “/байцаагч/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн нэрийн “ХУУЛЬД” гэсний дараа “НЭМЭЛТ,” гэж, 2 дугаар зүйлийн ““хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж” гэсний дараа “, ““тахир дутуугийн тэтгэвэр” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр” гэж тус тус” нэмж, 1 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлнэ” гэснийг “заасан мэдээллийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Васгийн газар 2021.10.15-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболд, мөн хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Уг асуудлыг 18 цаг 00 минутад хойшлуулав.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хууль, Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн:

1.“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:01/

2.“Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:01/

4.“Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:02/

5.“Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:02/

6.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /18:03/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдаж гарсан:

7.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /18:03/

8.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /18:03/

9.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /18:03/

10.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /18:04/

11.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /18:04/

12.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль; /18:04/

13.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /18:04/

14.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:04/

15.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:05/

16.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /18:05/

17.Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль; /18:05/

18.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль; /18:05/

Холбогдуулан боловсруулсан:

19.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоол; /18:05/

Улсын Их Хурлын гишүүдээс хууль, тогтоолуудын эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хууль, тогтоолуудын эцсийн найруулгатай танилцлаа.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн урилгаар Баянхонгор аймгийн Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1991 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн урилгаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид, мөн аймгийн Алтай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтын урилгаар Ховд аймгийн 4 дүгээр 10-н жилийн сургуулийн 2003 оны төгсөгчид, Баянхонгор аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 44 минут үргэлжилж, 73 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 64.3 хувийн ирцтэйгээр 18 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 32 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтган мэндчилье.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлэг. Холбогдох сайд, хариуцсан сайд байхгүй учраас хойшлуулъя.

2.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

3.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

4.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

5.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

6.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /анхны хэлэлцүүлэг/

7.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

8.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Лхагвын Мөнхбаатар нарын гишүүдээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулыг хариуг сонсох ийм чиглэлтэй байсан.

Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг сайд нар байхгүй учраас хойшлуулсан.

Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Дашизэвэгийн Амарбаясгалангаас асуулгын тухай 1521 тоот албан бичиг ирүүлсэн байна. Уг албан бичгээр өнөөдрийн асуулгад хариулах Хаянгаагийн Болорчулуун сайд гадаад томилолттой байгаа учраас асуулгын хариуг хойшлуулж өгөх хүсэлт ирүүлсэн байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Лхагвын Мөнхбаатар нарын гишүүдээс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг

өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулж байна.

Одоо хэлэлцэх асуудалдаа орно. Төсвийн гүйцэтгэлийг хойшлуулсан.

2 дахь асуудал. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Нямбаатар сайдыг индэрт урьж байна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулах, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2023 онд дуусаж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хэлэлцэхэд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт дунджаар 75 хувьтай гарсан байна. Ийнхүү дээрх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр Монгол Улсын авлигатай тэмцэх ажилд ахиц гарч, тодорхой үр дүнгээ өгч байгаа бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан авлига, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангаруулж, хэрэгжилтийг сайжруулах, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигатай тэмцэхэд иргэд, олон нийт, хувийн хэвшлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, төсөв, санхүүгийн ил тод байдал хариуцлагыг өндөржүүлэх зэрэг энэхүү хөтөлбөрөөр хараахан

хүрээгүй үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай зарим үйл ажиллагаа арга хэмжээ хүлээгдэж байна.

Түүнчлэн Трансперенси Интернэйшнл Олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг авлигын төсөөллийн дүнгээр 180 орноос Монгол Улс 2017 онд 103, 2018 онд 93, 2019 онд 106, 2020 онд 35 оноо авч 111, 2021 онд 35 оноо авч 110, 2022 онд 33 оноо авч 116 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

Энэхүү авлигын төсөөллийн индекс нь манай улсын авлигын түвшинд өгч буй Олон улсын байгууллагын үнэлгээ бөгөөд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр энэхүү үнэлгээнд ахиц гарах ач холбогдолтой юм.

Улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгох нь даамжирч, иргэдийн боломжийг хязгаарлан, эдийн засаг, нийгэм, боловсрол, эрүүл мэнд зэрэг бүхий л салбарт тэгш бус байдлыг үүсгээд байна. Энэ нь улс орны эрсдэлийг нэмэгдүүлэн олон улсын байгууллагуудын үнэлгээнд сөргөөр нөлөөлж, улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулахад хүргэж байна.

Албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах эдгээр зохисгүй нөхцөл байдлыг таслан зогсоох, авлигатай тэмцэх тэмцлийг үр дүнтэй хэрэгжүүлэх, улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд урт ба дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг бодлого, төлөвлөгөөтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд дээрх бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, авлигын төсөөллийн индексэд ахиц гаргах, авлигатай тэмцэх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлэх зорилгоор дараагийн хөтөлбөрийг батлан гаргах хэрэгцээ шаардлагыг үзэл баримтлалд тодорхойлж, түүнд нийцүүлэн

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хөгжлийн зорилтот хөтөлбөрт хамаарч байгаа болно.

Хөтөлбөрийн төслийг Авлигатай тэмцэх газрын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг анхлан боловсруулсан бөгөөд авлигатай тэмцэх талаарх төрийн бодлого эрх зүйн орчин, үйл ажиллагааг цогцоор нь авч үзэн шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зарчмыг баримтлан боловсруулахын зэрэгцээ шинэ сэргэлтийн бодлого Засгийн газраас 2023 онд зарласан авлигатай тэмцэх “5Ш” ажиллагаа зэрэгтэй холбогдуулан тодорхойлсон болно.

Хөтөлбөрийн төсөлд нийт 10 зорилго, 46 зорилт, үүнийг хэрэгжүүлэхэд 203 үйл ажиллагааг тусгалаа. Хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон нийт үйл ажиллагааг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоо хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэх юм. Үр дүнд нь авлигын индексэд ахиц гарах, улсын төсөв тэлэх, иргэдийн төрийн байгууллага, төрд итгэх итгэлийн түвшин нэмэгдэх, иргэдийн орлого өсөж, авлигыг үл тэвчих соёл, шүгэл үлээх тогтолцоо бэхэжсэн байна гэж үзсэн болно.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал болон тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал,

дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилиуулна. Индэрт урьж байна.

Б.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч болон баримт бичгүүдэд тусгасан зорилтыг хэрэгжүүлэх, авлигын төсөөллийн индексэд ахиц гаргах, түүнчлэн Улсын Их Хурлаас 2016 онд баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжих хугацаа энэ онд дуусаж байгаатай холбогдуулан авлигатай тэмцэх ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлж, дараагийн хөтөлбөрийг батлах хэрэгцээ шаардлагыг үзэл баримтлалдаа тодорхойлж, түүнд нийцсэн 2023-2030 он хүртэл хэрэгжүүлэхээр “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын туслах тогтоолын төслийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг D-parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, дунд шатны албан тушаалтанд холбогдох авлига, албан тушаалын хэрэгтэй хэрхэн үр дүнтэй тэмцэх, тогтоолын төсөл батлагдсанаар авлигын төсөөллийн

индексийн дүнг ямар шалгуур үзүүлэлтээр хэдэн хувиар бууруулах, арга хэмжээ авах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Адьшаа Засгийн газраас 2023 онд зарласан авлигатай тэмцэх “5Ш” ажиллагаа, арга хэмжээний үр дүнгийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улс төрийн намын тухай хуулийн төслийг уг хөтөлбөртэй уялдуулж “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-т гишүүд онцгой ач холбогдол өгч ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хөтөлбөрт авлигын хэргийг давж заалдах шатны шүүх, анхан шатны журмаар шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ гэж заасан нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал нийцэхгүй байгааг хэлэлцүүлгийн явцад анхаарах, мөн гишүүд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоолын төсөлтэй холбогдуулан тодорхой саналаа Байнгын хороонд бичгээр ирүүлэх боломжтой талаар үг хэлсэн болно.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүнд санал нэгтгэйгээр үзэл баримтын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Пүрэвжавын

Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дорждэрэмийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Загараагийн Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, Авлигатай тэмцэх газрын судалгаа, шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Цэдэн-Ишийн Шинэбаяр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар албаны дарга, ахлах комиссар Чимэддоржийн Жаргалбаатар, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга, ахлах комиссар Батмөнхийн Баярсайхан, Авлигатай тэмцэх газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, эрхэлсэн комиссар Доржсүрэнгийн Дуламсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон. Цолмон Их Хуралд жоохон хүндэтгэлгүй хандаад байсан билүү, үгүй билүү. Ярилцлага энэ тэр өгөөд байсан уу, үгүй юу. Эдийн засгийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар шимтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Хорлоогийн Оюунцэцэг, Авлигатай тэмцэх газрын судалгаа шинжилгээний албаны ажилтан, комиссар Лхагважавын Хангарди, “Транспаренси интернэшнл” Монгол НҮТББ-ын гүйцэтгэх захирал Лхагважавын Төр-Од.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү. Лхагвын Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууна.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ер нь энэ хөтөлбөр батлахыг дэмжиж байгаа л даа. Тэгэхдээ 2 асуулт байна.

1 дүгээрт энэ хөтөлбөрт олон чухал чухал зорилтууд тусгаж л дээ. Улс төрийн хүрээнд, хувийн секторт, хүүхдийн хүмүүжлийн асуудал энэ тэр гээд. Тэгээд гол юм нь байхгүй юм шиг л санагдаад байх юм. Энэ нөгөө бид нар чинь Алсын хараа хөтөлбөрт ч гэсэн, намын хөтөлбөрт, Их Хурлын хөтөлбөрт энэ авлигын үндэс суурь болоод байгаа бизнест төрийн оролцоог багасгая, зохистой болгоё гэдэг л том зорилго дэвшүүлээд яваад байгаа шүү дээ. Тэр чинь энд ерөөсөө бүлэг байтугай, өгүүлбэр ч байхгүй юм шиг байх юм. Би түрүүнээс хойш л үзээд л, хараад л, эргүүлээд суугаад байна л даа. Ер нь бол үндэс нь тэр биз дээ. Авлигатай тэмцэх гол эдийн засгийн болон санхүүгийн эх үүсвэр нь. Тэрнээс биш хуулиа чангаруулаад, хэчнээн хөтөлбөр батлаад, хэчнээн хүн хүмүүжүүлээд, төр чинь орох, орохгүй бүх бизнесийг хийгээд, булаацалдаад, төрийн эрх мэдэлд асар их хэмжээний хөрөнгө мөнгө төвлөрөөд, тэгээд төрийн албан хаагчид тэр хөрөнгө мөнгийг нааш цааш нь гувчуулах бололцоо гараад байх юм бол бид нар яаж ч авлигатай тэмцээд нэмэр байхгүй шүү дээ. Тэр санаа чинь уг нь энэ хөтөлбөрийн ерөөсөө ноён нуруу болж, улаан шугам болж, тэр санаанд энэ хөтөлбөр үг, өгүүлбэрээрээ захирагдаж баймаар байх юм. Энэ дээр нэг тодруулга авмаар байх юм 1 дүгээрт.

2 дугаарт энэ Улсын Их Хурлаар, 3 Байнгын хороогоор дамжаад 2 жил, 3 жил хийсэн ажлаа сая Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хуралд тайлагнах гэж байна л даа. Монгол Улсын нэгдэж орсон 294 конвенц олон улсын. Тэр дундаа нөгөө Засгийн газар тайлангаа өгдөг 30 конвенц. Тэр дундаа эрүүдэн шүүх, авлига, үчээр алга болгох гээд ингээд Эрүүгийн хуультай холбоотой конвенцуудын хэрэгжилтийг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцээд, манай улсын нэгдэж орсон олон улсын гэрээ конвенцуудын хэрэгжилт 1 дүгээрт тааруу байна. 2 дугаарт хамгийн гол нь

Эрүүгийн хуульдаа жишээ нь эрүүдэн шүүх ялыг томъёолж оруулахдаа конвенцынхоо зүйлээсээ өөр болгоод оруулчихдаг, хүний эрх нөгөө хүчээр алга болох буюу нөгөө *enforced disappearance* гэдэг гэмт хэргийнхээ тодорхойлолтыг бас ингээд зөрүүлээд хийчихдэг гэх мэтээр энэ эд нарыгаа цэгцэлж, янзалъя гэсэн байгаа. Энэ уг нь бас хөтөлбөрт тусгай зүйл анги зүйл болж болж ормоор байгаа юм. Энэ дээр ямар санаа оноо байна хэлээч. Баярлалаа.

Г.Занданишатар: Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишигээгийн Нямбаатар асуултад хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Мөнх-Оргил гишүүн ер нь маш чухал асуудал хөндөж байгаа юм. Одоо бараг манай танхимд байгаа гишүүдийн дийлэнх нь Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, ер нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа гэдэг бол энэ хөтөлбөрт зонхилон дурдагдаад байгаа ял шийтгэлийн бодлогыг чангатгах, мөрдөн шалгах үйл ажиллагааны процессыг хялбаршуулах, хохирлыг нөхөн төлүүлэх гэх мэт агуулга төдийхнөөр ойлгож байхыг би үгүйсгэхийн аргагүй гэж бодож байгаа юм. Гэтэл яг олон улсад авлигатай тэмцэх үйл ажиллагааг ерөнхий байдлаар дараах 13 шалгуур үзүүлэлтээр авч үзэж байгаа юм.

Нэгд нь. Эдийн засагчдын чадавхын нэгж гэж Олон улсын байгууллагаас улс орнуудын эрсдэлийн үнэлгээг гаргаж байгаа юм. Тэгэхээр манай улс эрсдэлийн үнэлгээгээрээ ерөөсөө энэ үнэлгээгээ ахиулж чадахгүй байгаа. Өөрөөр хэлбэл энэ хөрөнгө санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулах тэр эрсдэлийг нь хэр их хамгаалж, бууруулж өгсөн юм бэ. Бид 1993 оны дампуурлын тухай хуулиа гаднын байгууллагууд маш олон жил зөвлөөд, энэ хуулиа өөрчлөхгүй тохиолдолд танай энэ бизнесийн харилцаа эрсдэлтэй шүү гээд зөвлөөд байдаг. Өнөөдрийг хүртэл бид нар шинэчилж чадаагүй байгаа. Одоо Их

Хуралд манай яамнаас өргөн бариад 1 жил гаран болж байна. Хэлэлцэх эсэхээ шийдчихээд байж байдаг. Тэгэхээр энэ бол гаднын зөвлөхүүдийг л бид нар сонсох ёстой.

2 дугаарт ер нь авлигын төсөөллийг гаргахад 2 дахь том шалгуур үзүүлэлт бол олон улсын эрсдэлийн удирдамжийн байгууллагаас гаргадаг. Энэ мөн л олон улс дахь манай улсын өрсөлдөх чадварын эрсдэлийн үнэлгээ байж байгаа юм.

3 дахь нь ардчиллын олон талт байдлын үнэлгээ буюу Видэм гэдэг байгууллагаас гаргадаг үнэлгээ.

Дараагийнх нь Дэлхийн өрсөлдөх чадварын төв гэдэг байгууллагаас гаргадаг. Монгол Улс өрсөлдөх чадварынхаа хувьд дэлхийн 180 орноос хэдэд байгаа юм бэ гэдэг.

Дараагийнх нь энэ бестмен гээд том тинк танк байгууллагаас гардаг шилжилтийн индекс нь ямархуу шатандаа байгаа юм бэ.

Дараагийнх нь Дэлхийн банкны манай улсад өгдөг 49 шалгуур үзүүлэлтээр Монгол улс эдийн засгаа хэрхэн либералчилж, хувийн секторын өрсөлдөх чадварыг хэрхэн тэгш чиглэлд хангаж байгаа юм бэ гээд.

Тэгээд улс орнуудын эрсдэлийн зэрэглэлийн үнэлгээ, дэлхийн эдийн засгийн форумын үнэлгээ, шударга ёсны үнэлгээ гээд. Тэгээд бид нар энэ 10 хэдэн шалгуур үзүүлэлтүүдээс ерөөсөө авлигатай тэмцэх гэхээр зөвхөн нөгөө шударга ёсны үнэлгээ буюу rule of law гэдгээр бид нар дэлхийд хэдэд жагсаж байгаагаараа л өөрсдийгөө шударга ёсны талаар авлигатай тэмцэх чиглэлээр гэдэг ийм бодлогоо чиглүүлээд байгаа нь алдаа юм. Тэгэхээр сая Мөнх-Оргил сайд маш чухал асуудал хөндөж байгаа нь юу вэ гэхээр энэ саяын миний дурдсан 13 шалгуур үзүүлэлт доошоогоо 40, 50 ийм шалгуур үзүүлэлтэд задраад тэрэнд нь

Монгол Улсын төрийн бодлого, хууль тогтоомжийн бодлогод хэрхэн чиглэж байгаагаас шалтгаалж тухайн улсын авлигатай тэмцэж байгаа тэр шалгуур үзүүлэлтүүд Си ни ай-ууд тодорхойлогдож байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр яг Мөнх-Оргил гишүүний хэлсэнчлэн яг энэ чиглэлийн тодорхой асуудлуудыг энэ хөтөлбөрт тусгаж ирсэн. Иргэд олон нийт хувийн хэвшлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, төсөв санхүүгийн байгууллагуудын ил тод байдал хариуцлагуудыг өндөржүүлэх гэх мэт тодорхой асуудлуудыг хөтөлбөрт бид нар тусад нь бүлэг болгож, бие даалгаж оруулж ирсэн. Цаашид ерөөсөө бид нар Их Хурлын гишүүд ч тэр, Засгийн газрын гишүүд ч тэр, төрийн дунд, доод бүх шатандаа бид нар авлигатай тэмцэх үндсэн чиглэлийн нэгээхэн хэсэг нь энэ үндэсний хөтөлбөрийн тодорхой энэ хууль сахиулах байгууллагуудад өгч байгаа чиглэл гэдэг агуулгаар л ойлгох хэрэгтэй. Бусад бүх чиглэлүүд нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Болчихсон уу. Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Мөнх-Оргил: Энэ хөтөлбөрт уг нь Нямбаатар сайд аа, ийм тоонууд л баймаар байгаа байхгүй юу. Одоо жишээ нь манайх дунджаар 15,7 их наяд долларын эдийн засагтай, Жи Ди Пи-тэй гэж бодоход улсын төсвийн зарлага бараг 40% нь байгаа байхгүй юу, 37,6% бид нарын баталсан төсөв. Тэгэхэд дэлхийн дундаж 16% байгаа байхгүй юу. Тэгэхээр нийт Жи Ди Пи буюу Монгол Улсад үйлдвэрлэж байгаа үйлчилгээ бүх юмаа бүх баялгийнхаа 40%-ийг нь төсвөөр буюу дээр нь өөр бид нар нөгөө төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ оруулах юм бол ерөөсөө нийт эдийн засгийн чинь 50% нь төрийн гараар эргэлдээд байна шүү дээ. Төрийн албан хаагчдын гараар. Гэтэл дэлхийн дундаж 16% байгаа байхгүй юу. Тэгэхээр ийшээ яаж хүргэх юм бэ гэдэг энэ дээр тоо тавьж бүр жил жилээр бид нар

эмэгтэйчүүдийн квотоо тэдэн хувь нэмнэ гээд л хөтөлбөр батлаад л явж байгаа шүү дээ. Яг тэрэнтэй адилхан улсын төсөвт, эдийн засагт эзэлж байгаа төсвийн зарлагыг тэдэн он гэхэд тэдэн хувь болгоно, тэдэн он гэхэд тэдэн хувь болгоно.../минут дуусав/

Г.Занданишатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна .

Х.Нямбаатар: Бид нар харин бас наадхыг чинь яг ярьсан юм аа. Ер нь бол цаашид бид нар энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, энэ бодлогын баримт бичгүүд боловсруулахдаа ерөөсөө л яг саяын таны хэлж байгаа болон энэ бусад шалгуур үзүүлэлтүүд бид нарт ямар дүгнэлт тавиад байгаа гэдэгт л чиглүүлмээр юм байна лээ. Тэрнээс орлого олохоо урьтал болгожгүй, дандаа популист амлалтуудаар бид нарын бодлогын баримт бичгүүд ихэвчлэн дүүрч байгаа.

2 дугаарт саяын таны хэлсэн рүү бид нар хүрэхийн тулд энэ намрын чуулганаар бид нар том хүлээлт байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчит компанийн хуулиа бид нар батлуулах гэж байгаа юм. Тэр компанийн хуулиар ямар зохицуулалт хийх гэж байгаа гэхээр Мөнх-Оргил гишүүн ээ, цаашид Монголын төр 5, 5 жилээр ямар бизнес хийхээ л тодорхойлж. Бусад бүх салбарт төр оролцохгүй, үүнийг хувийн сектор гүйцэтгэх ёстой гэдэг тоглоомын дүр юмаа тогтоож өгч байж саяын тэр тоо руу явна. Дээр нь бид нар сая таны хэлсэнчлэн энэ нөгөө Жи Ди Пи-тай харьцах энэ төрийн оролцооныг бууруулах талаар.../минут дуусав/

Г.Занданишатар: Цэндийн Мөнх-Оргил гишүүн тодруулж, 1 минут асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хэдүүлээ Их Хурал дээр энэ анхны хэлэлцүүлгийн үеэр энэ тоонуудыг оруулахыг бодъё. Засагтай ярьж байгаа. Тийм ээ. Тэгээд Нямбаатар сайд аа, 5, 5

жилээр жишээ нь намар хууль орж ирээд 5, 5 жилээр засаг төр ийм бизнест оролцоно гээд тодорхойлох юм байна л даа. 1 дүгээрт 5 жил чинь маш богинохон хугацаа. Засаг тэрийгээ хийх гээд явах гэсээр байтал хугацаа чинь өнгөрчихнө. Бизнесүүд тэрэнд дасаж амжихгүй. Тэгэхээр 5, 5 жилээр биш ерөөсөө бүр тогтмол ийм юманд л төр хийнэ, ийм юманд хамтарч оролцоно, ийм юманд огт оролцохгүй гэдэг нь эхнээсээ бүр тодорхой байвал амар байгаа байхгүй юу. Тэгэхгүй бол хууль батлаад л наадхыг чинь өөрчилчихнө шүү дээ Нямбаатар сайд аа. Жишээ нь юу гэдэг юм уул уурхайд огт орохгүй гээд хэлчихье гэж бодъё. Тэгтэл дараагийн Их Хурал гарч ирээд л уул уурхайд орно гээд л хууль баталчихна. Тэгээд л нөгөө эрх зүйн орчин нь өөрчлөгдчихнө. Төрийн бодлого нь өөрчлөгдчихнө. Бизнесүүдийн хүлээлт нь дампуураад дуусчихна.

Г.Занданишатар: Нямбаатар сайдад микрофонд хариулъя. 1 минут. Хишгээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Мөнх-Оргил гишүүний саяын саналуудыг хэдүүлээ анхны хэлэлцүүлгийн өмнө зарчмын зөрүүтэй санал гаргаад, компанийн хууль дээр энэ тэр шийдчихэж болно. Зүгээр OCD юу гэж зөвлөж байгаа вэ гэхээр 1 дүгээрт, 2 дугаарт бид нар нөгөө Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар дунд хугацааны бодлогын зорилт чинь 5 жилээр тодорхойлчихсон учраас л тэгж явсан юм. Энийг эргээд нөгөө дагасан хуулиа уялдуулж өөрчилж болох байх. Ер нь бол OCD юу гэж зөвлөдөг вэ гэхээр энэ дунд хугацааны зорилт дэвшүүлж явах ёстой. Тэгээд улс орнуудын дэвшүүлж байгаа стратегиуд нөгөө цаг үетэйгээ холилдож, уялдаж шинэчлэгдэх ийм шаардлагууд гардаг юм л гэж байгаа юм. Манайх тэр компанийн хуулийг бичихдээ манай яамныхан бүгд OCD-ийн зөвлөмжийг үндсэндээ бүрэн тусгаж, тэр хуулийг бичсэн гэдгийг хэлье. Тэгээд саяын таны хэлсэн тоонуудыг энэ хэлэлцүүлгийн явцад

хэдүүлээ оруулаад ингээд Си Пи Ай-уудаа тусгаад явчихъя.

Г.Занданишатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр авлигатай тэмцэх хөтөлбөрөө бид шинэчлэн баталж байна. Яах аргагүй энэ чиглэлээр бид нэлээн идэвхтэй, нэлээн хүсэл зориг гаргаж сайн ажиллах ёстой. Ингэхийн тулд хэд хэдэн тийм суурь асуудал байна уу гэж ингээж ойлгоод байгаа юм.

1 дүгээрт ерөөсөө энэ нийгмийн соён гэгээрлийн чиглэлийнхээ үйл ажиллагааг бид идэвхтэй явуулах ёстой. Энэ хөтөлбөрийн ер нь гол агуулга энэ дээр нэлээн төвлөрөх ёстой гэж.

2 дугаарт ерөөсөө ил тод байдлын хангалтын асуудлыг бид онцгойлон авч үзэх ёстой гэж ингээж ойлгоод байна. Дараагийн 1 зүйл ерөөсөө эдийн засагт төрийн оролцоог хязгаарлах бууруулах чиглэлээр л их тодорхой зүйлүүд орох ёстой. Дан дамаа энэ бид нарын эдийн засаг төсөвт орж ирж байгаа орлого, энэ бүх юмыг харахаар заяагдмал баялаг дээр суурилсан орлого, амьжиргаа давамгайлаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг дагасан янз бүрийн асуудлууд гараад байна гэдэг нь өнгөрсөн цаг хугацаанд яригдсан бүх зүйл эндээс гарч ирээд байгаа. Тийм учраас энэ заяагдмал баялаг дээр тулгуурласан аж ахуй, зохион байгуулалт, үр өгөөжийн дээшлэлтийн асуудлыг тэр олон нийтийнх нь оролцоо хяналтад аваачих эрх зүйн орчныг нь л бид бүрдүүлж өгөх ёстой. Өнөөдөр нэг тодорхой хувьцааны тоо яриад, тэр нь оролцоо юм шиг харагдаад, гэтэл оролцоогүй олон нийтийн засаглал болчхоод байгаа байхгүй юу. 1072 хувьцааг эзэмшиж байгаа тэр 2 сая гаран хүний төлөөлөл энэ Эрдэнэс таван толгойн ТУЗ-д байна уу. Ямар зохицуулалт бодлоготойгоор тэнд эд нарын эрх ашгийг хамгаалж энэ бодлого чиглэлд оролцож явна вэ. Үр

өгөөжийг нь дээшлүүлэх талаар ямар хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж байна вэ гээд ингээд бодохоор бидэнд яах аргагүй энийг тойрсон маш том эрх зүйн зохицуулалт хийх, тэгээд тэр олон нийтийнх нь оролцоо хяналтыг жинхэнээр нь бий болгох ингээж байж энд нэг эрүүл систем бий болгох, эрх зүйн зохицуулалтыг хийх чиглэлээр энэ хөтөлбөрт ер нь ямар бодлого чиглэл байна вэ гэдэг асуудал байна. Энэ дээр хариулт авъя гэж.

Дараагийн нэг зүйл ерөөсөө энэ нэмүү өртөг бүтээдэг, баялаг бүтээдэг салбараа гэдэг юм уу хөгжлөө том төслүүдээ хэрэгжүүлдэг санхүүгийн эх үүсвэр нь их тодорхой тэгээд нийтлэг хямд өртөгтэй байх тухай л асуудал байгаа. Өнөөдөр бид нар бас тодорхой салбар гэдэг юм уу чиглэл яриад хязгаарласан түвшинд хямд өртөгтэй зээлийн гэдэг юм уу санхүүгийн эх үүсвэр гаргаад тэр лүү нь хуруу дүрэх сонирхлууд олон болчхоод энэ нэг асуудал чинь үүсээд байгаа юм. Тэгвэл банк санхүүгийн байгууллагууд нийтлэгээрээ бүх хүнд ижил тэгш боломж олгосон хямд өртөгтэй эх үүсвэрийн асуудал л байгаад байна. Үүнийгээ яаж шийдэж байж асуудал зөв явах юм бэ. Үүгээр би энэ авлигатай тэмцэх ажлын бас нэг их том чиглэл гарч ирэх ёстой гэж ингээж хараад байгаа.

Дараагийн нэг зүйл энэ улс төрд нөлөө бүхий нөхдийн оролцоо, үйл ажиллагаа юмнуудыг үнэхээрийн сайн хумьж хязгаарлах ёстой. Гэхдээ алагчилж яримгүй л байна. Сонгогддог гэдэг юм уу Улсын Их Хурал гэдэг юм уу, эс үгүй бол бүх шатны хурлын төлөөлөгч нар дээрээ нэр заагаад тодорхой юм тавьчихаад, цаана нь тэр улс төрд нөлөө бүхий нөхөд нь сугарч үлдэхээр гэдэг юм уу ийм ангилал заалт байж таарамгүй ээ. Энэ Улсын Их Хурал, бүх шатны хуралд нэр дэвшигчид, түүнтэй хамааралтай хяналтын чиг үүрэг эрх зүйн орчин бүрдүүлэлтийн асуудлаар нэр дурдаад байгаа юмнуудаа ер нь яаж

ойлгоцгоогоод байна вэ. Үүнийгээ нэг хармаар байна. Тэр битгий хэл Их Хурлын гишүүд өгсөн санал нь.../минут дуусав/

Г.Занданшатар: 81. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

П.Сайнзориг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Би сүүлийнхээс нь эхлээд хариулъя. Ер нь мэдээж бас эдийн засгийн агуулга талаасаа дэмжиж, эдийн засгаа тэлж байж бас энэ авлигатай тэмцэх, энэ рүү бас хувийн хэвшлийн зөв оролцоог оруулах ёстой. Энд нь хямд эх үүсвэртэй санхүүгийн үйлчилгээг санал болгох ёстой гэдэг таны саналыг бол бүрэн дэмжиж байгаа. Энэ дээр ч бас агуулгын хувьд бас орж байгаа. Ингэхдээ мэдээж бас хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг бас Засгийн газраас үе шаттайгаар сайжруулах асуудал байгаа. Энэ дээр бол гадаадын банкны төлөөлөгчийн газар болон гадаадын банкны үйл ажиллагааг ерөнхийдөө дэмжиж бас оруулж ирж байж, тодорхой хямд эх үүсвэрийг татах энэ бололцоо бүрдэнэ.

2 дугаарт бид хэд бас энэ банкны үйл ажиллагаа зардалд нөлөөлдөг зарим хууль эрх зүйн орчны шинэчлэлийг зайлшгүй хийх хэрэгтэй байгаа юм. Энэ нь нөгөө зээлийн маргаантай холбоотойгоор дунджаар 4,5 жил явдаг байгаа. Шийдвэр гүйцэтгэлтэйгээ явбал бас нэлээн өгсчихнө. Хамгийн урт хугацаанд энэ зээлийн маргаан шийдэгдсэн маргаан 16 жил 5 сар үргэлжилсэн маргаан байдаг. Энэ нь өөрөө эргээд нөгөө банкиг хямд эх үүсвэртэй, эх үүсвэрийг бусад бизнесийнхэн санал болгоход бас ийм төвөгтэй байдлууд байгаа. Тэгэхээр иргэний процессын хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, эвлэрүүлэн зуучлал, шүүхийн бус журмаар өр барагдуулах ч гэдэг юм уу маш олон энэ хууль эрх зүйн орчнуудыг бид нар яг цогц байдлаар нь шинэчилж

байж таны энэ зорилтыг дэмжиж ажиллах шаардлага байгаа юм аа.

Дээрээс нь та бас ил тод байдлын асуудлыг ярьж байгаа. Энэ дээр ч бас Улсын Их Хуралд тодорхой бодлого дэмжлэгээр хууль эрх зүйн орчныг нь бүрдүүлж өгсөн. Засгийн газрын бас хэрэгжилтүүд бас тодорхой “5ш” ажиллагааны хүрээнд бас шилэн, ил тод байдлыг бол дэмжих асуудал байгаа. Ингэж байж өөрөө эргээд тухайн секторын хувийн хэвшил төдийгүй иргэд олон нийт бас энэ төрийн төсвийн зарлага. Эргээд татвар төлөгчдийн бүрдүүлж байгаа хөрөнгийг хэрхэн, юунд зарцуулж байгаа юм бэ гэдэг дээр бас үр ашиг нэмэгдүүлэх. Энэ чиглэлдээ бас алхмууд хийгдээд явж байгаа. Тэгэхдээ энэ асуудлыг илүү их бодитой сайжруулах асуудал байгаа. Бид хэд ил тод болгоод шуугиад өнгөрөх би. Үүний зөв гаргалгаа, зөв менежментийг буцаагаад яаж сайжруулах вэ гэдэг асуудал бол дараа нь үе шаттай хийгдэх ёстой байгаа.

Тухайлбал Засгийн газрын тусгай сангийн хууль, эрх зүйн орчноо бид хэд эргэж харахаас өөр аргагүй байдалд байна гэдэг зүйлийг бас саяын тэр ил тод байдлуудыг ингээд харж байхад бол гарч ирж байна. Хамгийн чухал асуудал бол та соён гэгээрүүлэх асуудал байна. Өчигдөр ч гэсэн Улсын Их Хурал дээр явж байгаа боловсролын реформ гэдэг бол бас энэ соён гэгээрүүлэх, иргэдийг зөв хүмүүжүүл ёс суртахуунтай буюу бусдад төвөг уддаггүй яг энэ хүний эрхийг дээдэлдэг бас шударга ёсны мэдрэмжтэй ийм иргэдийг төлөвшүүлэхэд л энэ манай боловсролын зорилго бас чиглэж байна гэж шинэ реформыг бас харж байгаа. Мэдээж юу гэдэг юм зөвхөн боловсрол гэхгүйгээр бид хэд ёс суртахуунтай иргэний гэр бүлийн орчинд яаж бий болгох вэ, бусад институц буюу магадгүй шашины институц, бусад олон нийтийн институцийг дэмжлэгтэйгээр, нийгмийн ёс суртахуун буюу нийтлэг энэ ёс

суртахууныг яаж бэхжүүлэх вэ гэдэг асуудал байгаа. Бүх зүйлийг хуульчлан хязгаарлаж хариуцлага тооцох юм бол бид юунд ч хүрэхгүй.

Тийм учраас яг таны хэлж байгаа шиг энэ ухамсар, эрх зүйн зөв соёл, ёс суртахуун гэдэг зүйлүүдийг бас багаас нь суулгаж өгч байж бас авлигатай үр нөлөөтэй тэмцэнэ. Зөвхөн авлига гэхгүй бүх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж бид чадна гэдэг л зүйлийг бас танд хэлмээр байна аа.

Г.Занданишатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ж.Батжаргал: Тэр заяагдмал баялаг дээр тулгуурлагдсан аж ахуй зохион байгуулалтын байгууллагуудын ил тод байдал, хяналт оролцоог нэмэгдүүлэх асуудал дээр бид онцгой анхаарах ёстой юм байна лээ. Оролцоогүй олон нийтийн засаглал үүсгэж таарахгүй. Тийм учраас би бол аливаа юм ер нь хяналтын багц нь байхгүйгээр үнэд ордоггүй гэдгийг бас хараад байгаа. Тухайн аж ахуйн байгууллагын 34%-аас доошгүйг нь үнэт цаас болгож гаргахгүй бол тэр үнэт цаасны үнэ цэн алдагдаад болж өгөхгүй байгаад байгаа. Санаатайгаар бараг үнэгүйдүүлээд ч байгаа юм шиг ийм зүйл харагдаад болохгүй юм. Тийм учраас энэ хөтөлбөр агуулга юмандаа бид бас нэг үзэл баримтлалаа их тодорхой болгож оруулж байж энэ ажлын үр дүн юмнууд нэлээн тодорхой гарах ёстой. Энэ талаас нь асуудалдаа хандаж ажиллах ёстой гэж ингэж ойлгоод байна. Дээр нь энэ Их хурлын гишүүд чинь төрийн албан.../минут дуусав/

Г.Занданишатар: Пүрэвжавын Сайнзориг Төрийн нарийн бичгийн дарга хариулна. 81.

П.Сайнзориг: Байгалийн баялагтай холбоотойгоор энэ менежментийг эргэж харах ёстой гэдэг дээр бол 100 хувь санал

нэг, энэ дээр ч бас тодорхой зорилтууд орсон байна. Түүрх Мөнх-Оргил гишүүн бас асуудлыг хөндсөн. Ер нь бол энэ Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглалыг ил тод болгох. Засаглалыг ил тод болгохын зэрэгцээ нөгөө ур чадвартай буюу яг менежментийг авч явдаг, үүнийхээ төлөө урамшуулал авдаг, эсвэл алдаа гарвал хариуцлага хүлээх энэ эрх зүйн орчин бол зайлишгүй шаардлагатай байгаа. Зөвхөн төрийн өмчит компаниудтай холбоогүй. Хувийн хэвшил ч гэсэн энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа бол Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийг бас Засгийн газраас тун удахгүй энэ хөтөлбөртэйгөө нийцүүлээд өргөн барих гэж байгаа. Дээрээс нь ингээд Уул уурхайн биржийн тухай хууль тун удахгүй бас хэрэгжилт нь хангаад явна. Тэгэхээр бид хэд энэ байгалийн баялгийг зохистой эдийн засгийн эргэлтэд оруулж үүний үр өгөөж ард түмэндээ явдаг. Үүнийг дагасан юу гэдэг юм хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх бодлого механизм бас уялдаж явна гэдэгтэй бол санал нэг байна. Энэ дээр бас тодорхой зорилтууд орсон.../минут дуусав/

Г.Занданишатар: Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Авлигатай тэмцэх үйл ажиллагаа бол их өргөн хүрээтэй ойлголт. Зөвхөн авлигын гэмт хэрэгтэй тэмцэх гэдэг юм уу авлигын гэмт хэргийг мөрдөх асуудал бол огт биш. Түүнээс гадна соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, улс төрийн хүсэл зориг, манлайлал, тэгээд төрийн бүх шатын байгууллагуудын үүрэг оролцоо, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын оролцоо гээд их олон зүйлүүдээс хамаарна. Мөн иргэд, иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлчдийн оролцоо ч их өндөр байдаг. Ийм учраас энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалтад бол бас анхаарал хандуулах ёстой гэж би бодоод байгаа юм. Ер нь бол энэ

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр бол их үр дүнтэй хэрэгжиж байгаа. 2002 онд анх удаа батлагдан гарсан. Улсын Их Хурлын дэд даргын дэргэд Ажлын алба нь анх 2 хүнтэй байгуулагдаад, одоо бол Авлигатай тэмцэх газар болтлоо өргөжөөд явж байгаа. Авлигатай тэмцэх ажлын зохион байгуулалт дээр орон нутагт энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой субъект их чухал. Тэгэхгүй бол нөгөө хуулийн хэлтэст хариуцуулдаг. Хуулийн хэлтсийн мэргэжилтэн давхар хариуцаад яваад байдаг. Ийм учраас энэ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж гэдэг юм уу, тодорхой субъектийг бол энэ үндэсний хөтөлбөрт тодорхой зааж өгсөн үү. Хэн хариуцаж, хэрхэн тайлагнаж байх юм, ямар үйл ажиллагаа явуулж байх энэ чиглэлийг нь тогтоож өгсөн үү гэдгийг асууя.

Нөгөөтээгүүр энэ сая өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжилт үр дүн нь бас сайн байхад бол Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх энэ ажлын албатай ажилласан шүү дээ. Энэ их чухал гэж би бодоод байгаа юм. Энэ ажлын алба бол цаашид үргэлжилж ажиллах уу. Энэ асуудлыг бас энд тусгасан уу. Яагаад гэвэл төрийн, бүх шатны байгууллагууд, орон нутгийн байгууллагууд, иргэний нийгмийн оролцоотой төрийн бус байгууллагуудыг бүгдийг нь нэгтгэж зангиддаг, энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг, түүний хэрэгжилтийг тайлагнадаг мөн Улсын Их Хурал, Хууль зүйн байнгын хороонд тайлагнах учиртай. Энэ хэдий хугацаанд тайлагнах вэ. Тайлагнах процесс нь бас явах юм. Энэ зүйлүүд маань энэ хөтөлбөрт маань хэр тодорхой сууж өгсөн бол гэдэг зүйлийг асууя. Ер нь бол цаашид энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг бол хэрэгжүүлэх тодорхой субъектүүдийг бол төрийн бүх шатын байгууллагуудад бас байх ёстой л гэж би бодож байгаа юм. Тэгж байж энэ авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг үл

тэвчих уур амьсгалыг бий болгох, энэ чиглэлээр соён гэгээрүүлэх ажил нь түлхүү явахад бол их дөхөм болно гэж бодож байгаа. Энэ чиглэлээр Үндэсний хөтөлбөрт ямархуу зүйлүүд тусгагдав. Тэр дотроо орон нутагт энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах вэ гэдэг асуудлыг асууя.

Г.Занданшатар: 82. Дуламсүрэн Үндэсний хөтөлбөр хариуцсан эрхэлсэн комиссар.

Д.Дуламсүрэн: Мөнхбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үндэсний хөтөлбөрийн хувьд бол зөвхөн нөгөө Авлигатай тэмцэх газрын хийж зохион байгуулах ажил бол биш гэдгийг хүмүүс угаасаа мэдэж байгаа. Энд бол иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд, бүх төрийн байгууллага, орон нутаг гээд өргөн хүрээг ингэж хамардаг. Тэгэхээр үүний хэрэгжилтийг зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлан гаргаж нэгтгэх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд мөн тайлан мэдээллийг хүргүүлэх гэсэн ийм ажлуудыг бол ажлын алба хэрэгжүүлж ирсэн. Тэгэхээр одоогийн нөхцөл байдлын хувьд бол Авлигатай тэмцэх газар бол орон нутагт бүтцийн нэгж салбар бол байхгүй. Зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр үндэсний хөтөлбөр дээр бол Авлигатай тэмцэх газрын салбарыг орон нутагт байгуулах ажлыг бол шат дараатай хэрэгжүүлнэ гэсэн ийм байдлаар тусгасан байгаа. Зохион байгуулалтын шинжтэй асуудлуудыг бол өмнө нь хэрэгжүүлж байсан ажлын алба бол үргэлжлүүлээд хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд Үндэсний хөтөлбөрийн төсөлд мөн энэ зохион байгуулалтын шинжтэй орон нутаг хэрэгжүүлэгч байгууллагууд тайлангаа хэдий ямар хугацаанд, яаж, хаана хүргүүлэх вэ. Тайлан маягт ямар байх юм. Үндэсний хөтөлбөрийн цахим санг бас байгуулаад бид нар хөгжүүлж

байгаа. Энэ цахим сантай холбоотой асуудал дээр бас энэ орон нутгийн болон төрийн байгууллагуудын асуудал хариуцсан хүмүүс хэрхэн яаж уялдаа холбоотой ажиллах юм бэ энэ тэр гэдэг байдлыг бол тусгаж болно. Зүгээр Үндэсний хөтөлбөрийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд энэ шаардлагатай асуудлаар холбогдох арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудын удирдлагуудад даалгасан байгаа. Энийг нарийвчлан тусгаад үндэсний хөтөлбөрийн төслийн төгсгөл дээр нь бас зохион байгуулалтын шинжтэй асуудлуудыг тусгаж болно.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулт хариултын цаг дууссан учраас санал хураалт дараа нь явуулна. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Ширнэнбандийн Адьяаа гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр, Нямаагийн Энхболд гишүүд үг хэлнэ. Содномын Чинзориг гишүүн байна.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэнгийн урилгаар Баянхонгор аймгийн Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1991 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төгсөлтийнхөө гэгээн дурсамжийг хуваалцаж эргэн дурсахуй уулзалт хийж байгаа та бүхэнд төрөлх сургууль, ачит багш, эх нутгаа эргэн санасан энэ сайхан уулзалтын өдрийн мэндийг өргөн дэвшүүлээд сайн сайхныг хүсэн ерөөе.

Содномын Чинзориг гишүүнээр тасаллаа. Ширнэнбандийн Адьяаа гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлнэ.

Ш.Адьяаа: Өнөөдөр Улсын Их Хурал Авлигатай тэмцэх хөтөлбөрийг бид хэлэлцэж байна. Авлигатай тэмцэх асуудал сүүлийн жилүүдэд бас олны анхааралд орж, энэ авлига гэдэг хорт зуриллаас Монголын нийгмийг, Монголын

төрийг эрүүл байлгахын төлөө Засгийн газар, Авлигатай тэмцэх газраас бас тодорхой ажлуудыг хийж, тодорхой үр дүнд хүрсэн гэдгийг үгүйсгэхгүй байна. Гэхдээ өнөөдөр энэ хөтөлбөрөөс ингээд харж байхад энэ хөтөлбөрийн зарим заалтууд Монгол улсын батлагдсан хуулиудтай зөрчилдсөн асуудал байна. Бид нар хэдхэн сарын өмнө Монгол Улсын төрийн албаны ёс зүйн тухай хуулийг баталсан. Авлигатай тэмцэх асуудал бол Монголын төр иргэн бүрийн үүрэг, төрийн хууль хүчний байгууллагын үүрэг гэдэг санал нэг байгаа. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд 200 гаруй мянган төрийн албан хаагч байна. Авлигатай тэмцэх газарт хөрөнгө орлогоо мэдүүлдэг 100 мянга орчим төрийн албан хаагч байдаг юм шиг байгаа юм. Би буруу ч юм ярьж байж магадгүй тэр судалгааг. Энд зарлагаа мэдүүлнэ гэдэг нэг асуудал орж ирсэн байна. Тэр төрийн албаны ёс зүйн тухай хууль дээр бид энэ асуудлыг яриад, бас энэ дээр тодорхой шийдэлд хүрч байсан. Энэ зарлагаа мэдүүлнэ гэдэг чинь тодорхой хэмжээ байх юм уу. Энэ 200 мянган хүн чинь өнөөдөр хоол идсэн, буудалд хоносон, тамхи авч татсан гэдэг энэ асуудлууд мэдүүлэх ийм шаардлага энэ хууль, эрх зүйн бодлогын бичиг баримтаар шийдэгдэх юм уу гэдэг асуудлыг бас өнөөдөр энэ хэлэлцүүлгийн явцад бид ярьж шийдэх ёстой шүү. Ийм байдлаар асуудалд хандаад хэтэрхий нарийн гэх юм уу, хэтэрхий ийм байдлаар энэ 200 мянган төрийн албан хаагчийнхаа зарлага мэдүүлнэ гээд асуудал дээр яг хэмжээ тогтоох юм уу. Хэдий хэмжээний зарлага гаргавал энийг мэдүүлнэ. Тэрнээс биш аяга таваг хоол, нэг тамхи авч татаад тэрийгээ өдөр бүхэн мэдүүлээд байх юм бол энэ чинь ер нь биелэгдэхэд ямар байх вэ гэдэг дээр бас энэ дараагийн хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурал, Засгийн газар, манай энэ Авлигатай тэмцэх байгууллагын хууль хүчний байгууллага энэ дээр бас анхаарах ёстой шүү. Анхаарах ёстой. Бид бол энийг ингэж шийдэхгүй бол өнөөдөр олон асуудал дээр олон юм

шийдэгдээд байгаа шүү дээ. Эрүүгийн хуулийн 22 гээд материаллаг хохирол шаардахгүйгээр олон асуудал дээр олон хүн гэмт хэрэгт татагдах ийм хууль, эрх зүйн орчин хүртэл өнөөдөр байдаг. Үүнийг ч хүртэл бид засаж, залруулахын төлөө явах ёстой. Бид нийгмийг эрүүл байлгах, авлигагүй байлгах, төрд итгэх итгэлийн төлөө бүгд хамтарч ажиллах ёстой. Энэ дээр санал нэг байна. Тэгэхдээ ингэж бүгд ийм байдлаар явбал яах вэ гэдэг дээр бас Засгийн газар энэ төсөл хөтөлбөрийг оруулж ирж байгаа хүмүүс, Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ дээр анхаарч ажиллах ийм шаардлагатай байгаа учраас би ийм байр суурийг илэрхийлж байна. Энэ байр сууриа бас энэ Төрийн албаны ёс зүйн тухай хуулийг бид хэдхэн сарын өмнө баталсан. Энэ Төрийн албаны ёс зүйн тухай хууль дээр үндэслэгдэн өнөөдөр энэ төсөл хөтөлбөрүүд явагдах ёстой. Хуультай зөрчилдсөн, агуулгын хувьд хэлбэржсэн ийм төсөл хөтөлбөрүүд явагдана гэвэл үр дагавар нь, цаашид хэрэгжих бодлого нь олон асуудал дагуулж өнөөдөр маш олон маргаан, олон шийдэл, олон буруу зөрүү зүйл гарна шүү гэдгийг би зориуд анхааруулж хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Авлигатай тэмцэх хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан. Тийм учраас бид авлигатай тэмцэх ирэх 7, 8 жилийн хугацаанд дагаж мөрдөх Үндэсний хөтөлбөрийг бол батлахаар өнөөдөр ярьж байна. Энэ бол бас гэнэт орж ирээгүй ээ. Сүлийн 1, 2 жилийн хугацаанд Авлигатай тэмцэх газар санаачлаад 40 гаруй хүнтэй ажлын хэсэг байгуулаад иргэдийн нийгэм, судлаачид, Засгийн газрын байгууллагын бүх төлөөллийг оролцуулсан ийм том ажлын хэсгийн бүтэн жил гаруйн судалгаа, шинжилгээ ийм тооцооллын үндсэн дээр гарч ирсэн ийм бодлогын баримт бичиг байгаа. Энэ бодлогын баримт бичгийг Улсын Их Хурлын дарга энэ хаврын

чуулганыг бол нээлтдээ хэлсэн. Энэ удаагийн чуулган бол авлигатай тэмцэх чуулган болно гэдэг энэ зүйлийг хэлсэн. Дөнгөж сая бид нийтийн Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуульд маш том хэмжээний өөрчлөлт оруулахаар эхний хэлэлцүүлгийг нь хийлээ. Одоо бид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэлэлцэх эсэх асуудлыг бас шийдэх гэж байна. Чуулган маань хаахад бас 2 7 хоногийн хугацаа үндсэндээ үлдэж байгаа. Тийм учраас энэ хөтөлбөрийг бол Улсын Их Хурал энэ манлайллаа үзүүлж, шуурхай хэлэлцэн батална. Энэ бодлогын баримт бичгүүд дээр зөвхөн Засгийн газраас, Авлигатай тэмцэх газраас боловсруулсан гэж ийм хөтөлбөр биш Улсын Их Хурлын дарга бас энэ асуудал дээр төсөл боловсруулахаас нь эхлээд бас анхаарал хандуулж, хамт оролцож, манлайлж ингэж явж байгаа хөтөлбөрүүдийг би бас Хууль зүйн байнгын хорооны даргын хувьд зориуд хэлье. Маш өргөн хүрээтэй хөтөлбөр. Энэ ирэх 7 хоногийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар 2 дахь өдөр анхны хэлэлцүүлгийг нь хийнэ. Анхны хэлэлцүүлгийг нь. Тийм учраас гишүүд тодорхой санал байвал Байнгын хороонд шууд саналаа ирүүлээрэй гэдгийг би хэлж байгаа юм. Тодорхой саналууд байвал. Энэ хэлэлцэх эсэх асуудлыг шийдэж байгаа хуралдаанд хэлж байгаа гишүүдийн саналыг бол бас тусгаж хүлээж авч томъёолно. Түрүүн Мөнх-Оргил гишүүн, Батжаргал гишүүн, олон гишүүд бас их тодорхой саналууд гаргаж байгаа юм. Ялангуяа тэр төр нь хувийн хэвшилтэйгээ өрсөлдөхгүй байх, өрсөлдөхгүй байх. Шинээр аж ахуйн нэгжүүдийг байгуулж, хувийн хэшилээ боомилдог, данхайдаг энэ асуудал бол гол авлигын хүнд суртлын үндсэн шалтгаан байгаа. Энэ дээр бас тодорхой саналууд, томъёоллуудыг бас хэлэлцүүлгийн шатанд оруулъя гэж ингэж бодож байгаа. Тийм учраас Үндсэн хуулийн үзэл баримтлалд бид нийцүүлж аливаа асуудлуудаа ярих ёстой. Тэр хүрээнд бол бас Улсын Их Хурал хэлэлцэх эсэх асуудлыг нь шийдсэний дараа өнөөдөр

бас ажлын дэд хэсэг дээр нэлээн тодорхой бас дахиж ярилцаж, боловсронгуй болох дээр ажиллана гэсэн ийм байр суурьтай байгаа. Тийм учраас гишүүд маань тодорхой саналуудаа Хууль зүйн байнгын хороонд өнөөдөр үдээс хойш багтаагаад ирүүлбэл их сайн байна гэдгийг хэлье.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалангийн урилгаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны, Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Алтайчууд та бүхэндээ эргэн дурсахуйн уулзалт, гэгээн дурсамж, төрөлх сургууль, ачит багш нараа эргэн дурссан уулзалтын өдрийн мэндчилгээ дэвшүүлээд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Нямаагийн Энхболд гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдах тул гишүүд чуулганы танхимд цуглана уу. Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

Н.Энхболд: Баярлалаа дарга аа. Энэ хөтөлбөрийн хэлэлцэх асуудлыг дэмжиж байна. Тэгээд бид нарт бас бодох юм байна. Яг энэ хэлэлцэж байгаа цаг үе маань ийм их онцлог таарлаа. Хулгай зэлгий, авлига, хээл хахууль нүүрлэсэн. Нийгмийн хамгийн их шүүж хэлэлцэж байгаа, ингэхдээ яаж яллах вэ, яаж шийдэх вэ, яаж шоронд хийх вэ гэдэг бодол санаа нь давамгайлсан нэг ийм уур амьсгалтай үед л яг бид нар энэ асуудлыг хэлэлцэж байна. Ийм уур амьсгал байхаас ч өөр аргагүй нэг ийм байдалд хүрчхээд, үүнийгээ ярихаас өөр аргагүй байдалд ороод байна шүү дээ. Гэхдээ бидэнд бол энд бас бодолцох юм байна. Би бол хэлэлцэхийг нь дэмжинэ. Дотор нь саналаа өгнө. Гэр доторх юмаа ярьж байгаад, гэрээ яаж бүтэн байлгах вэ гэдэг юмаа бас мартчих вий дээ гэдэг

дээр бас бид нар бүгдээрээ анхаарах ёстой. Хэт ийм уур амьсгалд автаад, нэг тал руугаа хэлтийсэн ийм агуулгатай хөтөлбөр бол дараа дараагийн хуулиуд, бусад үйл ажиллагаанд бас үүнээсээ дутуугүй зарим муу үр дагавар авчрах зүйлүүд гарах вий дээ гэж бас болгоомжилж байна. Энийг Хууль зүйн байнгын хороо өөр дээрээ ярихдаа бас анхаарна биз дээ.

Сая Энхбаяр дарга ч хэллээ. Үндсэн хуультай холбоотой асуудлууд байна. Хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, ялгаварлахгүй байдал энэ тэрийг харгалзсан Үндсэн хуулийн заалтууд зөрчигдсөн юмнууд энэ дотор байх вий. Ерөөсөө гэмт хэрэг, түүнд ноогдуулдаг ял шийтгэлийн тухай зохицуулалтууд хоорондоо их зөв уялдаатай, зохистой байж байж үр дүн сайн байдаг шүү дээ. Энэ тухай бүр нийтлэг зарчим, тогтсон хүлээн зөвшөөрөгдсөн практик ийм зүйлүүд байдаг. Энэ уялдаануудыг их сайн авч хэлэлцэж байх хэрэгтэй. Яг энэ дотор байгаа зүйлүүдээс гадна түрүүн бас нэг гишүүн хэлж байна. Энэ соён гэгээрүүлэх ажил, авлига, хээл хахууль, хулгай зэргийг үл тэвчих, энэ уур амьсгалыг чиглэсэн их тодорхой заалтууд баймаар байна. Тэгэхгүй бол энэ дотор байгаа ихэнх зүйлүүд нь яаж шийдэх вэ, яаж торгох вэ, яаж гэсэн юмнууд давамгайлчхаад, тэр харьцаа алдагдаад ирвэл дахиад миний санаа зовж байгаа Үндсэн хууль, бусад хуулиудтай зөрчилдөх юмнууд орчихвол өөрөө их буруу зүйл болох юм шүү гэж бодож байна. Нэг тийм үзэн ядалт, тамын тогооны тухай яриа байдаг шүү дээ. Тийм зүйлүүдэд тулгуурласан биш, яавал бүгдээрээ тэгш, зөв байх вэ, хөгжих вэ, дэвших вэ, ахих тэмүүлэх байх вэ, яавал ийм зүйлийг гаргахгүйд зөвхөн төрийн өндөр албан тушаалтнууд биш, нийгмээрээ зөв оролцож байх вэ гэдэг энэ зүйлүүдийг тусгасан ийм заалтууд орвол их сайн байгаа шүү. Жишээ нь ганц, 2 яг тодорхой заалтууд байна. Жишээ нь 1.5.2 гээд заалт байгаа. Энэ бол бид

нарын заавал бодох ёстой заалт. Тэгээд ялангуяа би энийг Төрийн байгуулалтын байнгын хороо дээр даргын хувьд их анхаарах ёстой зүйл гэж бодож байна. Цаана нь ямар санаа байгааг эндээс харагдахгүй байна. Гэхдээ жишээ нь Улсын Их Хурлын гишүүний өгсөн саналыг батлагдсан бодлого, шийдвэртэй уялдуулж хянаж байна гэж байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ Энхбаяр дарга аа, 1.5.2 гэдэг заалт байна. Их Хурлын гишүүний өгсөн саналыг батлагдсан бодлого шийдвэртэй уялдуулж хянана гэж байна. Энэ юу гэсэн үг вэ. Хэний батлагдсан бодлого, шийдвэртэй уялдуулах юм,. Гишүүд өөрснөө л гаргасан бодлого, шийдвэртэй уялдуулж л ярина шүү дээ. Байр сууриа чөлөөтэй илэрхийлж болно шүү дээ. Гэтэл хянана гэдэг үг байгаа нь энэ өөрөө энэ байж болох уу, үгүй юу. Энийг та нар Байнгын хороо дээрээ их анхаарал дээр авч хэлэлцээсэй гэж бодож байна. Дээр нь анхаармаар зүйлүүд бас байх юм. Жишээ нь энэ Хөгжлийн банктэй холбоотой явагдаж байгаа шүүх хурлын явцаас харахад хүмүүсийн аль аль талын байр сууриа илэрхийлж байгаа, ярьж байгаа зүйлүүдээс харахад энэ хамтын шийдвэр гаргадаг байгууллагуудын асуудлыг их ярьж байна. Улсын Их Хурал шийдвэр гаргачихсан байхад Их Хурлын даргыг ч юм уу, эс үгүй бол тэр шийдвэрийг дэмжсэн хүмүүсийг шийтгэж байгаатай, эс үгүй бол одоохондоо шийтгээгүй л байна л даа буруутгаад явж байна. Энэтэй адилхан уур амьсгалтай зүйлүүд энэ дотор чинь орчих вий дээ. ТУЗ, Засгийн газрын гаргасан шийдвэрүүдийг эс үгүй бол даргатай нь, эс үгүй бол хэсэг бүлэгтэй нь холбочихсон. Хэсэг нь үлдчихсэн. Нэг хэсэг нь ингээд буруутгагдаад. Дахиад хэлье одоохондоо шийтгэгдээгүй байна. Тэгэхдээ энэ уур амьсгал ер нь эс үгүй бол ийм практик зөв үү, үгүй юу. Энэ нарийн зүйлүүдийг багтсан тал талаас нь харсан юм байхгүй бол дахиад хэлэхэд хэтэрхий нэг талын уур амьсгалд автагдсан.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэнэ. Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор, Бямбацогт сайд суудалдаа суу, санал хураалт явуулъя. 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

Сая манай Хууль зүйн байнгын хорооны дарга бас энэ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг цаг хугацаанд нь шуурхай, бас тэгэхдээ чанартай хэлэлцэж батлах талаар улс төрийн хүсэл зоригоо илэрхийллээ. Энэ авлигатай тэмцэх асуудал бол бүх нийтийн үйлс хэрэг юм. Тэгээд энэ хөтөлбөрийн эхний зорилт ч гэсэн авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайллыг улс төрийн хүрээнд төлөвшүүлэх явдал бол тэргүүн зорилт болохоор тунхагласан. Одоогоос 2 жилийн өмнө авлигатай тэмцэх үндэсний чуулганыг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан. 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр болсон энэ чуулганаар авлига бол улс орны аюулгүй байдалд заналхийлж, ардчилсан тогтолцоо, үнэт зүйлсийг доройтуулж, хөгжлийг сааруулж, төрд итгэх иргэдийн итгэлийг алдагдуулж байгаа ийм хорт үзэгдэл болж байна. Ийм учраас энэ хорт үзэгдэл, үйл явдалтай бүх нийтээрээ тэмцэх итгэл үнэмшил, оролцоог дэмжлэг, хяналтыг нийт нийгэмд чухал болох, бий болгох нь чухал байгаа талаар, түүнчлэн авлигын барьцааг иргэд ирээдүйгээрээ, улс орон хөгжил дэвшлийн боломжоороо төлж байгааг илэрхийлж үг хэлж байсан би.

Манай улсад төрийн авлигын түвшин олигтой буурахгүй байна гэж авлигын индекс зааж байгаа. Авлигын байдлыг хүн амын тоонд харьцуулсан судалгаагаар дээгүүр барьж жагссан хэвээрээ байгаа. Ийм учраас энэ авлигатай тэмцэх индексийн зүйл, заалт, шалгуур үзүүлэлт болгоноор тодорхой зорилго зорилт, тоон утгаар нь болон чанарын утгаар нь тавьж, тэгээд энэ авлигатай тэмцэх тэмцлийг бүх шатанд өрнүүлж төрийг авлигаас бүрэн ангид байлгах, бизнесийн болон өрсөлдөөний шударга орчныг бүрдүүлэх, авлигачдад хуулийн дарангуйлал тогтоох хэрэгтэй гэж үзсэн. Ингэж байж иргэдийн төрд итгэх итгэлийг сэргээнэ ээ.

Ийм учраас аливаа зүйлийг тэгшилэхийн тулд хэтрүүлж нугалах хэрэгтэй гэдэг нийгмийн энэ итгэл үнэмшил, авлигын байдал ингэж хэтэрчихсэн байгаа учраас нөгөө тийш нь хэтрүүлж, нугалж байж л энийг засна. Ийм ч учраас энэ 2023 оны хаврын ээлжит чуулганыг бүхэлдээ авлигатай тэмцэх хууль, эрх зүйн орчныг сайжруулах чуулган болохоор зарласан. Авлигын эсрэг чуулган болох ёстой. Энийг ард түмэн хүсэж байгаа учраас ард түмний төлөөлөгчдийн байгууллага манлайлах ёстой. Энэ ч утгаараа өчигдөр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулж, Төрийн өндөр албан тушаалтнууд хамаарал бүхий этгээдүүд авлигын эсрэг асуудалд манлайлал үзүүлэх агуулгатай эрх зүйн зохицуулалтыг батлахаар ажиллаж байна. Эхний хэлэлцүүлгээ дуусчихлаа. Ирэх 7 хоногт батална. Энэ асуудлыг саармагжуулж болохгүй, харин ч хүрээг нь өргөжүүлж чангатгах хэрэгтэй. Энэ бол Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндсэн шалгуур байх болно. Ерөөсөө төрд түмнээ төлөөлөх гэж байгаа хүн аливаа бизнесийн ашиг сонирхлоос ангид байх, хамаарал бүхий этгээдүүд нь төрд ажилладаггүй байх энэ зарчмыг бол хатуу суулгах нь зүйтэй.

Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарах ёстой. Ер нь энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2016 онд батлахдаа энэ төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, нийт мэргэжил сонирхлын бүлгүүдийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 6 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн. 2016 онд батлаад. Одоо энэ авлигын үзүүлэлт сайнгүй байгаа учраас иргэд, олон нийтийн хийгээд хөндлөнгийн судалгааны байгууллагууд олон нийтийн зүгээс шүүмжилж байна. Ийм учраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төсөлтэй холбогдуулж Авлигатай тэмцэх газар нийт 12 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, Олон улсын байгууллага, иргэдийг оролцуулж 250 орчим санал шүүмжлэл хүлээн авч төсөлд тусгасан нь сайшаалтай байна. Энэ утгаараа “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” бол бүх талыг хамарсан, маш сайн боловсрогдсон төсөл болсон гэж үзэж байна. Энэ дотор төсөвт төрийн мөнгөнд тавих хяналт шалгалтыг сайжруулахаас авлаад тэр тендер, хулгай, төсөв, төрийн өмчийн компаниуд, хулгай байгаа бүх газруудад энэ ил тод, нээлттэй байдлыг бий болгож, ард иргэдийн хяналтыг бий болгож ингэж авлигатай тэмцэх асуудлыг бүх нийтийн үйл үүрэг болгож байгаа нь сайн хэрэг. Энэ бол зөвхөн Авлигатай тэмцэх газрын асуудал биш, дижитал цахим болгохоос авхуулаад төрийн өмчийн бүх компаниуд Засгийн газар, яамдын бүх түвшинд нэн ялангуяа гүйцэтгэх засаглалын түвшинд энэ авлигатай тэмцэх хэргийг манлайлж ажиллах хэрэгтэй. Улсын Их Хурал бол энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг батлаад 2021 оноос хойш Хөгжлийн банк, нүүрсний хулгай гэх мэт олон асуудлаар шүгэл үлээж, иргэд, олон нийтэд анхаарлын төвд оруулж,

манлайлал үзүүлж ажиллаж байгаа шүү. Манай Хууль зүйн байнгын хорооны дарга, Хууль зүйн байнгын хороо бол энэ талаар маш санаачилгатай ажиллаж байгаа гэж хэлж болно. Нээлттэй сонсголыг ч гэсэн зохион байгуулж байгаа.

Ингээд эцэст нь хэлэхэд хөтөлбөрийн төсөлтэй холбогдуулж Улсын Их Хурлын гишүүд саналаа өнөөдрөөс эхлэн өгч энийгээ бодитой тусгаад, ирэх 7 хоногт хэлэлцээж батлахыг Хууль зүйн байнгын хорооны ажлын хэсэгт чиглэл болгож байна. Ингээд Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ. Шуурхай чанартай хэлэлцье ээ.

/11.34 цаг/

Дараагийн асуудалд орно.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Өчигдөр буюу 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдөр уг асуудлаар мөн нийгмийн даатгалын багц хуулиуд дээр Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн өнөөдрийн 10 цаг хүртэл завсарлага авсан байна. Завсарлагын хугацаа дууссан байна. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж үг хэлэх үү. Үг хэлэхгүй. Ингэхээр хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Анужин танилцуулна. Анужин гишүүнийг индэрт урьж байна.

П.Анужин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 27 дугаар захирамжаар хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Анужинаар ахлуулан байгуулж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Батжаргал, Ганбаатар, Доржханд, Жаргалмаа, Мөнх-Оргил, Идэрбат, Оюунчимэг, Сандаг-Очир, Саранчимэг, Туваан, Чинзориг нарын гишүүд ажилласан болно.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд, Ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж

байгаа ажилтан зөвхөн тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд хамрагдахаар, үндсэн ажлын хажуугаар зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр болон ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан зөвхөн тэтгэврийн даатгалд хамрагдахаар,

2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч болон даатгуулагчийг төлөөлсөн гишүүнд нэр дэвшүүлэх эрх бүхий байгууллага нь нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлэхээр, Байнгын хороо нэр дэвшигчийн нээлттэй сонсгол хийж, тухайн албан тушаалд нэр дэвшигчийг туршилага, ур чадварын хувьд тэнцэх эсэх талаар санал, дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд танилцуулахаар,

3.Хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тэтгэвэрт гарч байгаа даатгуулагчийн нөхцөлийг хэвээр үлдээхээр, хөдөлмөрийн хорттой халуун нөхцөл болон газрын доор ажиллаж байгаа даатгуулагчийн тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэхгүй байхаар,

4.2018 оноос дараалсан 6 болон 7 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан нэг удаа шинэчлэн тогтоохоор тусгалаа.

Ажлын хэсгээс Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 21 санал, найруулгын шинжтэй 2 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 10 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их

Хурлын гишүүн Содномын Чинзориг Монгол Улс хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын цаашидаа бүрэн хуримтлалын тогтолцоонд хэзээ шилжих, хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн ачаалал болон нийгмийн даатгалын сангийн зардал хэрхэн нэмэгдэх, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах олон нийтийн хяналтын зөвлөл байх шаардлагатай эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа цагийн ажилтан ажиллуулахад ажил олгогч заавал нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөр байгааг хэрхэн зохицуулах талаар асуулт асууж, хариулт авлаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эн эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай

хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Амарсайханы

Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Баасангийн Батжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга, Бумчангийн Даваахүү Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү, бүртгэлийн газрын дарга, Дугаржав Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Болдбаатарын Гэрэлсайхан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Сүхбаатарын Орхон Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, Гандангийн Ганчимэг судлаач, зөвлөх, Цогоогийн Дашдондог судлаач, зөвлөх.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг Эрүүл мэндийн сайд асуулт асууна.

С.Чинзориг: Би нийгмийн даатгалын салбарт өөрөө ажиллаж байсан хүний хувьд бол шинэчлэлийн бодлого нь яваасай гэсэн ийм бас чин хүсэл бол байгаа юм. Гэхдээ бас дотор нь бол эргэлзээтэй хэд хэдэн асуудлууд байгаа юм. Одоо энийг бид бид нар хэлэлцүүлгийн явцад яаж шийдэх юм. Олон жил яригдаж байгаа нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудал. Хамгийн гол нь санхүүгийн эх үүсвэрийн асуудлаасаа болоод л ингээд л гацаад л яваад байдаг л даа. Тэгээд энэ хууль батлагдсанаар орлого нэмэгдүүлэх, зардал бууруулж байгаа тийм чиглэлийн асуудал байхгүй. Дандаа зарлага асар их хэмжээгээр нэмэгдэх ийм л хууль

болчихоод би өөртэйгөө жаахан зөрчилдөөд суугаад байх юм. Бид нар чинь хуваарилалтын тогтолцоотой явж байгаа юм. Тэгээд хэдэн оноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих юм бэ гэхээр 2040 оноос гэж байгаа юм. Тэгээд 2040 оноос цаашаагаа бид нар бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих тийм л тооцоотой байна гээд. Тэгээд хагас хуримтлалын тогтолцоонд орох, бүрэн хуримтлалын тогтолцоонд орохтой холбоотойгоор санхүүгийн тооцоо, хуримтлалын тооцоо, тэнцлийн тооцоо эд нар хийгдсэн юмнууд их багатай байгаад байгаа юм.

Тэгээд би хэлэх гээд байгаа 2, 3 зүйл л байна. Нэг дэх асуудал. Энэ зарлага маш их нэмэгдэж байгаа юм. Одоо чинь нөгөө 1995 оноос тэтгэвэрт гарсан иргэдийн санхүү, тэтгэвэр, санхүүжилт, цэргийнхний санхүүжилт гээд 560 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт авч байгаа, татаас авч байгаа. Энэ хууль батлагдсанаар сангийн 2%-ийг нь 400 орчим тэрбум төгрөг тусгаарлаж өгнө. Энэ жил бид нар чинь тэтгэвэр 390 орчмоор нэмж байгаа. Тэр чинь ирэх жил зардал болж ирнэ. Дээр нь нөгөө 7 жилийг 5 болгож байгаа, малчдын шимтгэл тэр тэтгэврийнх нь 20%-ийг нэгэнд нь олгох эд нар гээд ингээд байсаар байтал 150-аад тэрбум төгрөг нийтдээ бараг л ч зардал бол ирэх жил Нийгмийн даатгалын сангийн зарлага бараг л 1,4 их наядаар нэмэгдэхээр ийм тооцоолол байгаад байгаа юм. Миний баримжаагаар бол. Үндсэндээ төсөв дээр ирэх ачаалал нь 900 орчим тэрбум төгрөгөөр ачаалал нэмэгдэхээр ийм л юм болчихоод байгаа юм. Тэгээд энийг яаж тооцох вэ.

2 дахь асуудал нь тэр сангийн хуримтлал бий болгож байгаа гэдгийг нь бол би бол дэмжээд байгаа юм. Гэхдээ энэ хуримтлалаа тэр 2 хувийн хуримтлалаа яаж хуримтлуулах вэ гэдэг нь, хуримтлал хэзээнээс үүсэх вэ гэдэг нь тодорхой бус. Тэгээд энэ чинь бараг л ч хагас хуримтлалын тогтолцоонд 2030

онд ер нь цаашидаа бол 2040 онд л хагас хуримтлалын тогтолцоо шилжинэ гэж ярьж байгаа юм. Тэгээд 2 хувийг нь хуримтлуулах асуудал ярингуутаа зэрэгцээд Сингапурын туршилага гээд бүрэн хуримтлалын тогтолцоотой орны туршилага гээд ингээд баахан юм хуулаад тавьчихаад байх юм. Хий хүлээлт үүсгэчих гээд байгаа юм. 2 хувийг нь хуримтлуулаад, тэр мөнгөжүүлсэн орлогынхоо орлогоос эрүүл мэнд, боловсролын зардалд нь зарцуулж болно. Ипотекийн орон сууцныхаа зээлд нь зарцуулж болно, Тэтгэврийг нь өвлүүлж болно гээд хэзээ хэрэгжих нь тодорхойгүй, 2040 оноос нааш хэрэгжих боломжгүй юмнуудыг ингээд одоогийн хуульд оруулаад, тэгээд иргэдийн дунд бас л нэг баахан хий бухимдал үүсгээд, асар тийм хүлээлт үүсгээ, тэтгэвэр өвлөгдөх гэж байгаа юм шиг, орон сууцныхаа зээлд өгч болох юм шиг, эрүүл мэнд, боловсролынхоо зардалд зарцуулж болох юм шиг ийм хүлээлт үүсгээд ингээд иргэдийг дахиад маш их төөрөгдүүлээд ингээд бужигнуулчих ийм юм руу явчих гээд байгаа юм. Энэ юмнуудыг бас жаахан бас анхаарч харвал яасан юм бэ гэсэн.

Яах вэ хэлэлцүүлгийнхээ явцад энэ юмнуудыг жаахан харах хэрэгтэй байх. Тэгэхгүй бол ингээд иргэд чинь асар их хэмжээний хүлээлт үүсгээд ийм л юм руу явчих гээд байгаа юм. Тэгээд энэ зардлаа бас Сангийн яам юу гэж үзэж байгаа юм. Ер нь бол ирэх жилээс 1 их наядаар ер нь сангийн чинь зарлага нэмэгдэхээр байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ Сангийн яам нь юу гэж үзэж байгаа юм. Болно гэж байгаа юм уу. Тэр хүлээлт үүсгэчих юмнуудыг та бүхэн юу гэж үзээд байгаа юм. 2040 оноос нааш хэрэгжихгүй юмыг одоогийн хуульд бичиж, иргэдийг бас бухимдуулах хүлээлт.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин Байнгын хороон дарга.

П.Анужин: Чинзориг сайдын асуултад хариулъя. Чинзориг сайд 1 дүгээрт энэ салбарт маш удаан ажилласан, 2 дугаарт өөрөө ажлын хэсэгт орж ажилласан, 3 дугаарт энэ бол Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан хууль. Үүнийг би бас тодотгож хэлэхийг хүсэж байна. Ер нь таны хэлж байгаагчлан энэ төсвийн асуудал, төсвийн тооцоолол дээрээ Сангийн яамтайгаа Засгийн газартайгаа тодорхой хэлцэлд хүрч, шийдэлд хүрээгүй бол энэ хууль энэ хүртлээ хэлэлцэгдэхгүй байсан гэдгийг та бас маш сайн мэдэж байгаа. Монгол Улсын Засгийн газар эдийн засгийн өсөлттэйгөө уялдуулаад хамгийн түрүүнд хийж байгаа реформын шинж чанартай бодлогын уялдаа нь ерөөсөө л энэ Нийгмийн даатгалын багц хууль. Үүнийгээ ч бас Монгол Улсын Засгийн газар тодорхой хэлж тайлбарласан. Сая Монгол Улсын Их Хурлаар орсон төсвийн тодотголоор уг хуулийн багц хуулийн төсөвт нийт шаардлагатай 1,2 их наяд төгрөгийн тал орчим хувь нь 7 сарын 1-ээс авхуулаад хийгдэх бүрэн боломжтой. Үлдсэн төсвүүд хууль хэрэгжих үеэс авхуулаад шийдэгдэх бүрэн боломжтой талаар Сангийн яамтай бол нэгдсэн ийм ойлголцолд хүрсэн байгаа гэдгийг бас танд тодруулж хэлье.

Энэ 2044 он хүртэл үе шаттайгаар, эхлээд 2025 он хүртэл бид нар хагас хуримтлалын тогтолцоогоо бас хэрэгжүүлж, хууль хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор цаашидаа 2044 он гэхэд бол Монгол Улс бүрэн хуримтлалын тогтолцоо руугаа шилжинэ гэсэн ийм үе шатлалтай үе шатууд явж байгаа. Тэр сангийн орлого, зарлагыг нэмэгдүүлэх тал дээр манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хишигбаяр дарга тодруулаад хариу өгчих. Сангийн орлогыг нэмэгдүүлэх тал дээр хийсэн тооцоолол, хуулийн төсөл заагдсан зүйлүүдээ хариулаад явчих.

Г.Занданшатар: 83.

А.Хишигбаяр: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Хишигбаяр. Анх хуулийн төслийг бол боловсруулж байхад бид нар 2024 оноос хууль хэрэгжинэ гэж үзэх юм бол 1,2 их наядын зардал гарна гэсэн ийм байдлаар бол тооцож явж байсан. Өнөөдөр бол тэтгэврийн зөрүүг ойртуулах, тэтгэврийг нэмэгдүүлэх ажлыг 7 сарын 1-ээс эхлээд хэрэгжүүлэхтэй холбоотой энэ хуулийг 2024 оны 1 сарын 1-ээс хэрэгжүүлэхэд бол 560 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарна гэж үзэж байгаа. 560 тэрбум төгрөгийн нэмэлт зардлын 369 тэрбум нь бол 2 хувийг мөнгөжүүлэх асуудал дээр бол гарч байгаа. Бусад нь бол зүгээр үйл ажиллагааны зардал буюу Нийгмийн даатгалын ерөнхий газар өнөөдөр Нийгмийн даатгалын сангаа санхүүжүүлээд явдаг. Агентлагийн тухай хуульдаа нийцүүлэх юм бол улсын төсвөөс санхүүжүүлэх ёстой. Энэ зардал бол нэмэлтээр улсын төсөв дээр ирж гарч байгаа. Бусад нь бол яг мөнгөжүүлэх асуудалтай холбоотой зардал байгаа гэж үзэж байгаа. Энэ мөнгөжүүлэхтэй холбоотой 379 тэрбум төгрөгийн зардлыг бол Сангийн яамтайгаа бол тохиролцоод энэ бол цаашидаа бол ингэж хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шаттайгаа энийг бол хуримтлал болгоод явах нь зүйтэй гэсэн байдлаар бид ярилцаж бол тохиролцсон байгаа. Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх асуудлыг бид нар хуулийн гол бас зорилго болж явуулсан. Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх, даатгуулагчаа нийгмийн даатгалд хамруулах нь бол ирээдүйн нэгэн баталгааг алдагдуулахгүй байх гол асуудал байгаа учраас нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх хэд хэдэн заалтуудыг бол оруулж ирсэн байгаа. Тэр дээр бол ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа ажилгүй байгаа хүмүүсийг хэрхэн яаж хамралтыг нь нэмэгдүүлэх вэ гэх юм бол олон нийтэд бол нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлах асуудлыг бол тусгайлан

оруулж өгсөн байгаа. Нөгөө талаар бол өнөөдөр зайлшгүй шимтгэлээ төлж чадахгүй байгаа байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эцэг эхийн шимтгэлийг төрөөс бас төлдөг байх зэрэг зохицуулалтыг бол нэмж оруулсан байгаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Хишигбаяр дарга чуулганы танхимд орж ирээд ингээд гишүүдэд худлаа буруу мэдээлэл өгөөд байж болохгүй шүү дээ. Наад хэлээд байгаа тоо чинь худлаа тоо хэлээд байна шүү дээ чи зориуд дараад. Энэ жилийн тэтгэвэр нэмсэн чинь 7 сараас сүүлийн хагас жилд ирнэ. Ирэх жил наадах чинь 780 тэрбум болоод нэмэгдэж очно. Дээр нь нөгөө 7 жилээ 5 жил болгоно гээд 90 орчим тэрбум төгрөг, малчдын шимтгэл нөгөө тэтгэврийн 20 хувийг нь нэмэгдэл өгнө энэ тэр гээд наадуул чинь бол асар их хэмжээний зардал, бараг л 200, 300-аад тэрбум төгрөгийн зардал нэмэгдэхээр байгаа шүү дээ. Энэ бодитой нэмэгдлүүдээ хэлэхгүй, худлаа ингээд 300-хан тэрбум төгрөгийн нэмэгдэл, тэтгэврийн нэмэгдэл байгаа гэж ингээд илт худлаа хэлээд байж болохгүй. Ажлаа явуулах гээд байж болно. Гэхдээ бодитой мэдээлэл өгөхгүй, дараагаар нь энэ зардал чинь нэмэгдэх юм уу, үгүй юм уу. Төсөв дээр ирэх ачаалал нь яг бодитой үнэн үү, үгүй юу гэдэг үнэн бодитой тоог нь хэлэхгүй, худлаа хэт дараад тэгээд 300-хан тэрбум байгаад Байнгын хорооны даргадаа, гишүүдэд буруу мэдээлэл өгөөд байж болохгүй ээ Хишигбаяр аа.../минут дуусав/

Г.Занданшатар: 83 хариулъя. Чинзориг гишүүн бол нийгмийн даатгалын асуудлаар их туршилагатай гишүүн шүү. Энэ туршилагатай хүмүүсийнхээ үгийг сайн сонсох хэрэгтэй. Та сүүлд нь тэгээд тоо зөрвөл хариуцлага хүлээнэ шүү дээ. 300 тэрбум 1 их наяд гээд. Буруу мэдээлэл өгөөд л

хариуцлага хүлээгээд байна шүү дээ Их хурал дээр.

А.Хишигбаяр: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Тэтгэвэр бодох цалингийн 7 жилийг 5 жил болгохтой холбоотой заалтыг энэ хуулийн төсөл дээр бас оруулж ирж байгаа. Энэ хуулийн төсөл дээр бид нар бол өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг бол өөрчлөн тогтооно гэж хуулийн төсөл дээр орж байгаа болохоос нөхөж олгоно гэдэг заалт бол манай энэ хуулийн төсөл хууль дээр байхгүй байгаа. Энэтэй холбоотой зардал бол нөхөж олгоно гэж орж ирээгүй, тусгаагүй учраас энэ хууль дээр бол зардал бол гарахгүй гэж харж байгаа. Харин 2 гэр бүлийн тэтгэвэр авагч нэг нь нас барвал 20 хувийн тэтгэврийн нэмэгдлийг нь олгоно гэдэг энэ тооцоо дээр бол 7 тэрбум төгрөгийн нэмэлт зардал бол гарахаар ийм тооцоо судалгаа бол байгаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд нэмж хариулъя.

Х.Булгантуяа: Чинзориг сайд орлого нэмэх талдаа яах гэж байна вэ гээд. Үгүй ээ, орлого нэмэхэд ерөөсөө л хэдхэн л юм хөдлөх ёстой шүү дээ. Эс үгүй бол цалин нэмэгдэх ёстой, дундаж цалин нэмэгдэх ёстой, одоогийнхоос бүр онцгой их нэмэгдэх ёстой, эс үгүй бол хөдөлмөр эрхлээд нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүмүүс нэмэгдэх ёстой. Тэгээд эс үгүй бол нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэх ёстой. Нөгөө талдаа бид нар зарлагаа бууруулахын тулд төрөөс НДШ-ийг нь төлдөг. Цэрэг, 3 хүртэлх настай хүүхдээ харж байгаа ээж нарын нийгмийн даатгалын шимтгэл, төрийн тусгай зарим албан хаагчдын гэр бүлийн НДШ-ийг төрөөс даадаг ч байдаг юм уу эд нарыг бид нар бууруулах ёстой. Тэгэхээр ингээд харахад өнөөдөр бид нар НДШ-ийн хувь хэмжээг нэмэх ямар ч боломж байхгүй. Иргэд бол эсрэгээрээ бууруулаасай гэж бодож байгаа юм.

Цалинг өнөөдөр бид нар шууд тэд болгоно гэж хуулиар бид нар үүнийг зааж өгөхөд бол хэцүү. Ингээд энэ хэдэн параметр дотор л орлого, зарлага 2 явж байгаа юм. Бид нар нөгөө талдаа энэ алхмыг үнэнийг хэлэхэд хийхгүй бол хий бичилт хийсээр байгаад манай нийгмийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Олон асуултад хариулах боломж гарна. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Нийгмийн даатгалын багц хууль орж ирж байна. Тэгэхээр миний өргөн барьсан 5 хууль байдаг юм. Яг энэ тэтгэвэртэй холбоотой. Тэгэхээр 7 жилийг 5 жил болгох тухай асуудал яг энэ Нийгмийн даатгалын багц хууль дотроо яг тэр агуулгаараа суугаад ороод ирсэн. Энэ тэмцэл маань амжилттай болсон.

Дараагийнх нь бол 2018 оноос хойш 7 жилээр бодуулсан тэр хүмүүсийн тэтгэврийг буцааж 5 жил болгож бодуулах тэр агуулга бол бүрэн хангагдаж орж ирсэн байгаа. Тэгэхдээ 1 зүйл дутуу байгаа. Өөрөөр хэлбэл энэ төрийн буруугаас болж хохирсон тэр хүмүүсийн тэтгэврийн зөрүүг буцаан олгох асуудлыг энэ хууль дотор тусгаагүй. Тийм учраас зарчмын зөрүүтэй саналаар оруулсан. Нийгмийн бодлогын байнгын хороо дээр унасан байгаа. Энэ бол иргэдийн буруу биш. Энэ төр засгийн буруу шүү гэдгийг бас хэлье.

3 дахь хууль бол Хамтын тэтгэврийн тухай хууль байгаа. Хамтын тэтгэврийн тухай хуулийг би Эрдэнэ даргаас зөвшөөрөл авсны үндсэн дээр дахин өргөн барьсан. Тэгээд энэ Нийгмийн даатгалын багц хууль дотроо ерөнхийдөө тэтгэвэр өвлөгдөх тухай асуудал орж ирж байгаа учраас бас жоохон зөрүү байгаа боловч энийг бол яах вэ бас тодорхой асуудал нь шийдэгдэж байгаа гэж би үзэж байгаа.

4 дэх хууль бол Тэтгэврийг индексжүүлэх тухай хууль байгаа. Дэлхийн 50 гаруй оронд тэтгэврийг индексжүүлэх хууль хэрэгждэг. Хэрвээ инфляцын хэмжээ зарим оронд 3 хувиас дээш, зарим оронд 4 хувиас дээш байх юм бол ирэх оны 1 сарын 1-ээс нь тэрнээс илүү гарсан инфляцынх нь хувиар шууд тэтгэврийг өсгөдөг ийм зохицуулалттай ийм хууль. Манай хажуу талын Казахстан, Орос, Хятад энэ бүх хуулийг бүгдийг нь бүгдээрээ яадаг. Жишээ нь 2021 онд ОХУ-ын инфляц 8,3% байсан. Тэгэнгүүт Орос бол 3 хувийн хязгаар тавьдаг тэгээд 5,3%-аар шууд тэтгэврээ нэмээд явчхаж байгаа. Тийм учраас энэ ахмадууд энэ тэтгэврийн нэмэгдэл нь шууд болдог учраас бас тэр дээр ямарваа нэгэн хэл ам гардаггүй асуудлаа шийдээд ингээд явдаг. Тэгэхээр өнөөдөр энэ инфляцын хувь хэмжээ бол асар их байна. 2022 оны 2 сард тэтгэвэр нэмсэн. 350 байж байгаад 500 мянган төгрөг болсон. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ. Гэтэл яг тэтгэвэр нэмж байх тэр үед гурил шуудай нь 50 мянган төгрөг байсан байхгүй юу. Гэтэл өнөөдөр 110 мянган төгрөг болчихсон. Тэгэхээр нөгөө 350 байсан тэтгэвэр чинь бүр буцаагаад 240 мянган хаништай болж хувирч байна л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ төр засаг тэтгэвэр нэмж болно. Буцаагаад тэрнийх нь зөрүүгээр хариуцлагагүй ажиллаад инфляцаар тэр кармагаас нь бүх юмыг шуучхаж болохгүй байхгүй юу даа.

Тийм учраас энд тэтгэврийг индексжүүлэх замаар ахмадууд төр засагтаа яаж ажиллаж байгааг нь хяналт тавих ийм механизмыг энэ хуулийн хүрээнд бүрдүүлж байгаа байхгүй юу даа. Манай энэ төр засаг чинь арчаагүй ажиллаж дээ. Яагаад гэвэл инфляцын зөрүүгээр бид нарын тэтгэвэр нэмсэн байна гэж. Тийм учраас ер нь бол татвар төлөгч нар хангалттай татвар төлөөд, дээрээс нь өнөөдрийн ажил хөдөлмөр хийж байгаа тэр хүмүүс НДШ-ээ хангалттай төлөөд, хамтын хуримтлалын зарчмаар бүх тэтгэврээ

тавиад явж байгаа. Гэтэл тэрийг нь төр засаг хариуцлагагүй ажиллаад ямар ч эдийн засгийн сайн үр дүн гаргахгүй. Ингэж явсаар байгаад тэр тэтгэврийг нь шимтгэлийг нь ямар ч үнэгүй болгох ийм зүйлийг маш их хийгээд байна. Тийм учраас энэ тэтгэврийг индексжүүлэх тухай хуулийг Нийгмийн даатгалын багц хууль явсны дараагаар би дахин энэ хуулийг батлуулахын төлөө зүтгэх болно. Тэгж байж бид нар энэ ахмадуудынхаа насаараа төлсөн тэр шимтгэлийг илүү хаништай болгох тэр хүмүүст.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн хариулъя. Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга хариулна.

П.Анужин: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Үнэхээрийн улс төр ойртоод тэтгэврийг 10 20 мянгаар нэмж, тэр нь эргээд үнийн өсөлттэйгөө холбоотойгоор ямар ийм нэмсэн үнэ цэн байхгүй энэ тогтолцоо явсаар ирсэн нь үнэн. Тэгэхээр энэ Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд орж байгаа чухал суурь өөрчлөлтүүдийн нэг нь бол тэтгэврийг жил бүр үнийн өсөлт, инфляцтай уялдуулж нэмэгдүүлж, өөрөөр хэлэх юм бол тэтгэврийн худалдан авах чадварыг сайжруулах ийм чухал зохицуулалт оруулж ирж байгаагаараа энэ бол маш чухал юм аа. Энэ хуулийн зохицуулалтыг ч гэсэн олон мянган бас ахмад маань хүлээж байгаа. Энэ хуулийн хэлэлцүүлгийн үед бас ард иргэдээс маань ч гэсэн тэтгэврийг үнэ цэнтэй болгож өгөөч ээ гэдэг санал бол маш ихээр ирж байсан. Энэ ч агуулгаараа хуулийн төсөлд бол бүрэн суусан байгаа гэдгийг хэлье. Та бас энэ хамтын тэтгэврийн талаар ярьж байна. Энэ хуульд маань бас ийм зохицуулалт орж ирсэн байгаа. Тэтгэврийн тусгай зохицуулалт гэж орж ирсэн. Хамт амьдарч байсан эрэгтэй, эмэгтэй 2-ын гэдэг юм уу, аль нэг нь бурхан болж, нас барсан тохиолдолд авч байсан тэтгэврийнх нь 20%-ийг үлдсэнд нь

өвлүүлж үлдээнэ гэсэн ийм бас зохицуулалт орж ирж байгааг хэлье.

7 жилээс 5 жил болсон. Энэ бол 2018-2023 оны хоорондох 5 жилийн асуудал байгаа. Үүний зохицуулалтыг бид нар ор тас тусгаагүй биш энэхүү хуульдаа бол бид нар оруулж ирсэн. Ямар байдлаар оруулж ирсэн бэ гэхээр бид нар цалинг нь ахин нэг удаа шинэчлэн бодож, тэр шинэчлэн бодсон цалингаас нь тэтгэврийг нь тогтооно гэсэн ийм зохицуулалт орж ирсэн. Энэ бол бас агуулгаараа таны хэлж байгаатай ижил ямарваа нэгэн хэмжээгээр бол хохирлыг үнийн зөрөөг нь гарч барагдуулна гэсэн ийм агуулга байгаа гэдгийг хэлье. Бусад зүйл дээр нь гүйцээгээд манай ажлын хэсэг Хишигбаяр дарга хариулъя.

Г.Занданишатар: Амгалангийн Адъяасүрэн гишүүн. За Хишигбаяр дарга хариулна. Ер нь байна шүү дээ 5 жил болгож байгаагийн эдийн засгийн үр дагаврыг их сайн тооцох ёстой юм байгаа юм. Яг энэ индексжүүлж л явахгүй бол энэ чинь бусад тэтгэвэр авагчийг асар их хохироож байгаа шийдвэр шүү. Попорч болно тэгэхдээ эдийн засгийн тооцоотой байх хэрэгтэй. 83.

А.Хишигбаяр: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл бол тэтгэврийг индексжүүлэн нэмэгдүүлнэ гэдэг асуудлыг бол бид тусгасан байгаа. Харин 7 жилийг 5 жил болгоно гэдэг дээр бол нөхөж олгоно гэдэг дээр ...

Г.Занданишатар: Тэтгэврийг индексжүүлэх асуудал биш ээ. Энэ 7 жил 5 жилийг чинь индексжүүлэх асуудал ярьж байгаа.

А.Хишигбаяр: 7 жилийг 5 жил болгох асуудлыг бол бас хуулийн төсөлд оруулж ирсэн байгаа. Энэ дээр бол хэрвээ нөхөж өгөх юм бол тооцоо судалгаа хийж үзсэн байгаа. 91 тэрбум төгрөгийн нэмэлт зардал гарах нь гэдэг асуудал бол

тооцоо судалгаагаар бол гарсан байгаа. Энэ хуулийн төсөл дээр бол яг нөхөж олгоно гэсэн заалтыг оруулаагүй болохоор энэ бол хуулийн төслийн зардал дээр бол тусгаагүй байгаа. Харин хуулийн төсөлд бол цаашидаа 7 жил биш 5 жилээр төлөөд явахад бол тодорхой хэмжээний энэ даатгуулагчид шударга байдлыг бий болгохын тулд бол даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ дээр бол тодорхой хязгаар тавьсан байгаа. Өнөөдөр даатгуулагч төлөх дээд хэмжээ нь бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр хамгийн дээд тал нь төлж болно. Хамгийн багадаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлнө гэж Засгийн газрын тогтоолоор бол зохицуулсан байдаг. Энэ хуулийн төсөл дээр бол бид шууд хуульчилж өгсөн байгаа. Албан журмын даатгуулагч бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээр төлнө. Сайн дурын даатгуулагч бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээ 7 дахин нэмэгдүүлснээр төлнө гэх байдлаар бол хуульчилж өгч, илүү шударга болгохыг бол зорьсон байгаа энэ хуулийн төсөлд.

Г.Занданишатар: Тодруулъя. Тооцоо судалгаагүй л юм ярьдаг улсууд юм байна.

Б.Пүрэвдорж: Мэдээж сүүлийн 5 жилээ өндөр төлөөд, тэгээд тэр хамтын хуримтлалын сангаас илүү авчих гэсэн тийм шударга бус бодолтой хүмүүс байдаг. Тэрийг бас тодорхой хэмжээгээр хязгаарлана гэдэг бол зөв зохицуулалт. Тэгэхгүй бол юу байдаг юм нэг тийм шунахайн сэдлээр асуудалд хандах тийм сонирхол бас зарим хүмүүст байдаг гэдгийг хэлье. Тэгэхээр Хамтын тэтгэврийн тухай хуулийг би өргөн барихдаа бол хамгийн багадаа 20 хувийг энэ талийгаач нөхөр, эхнэрийнхээ тэтгэврээс авах энэ хуулийн зохицуулалтыг оруулж ирсэн, өргөн барьсан байгаа. Яг энэ зохицуулалтаар орж ирж байгаа нь зөв байна. Тэгэхээр

насны хишиг гэдэг зүйл бол жишээ нь 250 мянган төгрөг авч байхад хэрвээ энэ өв өвлүүлэх тухай асуудал яригдах юм болбол жилдээ ойролцоогоор сая 200 орчим мянган төгрөгийн тэтгэврээ нэмэгдүүлэх ийм боломжийг бүрдүүлж байгаа юм.

Г.Занданшатар: Ер нь бол тэтгэврийн зөрүүг бид нар арилгахыг зорьж байхад энэ хандлага чинь тэтгэврийн зөрүүг улам нэмэгдүүлнэ шүү дээ. Яг адилхан ажил хийж байсан 2 хүн өөр хэмжээтэй тэтгэврээ авах болж байгаа юм. 10 жилийн өмнө багш хийж байгаад тэтгэвэрт гарсан хүн яг адилхан багш хийж байгаад гарч байсан хүн тэр үеийн цалингийн хэмжээ инфляц индексжүүлээгүй учраас түүгээрээ бодогдоод тэтгэвэрт гарч байгаа хэмжээ, одоо тэтгэвэрт гарах хүн 2-ын хооронд асар их ялгаа гарна. Энэ бол бүхэлдээ индексжүүлэхгүй бол нийгмийн даатгалын сангаа дампууруул руу чиглэсэн алдагдал руу явуулна. Тэгээд энэ тэрийгээ тооцохгүй зүгээр тэтгэврээ индексжүүлж нэмэх асуудал яриад байдаг. Ингээд хүмүүст таалагдах гээд тэтгэврээ нэмэх асуудлаа индексжүүлнэ гэж яриад байна. Цаад талд нь тэр индексийн хэмжээгээр нийгмийн даатгалын сан чинь өсөж байхгүй бол 2030 онд нийгмийн даатгалын сангийн чинь алдагдал Оюутолгойгоос илүү их алдагдал улсын төсөв дээр ирнэ шүү дээ. Энэ талаар Дэлхийн банкны хийсэн судалгаа байдаг. Тэгээд зүгээр сангаа бодохгүй зүгээр ингэж юу маягаар яриад, судалгаа тооцоогүй юм ярьж байгаа юм шиг байх юм бол ирээдүйд гарах хохирлыг хариуцах болно шүү. Энэ хариулж байгаа хүмүүс.

Амгалангийн Адьяасүрэн гишүүн.

А.Адьяасүрэн: Өдрийн мэнд хүргэе. Үнэхээр нийгмийн хүлээлт үүссэн хуулиудын нэг бол яалт ч үгүй Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл орж байгаад бас баяртай байна. Энэ дээр өнөөдөр бас манай тэтгэврийн насны

ахмадууд, улсад олон жил ажилласан тэтгэврийн хөгшчүүд маань энэ хуулийг бас ингээд хэрхэн яаж шинэчлэгдэх нь вэ гээд хараад сууж байгаа байх. Энэ дээр бас манай Ардчилсан намын бүлгийнхэн Нийгмийн даатгалын багц хууль болоод тэтгэврийн шинэчлэл дээр нэлээд олон ажлуудыг бол хийж байсан. Тухайлах юм бол манай Пүрэвдорж гишүүн маань энэ дээр бас онцгойлон рольж ажилласан гэдгийг бас би цохон хэлмээр байна. Мөн бас эмэгтэй Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай болоод бас эмэгтэй Байнгын хорооны даргатай болсон энэ үед энэ тэтгэврийн шинэчлэлийн асуудал болоод Нийгмийн даатгалын багц хуулиуд орж байгаад миний бие ч гэсэн бас баяртай байна. Энэ дээр бас нэлээд олон ийм шинэчлэлийн зүйлүүд орж ирсэн байна. Ийм учраас би энэ дээр 3 үндсэн асуудлыг бас тодорхой асуумаар байна.

1 дүгээрт нь энэ нийгмийн даатгалын хуулийн ерөнхий шинэчилсэн найруулгын төслийг харахад эв санааны нэгдлийн зарчим буюу энэ хуваарилалтын зарчим бүхий одоогийн тэтгэврийн тогтолцоо үргэлжилж байгаа юм шиг бол ойлгогдож байна. Цаашид эхлээд хагас хуримтлалын, дараа нь энэ бүтэн хуримтлалын тогтолцоог хэзээ хэрхэн яаж шилжих талаар төлөвлөсөн зүйл байгаа юу. Энэ дээр тодруулга авах гэсэн юм.

2 дугаарт энэ хувийн тэтгэврийн тухай асуудлаар Улсын Их Хуралд өргөн баригдаад байгаа хуулийн төслүүдийг Засгийн газраас өргөн барьсан Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй нэгтгэн боловсруулахдаа ямар чиглэл, ямар үзэл баримтлалыг үндэслэх гэж байгаа юм бэ. Тухайлах юм бол өөр өөр үзэл баримтлал бүхий төслүүдийг нэгтгэх боломж байгаа гэж үзэж байна уу. Энэ дээр бас тодорхой хариулт авмаар байна.

3 дугаарт нь сая бас хэд хэдэн гишүүн асууж байна. Ерөнхий тодорхой хариултыг өгөхгүй байна гэж бол би

үзэж байна. Хамгийн сүүлд нь Тэтгэврийн тухай хуулийн төсөлд 2018 оноос хойш дараалан 6 болон 7 жилийн цалингаар тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийг шинэчлэн тогтоогдохоор санал хураалт явагдах болсныг үнэхээр хувийн зүгээсээ бол дэмжиж байна. Энд харин хэдий хэмжээний зардал гарахаар тооцсон байгаа вэ. Хэр зэрэг нэмэлт ачаалал гарахаар тооцож байна. Мөн тооцоолсон тооцооллыг бол тодорхой сонсмоор байна. Энэ 3 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Пүрэв-Очирын Анужсин. Байнгын хороон дарга хариулна.

П.Анужсин: Адьяасүрэн гишүүнд баярлалаа. Сүүлийн асуултаас нь эхлээд хариулъя. Энэ 2018 оноос 2023 оны хоорондох энэ 5 жилийг 7 болсонтой холбогдуулаад үүний зөрүүг төлөх юм уу гэж байна. Би түрүүн бас тодорхой хариулсан. Хуульд бид нар тодорхой тусгаж оруулсан байгаа. Ямар зохицуулалт оруулсан бэ гэхээр энэ цалинг нь 1 удаа бид нар шинэчилж бодно гэж тогтоосон байгаа. Тэр шинэчилсэн цалингийнхаа хувь хэмжээнээс тэтгэврийг нь бодож энэ тодорхой хэмжээнийх нь зөрүүг нь гаргана гэсэн ийм зохицуулалт явж байгаа гэдгийг танд хэлье.

Эв санааны зарчим маань яах билээ. Бид нар энэ хуваарилалтын тогтолцооноосоо хагас хуримтлал, цаашилаад бүтэн хуримтлал руу шилжихэд энэ тогтолцоо маань яах билээ гэж. Зүгээр энд нэг зүйлийг бас тодруулж хэлэхийг хүсье. Энэ хуваарилалтын тогтолцоо маань өөрөө хэрхэвч муу тогтолцоо байгаагүй. Муу болохгүй зүйл болоод бид нар энэ хагас хуримтлал цаашилаад бүтэн хуримтлал руу шилжиж байгаа биш. Хуваарилалтын тогтолцоо маань өөрөө өдий хүртэл энэ 30 жилийн хугацаанд Монгол Улсыг авч ирсэн. Бусад гэнэтийн улс төрийн шийдвэр гэдэг юм уу аль эс

үгүй бол огцом буруу шийдвэрийг ийм улс төрийн шинж чанартай шийдвэрийг гаргаагүй байсан бол нийгмийн даатгалын энэ хуваарилалтад тулгуурласан энэ тогтолцоо маань өөрөө сайн тогтолцоо байсан гэдгийг хэлэх шаардлагатай. Гэхдээ өнөөдөр хүн амын дундаж наслалт ер нь дэлхийг нийтэд нь аваад үзэх юм бол өсөн нэмэгдэж байгаа дундаж наслалттай холбогдуулаад бид нар энэ нийгмийн даатгалынхаа сангийн орлого, зарлагын энэ бүх зүйлийг тооцоод үзэхэд, мөн цаашидаа ялангуяа залуучуудын зүгээс гарч ирж байгаа яагаад миний төлж байгаа мөнгөөр бусдын даатгал буюу бусад зүйлийг төлөх гэж. Би өөрийнхөө ирээдүйд ямар нэгэн өөрт эрсдэл үүсэх тохиолдолд өндөр насныхаа тэтгэмжийг, тэтгэврийг авах насанд хүрэхэд би өөрийн гэсэн нэрийн дансандаа хуримтлалтай байх ёстой гэсэн энэ зарчим бас өөрөө маш ихээр нийгмийн ийм хүлээлт бас энэ он цагийн өөрчлөлт заавал хийх шаардлагатай ийм түүхэн нөхцөл энэ цаг үед тохиож байгаа учраас Монгол Улс бол үе шаттайгаар энэ хуваарилалтынхаа тогтолцооноос хагас хуримтлал 2044 он гэхэд бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжинэ гэсэн ийм тооцооллыг хийсэн байгаа. Үлдсэн яг тэр тооцооллолтой холбоотой гарах асуудлыг нь Ганцэцэг дарга хариулчих уу.

Г.Занданшатар: Ганцэцэг дарга. 81.

Ц.Ганцэцэг: Адьяасүрэн гишүүний асуултад хариулъя. 7 жилийг 5 жил болгосонтой холбоотой энэ хуулийн заалт 2019 оноос эхлээд хэрэгжсэн. Үндсэндээ 2019 онд 6 жилээр 8,8 мянган хүн тэтгэврийг нь бодсон байгаа. 2020 оноос хойш шинээр тэтгэвэр тогтоолгож байгаа хүмүүсийн хувьд 7 жилээр бодоод эхэлсэн. Өнөөдрийн байдлаар бид нар 53,8 мянга хүнийг бол энэ хуулийн тухайн үед хэрэгжиж байсан 7 жилийн заалтаар бодоод тэтгэврийг нь олгоод явж байгаа. Хуулийн төсөл

дээр 1 удаа өөрчилнө гэдэг асуудлыг бол түрүүн бид нар танилцуулсан. Хэрвээ эдгээр хүмүүсийн 7, 6 жилээр бодсон тэтгэврийн зөрүүг нөхөж олгоно гэдэг ийм тооцооллыг хийсэн. Хэрвээ нөхөж олгохоор бол 91,2 тэрбум төгрөг өнгөрсөн хугацаанд бол шаардагдана. 2024 онд энэ хууль хэрэгжээд өөрчлөгдсөнөөр 20 тэрбум төгрөгийг нэмж энэ хүмүүст бид нар тэтгэврийнх нь эх үүсвэрт бол нэмж болох ийм тооцоолол бол байгаа.

Г.Занданишатар: Чинбатын
Ундрам гишүүн

Ч.Ундрам: Энэ хууль орж ирэх гэж маш их удсан. Манай ахмадууд нэлээн их хүлээсэн. Тэгээд энэ сүүлийн саруудад бол нэлээн эрчтэй манай Нийгмийн бодлогын байнгын хороо ажиллаад ингээд эхний хэлэлцүүлгийг явуулж байгаад бол хувьдаа маш баяртай байна. Энэ өнгөрсөн 3 жил тойргоороо явж ард иргэдтэй уулзахад манай ахмадуудын хамгийн гол ярьж байсан юм бол тэтгэврийн зөрүү байна. Шударга биш байна. Жишээлбэл 40 жил багшаар ажиллаад, тэгээд 20 жилийн өмнө ч юм уу, 10 жилийн өмнө тэтгэвэрт гарсан хүн яг адилхан багш хийгээд, адилхан хугацаагаар ажиллаад саяхан тэтгэвэрт гарсан хүн, энэ 2 хүний тэтгэврийн зөрүү нэлээн өндөр байна. Энэ бол шударга биш. Дээр нь дээрээс нь огт ажил хийхгүй байж байгаад, тэгээд НДШ-ээ өндрөөр тооцуулж төлөөд, тэгээд яг шударгаар ажиллаад, насаараа ажиллаад нийгмийн даатгалаа төлж байсан хүн надаас илүү өндөр тэтгэвэр аваад байна. Энэ шударга биш тогтолцоог зөв болгож энэ тэтгэврийн зөрүүг арилгаж өгөөч гэсэн 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал. Инфляцтай уялдуулж тэтгэврийг нэмэх шаардлагатай. Яагаад гэвэл 1 улс төрч ч юм уу, улс төрийн зорилгоор ч юм уу 1 удаа нэмчихдэг, тэгээд алга болчихдог. Гэтэл инфляц үнийн өсөлт гээд яваад

байдаг. Энэ асуудал тийм учраас хуулийнхаа дагуу инфляцтай уялдаад нэмэгддэг болох шаардлагатай гэсэн асуудал.

Дараа нь болохоор хилийн бүсийн нутгаас сонгогдсон гишүүний хувьд энэ цэргийн, хилийн, цэргийн хүмүүсийн гэр бүлийн хүмүүс НДШ нь төлөгддөггүй учраас тэтгэвэр тооцуулж бодуулах ямар ч боломжгүй байдаг гэсэн ийм асуудлуудыг ярьж байсан. Энэ асуудлууд бүгдээрээ энэ өөрчлөлтүүдээр шийдэгдэж байгаад бол маш их баяртай байна. Дээрээс нь бид нар сонгуулийн мөрийн хөтөлбөрт саяын асуудлууд дээр нэмээд тэтгэврийг өвлүүлдэг болгоно гэж амлалт өгсөн байгаа. Тэгэхээр 20 нь гэр бүлийн хүнд нь өвлөгдөх боломж олдож байгаа юм байна. Мөн нэрийн данс нээгдээд тэрийгээ бас тодорхой ипотекийн зээл ч юм уу, боловсролдоо зарцуулж болно гэдэг асуудал манай мөрийн хөтөлбөрт туссан. Тэгээд эдгээр зүйл орж байгаад бол бас маш их баяртай байна.

Хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт энэ НДШ-ийн дата мэдээллийг цахимжуулах ажлууд хийгдэх үү. НДШ-ийн дэвтэр гээд 1 дэвтэр бид нар бөглүүлдэг, тамга даруулаад, гарын үсэг зуруулаад, тэгээд заримдаа тэр нь алга болчихсон гээд л тэтгэвэрт гарч байгаа намайг МУИС-д ажиллаж байхад багш нар нөгөөдхөө олохгүй байна гээд л бөөн архив болоод л ингээд явдаг. Тэгэхээр энийг цахимжуулаад шууд автоматаар тэтгэвэрт гарахад нь л бодоод л өгчихдөг болгочихмоор байна. Ийм асуудал хийгдэж байгаа юу.

2 дугаарт энэ хуулийн төслийн өөрчлөлт дээр сангийн менежмент бас нэлээн орж ирж байна л даа. Компаниудын А зэрэглэлийн хувьцаа авах гээд. Яг энийг нь гүйцэтгэх хүнийг яаж сонгон шалгаруулах юм бэ. Энэ дээр маш чадварлаг хүн ажиллаж байж энэ сангийн менежмент сайн явна. Тэр хүнээс, тэр хүний мэдлэг, боловсрол,

чадвараас шууд хамаарна гэж бодож байна. Ийм асуулт 2 асуулт байна.

Суурь тэтгэврийг болохоор төсвөөс болон уул уурхайн баялгаас санхүүжүүлнэ гээд энэ өөрчлөлт дээр биччихсэн байна л даа. Энэ дээр би бас нэлээн санаа зовж байна. Одоо яваандаа энэ сан чинь төсвөөс ингээд л дандаа санхүүжээд явна гэхээр сан гэдэг утгаа алдчих юм биш үү гэсэн ийм 3 асуулт байна.

Г.Занданишатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: Баярлалаа Ундрэм гишүүн хуулийнхаа төсөлтэй бол маш сайн танилцаж маш ончтой асуултуудыг бол асууж байна. Тэгээд би энэ дээр бас нэг зүйлийг тодруулж хэлэх нь зөв байх. Энэ тэтгэврийн тусгай зохицуулалт гээд 20 хувийг бид нар үлдсэн хүнд нь олгох тухай ярьсан. Энэ бол өвлөгдөх асуудлаас бас тусдаа шүү. Энэ тэтгэврийн тусгай зохицуулалт гэж оруулж ирсэн. Ер нь статистик Монгол Улсын нийгмийнхээ байдлыг хараад үзэхэд хамт тэтгэвэр авч байгаа хүмүүс маань хамтарсан ипотекийн зээлтэй, 1 нь нас барсан тохиолдолд энэ амьдралын үнэ өртөг бүхий л зүйл нөгөө хамтын тэтгэвэр авч байсан үлдсэн хүнийхээ нуруун дээр бас үлдэж хүндэрдэг гэсэн ийм зүйл байгаа учраас энэ хуулийн зохицуулалтаар бол 20 хувийг нь тодорхой хэмжээнд үлдээнэ ээ гэж. Энэ маань нөгөө өвлөх асуудалтайгаа тустай юм шүү. Өвлөх асуудал ямар үед эрх нь нээгдээд ярьж байна вэ гээд хэлэхээр бид нар энэ хууль хэрэгжиж эхлэх он цаг буюу 2025 оны 1 сарын 1-ээс эхэллээ гэхэд төлж байгаа шимтгэлийн 2 хувийг нь нэрийн дансанд шууд мөнгөжүүлээд эхэлнэ гэсэн үг. Энэ мөнгөжүүлсэн энэ дансыг чинь өвлөх асуудал бол энэ мөнгөжүүлсэн нэрийн данс дээр яригдаж байгаа байхгүй юу. Таны ярьж байгаа 20 хувь бол тусгай зохицуулалт гэж яригдаж байгаа юм. Анх удаа бол таны бас асуултдаа

хөндсөн Монгол Улс анх удаа хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг өргөн барьж оруулж ирж байна. Энэ бол анхдагч хууль. Гэхдээ Монгол Улсын нийгмийн харилцаанд бол огт байгаагүй харилцаа биш. Энэ бол бас хувийн том компаниуд өөрсдийнхөө ажилчид бас амжилттай хэрэгжүүлээд ирсэн ийм зүйл байсан. Гагцхүү бид нар эдгээр хүмүүсийнхээ даатгуулагчийнхаа эрх ашгийг хуулийн хүрээнд хангаж өгч хуулиар хамгаалж байгаагаараа энэ хууль бол маш чухал үүрэгтэй.

Дараа нь мэдээж нэмэлт тэтгэврийг үүсгээд, ийм сан үүсгээд өөртөө өөрийнхөө ирээдүйн эрсдэлийг тэтгэвэрт гарсан үедээ ингэж сайжруулах ийм бүрэн сонголтын тогтолцоог бас бид нар хуулиараа нээж өгч байгаа. Тэр яг яаж санхүүгийн хяналтыг нь яаж хийх вэ гэдгийг Батжаргал дарга гүйцээж хариулаад, Ундрэм гишүүний тэр эхний асуусан 2 асуултад Хишигбаяр дарга бас гүйцээгээд хариулчих. Батжаргал дарга та эхлээд тэр санхүүгийн хяналтыг хэрхэн хийх вэ гэдэг асуултад хариулчих.

Г.Занданишатар: 85.

Ж.Батжаргал: Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам Батжаргал. Адьясүрэн гишүүний асуултад хариулъя. Ундрэм гишүүний асуултад хариулъя. Уучлаарай. Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо дээр нийтдээ зах зээл дээр 3 үндсэн бүрэлдэхүүнд тоглогч ажиллана.

1 дүгээрт хувийн тэтгэврийн сан, урт хугацааны даатгагч 2 энэ зах зээл дээр ажиллана. Энэ 2 үндсэн тоглогчоос гадна хяналт тавих 2 байгууллага орж ирнэ. 1 дүгээрт мэргэжлийн хөрөнгө оруулагч буюу хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд хөрөнгө оруулалтыг хийхээр хуулийн төсөлд тусгасан. 2 дугаарт өдөр тутмын болон бүх бүртгэлийг хийж, хянаж байх үндсэн байгууллага буюу Кастодиан гэдэг байгууллага бас энэ тогтолцоонд орж

ирж ажиллахаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Энэ бас бусад хяналтыг бол Санхүүгийн зохицуулах хороо өдөр тутмын болон бусад бүртгэлийн хяналт болон бусад хяналтыг тавина. Хуулийн төсөл дээр туссан бас нэг чухал ойлголт бол баталгаат өгөөжтэй байхаар хуулийн төсөлд тусгасан байгаа. Баярлалаа.

Г.Занданишатар: Булгантуяа сайд. Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Цахимтай холбоотой Ундрам гишүүний асуултад хариулъя. НДШ төлсөн тухай цахим лавлагааг бол одоо e-mongolia-аар дамжуулж авах боломжтой байгаа. 2022 онд НДШ-ийн лавлагаа e-mongolia-аас бас хамгийн олон удаа авсан үйлчилгээний болсон. Тэгэхээр хуучин шиг бичиг цаасаа, баримт бичгээ гээд ингээд байх шаардлагагүй болсон. Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хувьд бол ер нь төрийн үйлчилгээг хамгийн сайн цахимжуулсан яамдын 1 болсон. Иргэдийн хувьд ч гэсэн хамгийн их ханддаг. Өмнө нь бол хамгийн их бас бухимдалтай үйлчилгээний шат дамжлага ихтэй гэж бас бухимддаг байсан. Тэгэхээр үүнийг цахимжилт бол нэлээдгүй сайн хийгдсэн. Одоо бол нийгмийн даатгалын дэвтэргүй болсон 2020 оноос хойш. Тэгээд бол дэвтэр бол бүрэн цахимжсан гэсэн үг. Төлсөн бүх мэдээллүүд нь ингээд тооцогдоод явж байгаа.

Г.Занданишатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Нийгмийн даатгалын хууль Монголын ард түмний хамгийн гол 2 хуулийн 1 орж ирж байна. Дэмжиж байгаа. Зүгээр асуух хэдэн зүйл байна.

1 дүгээрт эхнэр эсвэл нөхөр нь нас барахад үлдсэн хүнд нь бол 20 хувиар тэтгэврийг нэмж өгнө гэж байна.

Тэтгэвэр алдагчид өгөх юм байна. Энэ дээр 590 сая төгрөг улсын төсөвт орно гэж заалаа.

2 дугаарт 1 чухал хууль байгаа энэ маш чухал хууль. 27.1-д ер нь бол инфляц хөөрөгдөөд л байвал жилийн инфляцын дундаж түвшинтэй уялдуулж тэтгэвэр дээр нэмэгдэл олгоно гэсэн байна. Энүүгээр өнгөрсөн жил ирэх жил 637 тэрбум төгрөг нэмэгдэнэ гэж орж ирж байна. Маш зөв. Дараагийнх нь болохоор 7 сарын дундаж болон тэр 80,4 тэрбум болон 264 тэрбум гээд ороод ирж байгаа. Энэ нийлээд ирэх жилийг тооцвол би тэр 637-г оруулаагүйгээр тооцож байгаа шүү. Тэрийг бол сан болон төсвөөс гэж байгаа. Энэ хууль орж ирэхэд нэг засах ёстой та нар юм бол нийгмийн даатгалын нэмэгдэл, улсын төсвийн дэмжлэг нэлээн олон зүйлүүдийг хольчихсон байна. Ялгаж орж ирээрэй. Дараагийн ээлжид дараагийн хэлэлцүүлгээр. Тэгэхлээр улсын төсвөөс 2024 онд 1,1 их наяд төгрөг тусгахаар зааж байна. Миний тооцоогоор нэмээд үзэхэд. Энэ 1,1 их наяд улсын төсөвт баталгаатай орох яг баталгаа байгаа юу. Хууль батлагдлаа л бол улсын төсөв дээр шууд ийм ачаалал ирнэ гэдгийг тооцоолсон уу. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Төслийн 7.1.1-д өндөр насны тэтгэврийн урамшуулал орж ирсэн байна л даа. Юу томъёолол орж ирсэн байна. Тэтгэвэр тэнцүү цалинг 45 хувиар нэмэх нь шимтгэлийг 0,125 хувиар нэмэгдүүлээд орж ирсэн томъёолол орж ирсэн байна. Сарын дундаж цалин 1 сая 200 мянган төгрөг гэж бодвол сард 550 мянган төгрөгийн тэтгэвэр авахаар тооцоо гарч ирж байна. Тэгэхлээр Улаанбаатар хотод хөдөлмөр амьжиргааны доод түвшин 277 мянга байгаа. Амьжиргааны доод түвшинээс 2 дахин их л орж ирж байна. Энэ бага биш үү. Энийг нэмэгдүүлэх боломж байгаа юу. Нийт тэтгэвэр авагчдын 37,6 хувь нь нийт цалингийн бүтцийн 37,6 хувь нь 420 мянгаас 1 сая төгрөгийн дотор гэж байгаа шүү дээ.

Нийт хүмүүсийн 2 сая төгрөг хүртэлх цалин буюу дундаж цалин бол 1 сая 573 мянга байгаа. Монголын дундаж цалин 1 сая 500 мянга байгаа. Тэгэхээр бидний тооцоогоор би өөрийнхөө л хэмжээнд актуар тооцоо хийж байна шүү дээ. 500-600 мянган төгрөгийн дунд л бид хэлбэлзэхээр тэтгэврийн тооцоо гарч байна гэж би ойлгож болох уу. Би тооцоогоо бүр дэлгэрэнгүй та нарт танилцуулбал нэлээн цаг авах байх. Ер нь Монголд бол 2-3 сая төгрөгийн цалин авдаг хүн бол 11.5 хувь, 3 саяас дээш цалин авдаг хүн бол 8,8 хувь. Тэгээд энэ утгаараа тооцоход би 1 сая 200 мянган төгрөгийн цалин авлаа гэхэд ийм тооцоо гараад байна.

3 дугаар асуулт. Чухам яагаад 20 хувь гэж тооцсон юм бэ та нар. Тэтгэвэр алдагч тэтгэврийг эхнэр юм уу, нөхөр нас барахад үлдсэн хүнд нь 20 хувиар нь нэмэгдэнэ гэж байна. 30, 40, 50 хувь байх боломж байгаагүй юу. Энэ актуар тооцоо л байх л даа. Яаж хийсэн бэ.

Г.Занданишатар: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэв-Очирын Ануужин гишүүн хариулъя.

П.Ануужин: Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд баярлалаа. Түрүүнээс хойш ер нь олон гишүүд асууж байна. Энэ тооцооллоо Сангийн яамтайгаа уясан юм уу. Тооцоо төсөвгүй тооцоо нь судалгаагүй ингээд ийм хууль яваад байгаа юм биш үү сайхан заалтуудтай гэж. Би бас түрүүн хэлсэн. Ер нь энэ нийгмийн даатгалын багц хууль бараг 30 жилийн явцад өөрчлөгдөж шинэчлэгдэж чадаагүй. Гэтэл нөгөө талдаа ард түмний дунд асар их эрэлттэй байгаа энэ хууль яагаад Их Хурлын босгыг давж орж чаддаг вэ гэдэг гол шалтгаан бол ерөөсөө л энэ төсвийн тооцооллын асуудал байсан. Монгол Улсын Засгийн газар бас эдийн засгийн энэ өсөн нэмэгдэж байгаа энэ байдалтайгаа уялдуулаад хамгийн түрүүнд энэ төсөвтөө уяж авсан

реформ шинэчлэлийн шинжтэй. Мөн улс төрийн бодлогын том алхам хийсэн нь энэ нийгмийн даатгалынхаа реформыг төсвийнхөө, эдийн засгийнхаа өсөлттэй уялдуулж хийсэн энэ том алхам байсан. Тэгэхээр энэ Нийгмийн даатгалын багц хууль маань өөрөө дөнгөж саяхан Улсын Их Хурлаар хэлэлцэгдсэн төсвийн тодотгол мөн Монгол Улсын төсвийн хүрээтэй нягт уялдуулж ингэж гаргасан тооцооллууд, бид нар хэрэгжих боломжийг нь бүгдийг нь Сангийн яам, Монгол Улсын төсөвтэйгөө бид нар уялдуулж ингэж хууль хэлэлцүүлэх явцад бид нар ажилласан байгаа. Тэр нарийн тооцооллын асуудлуудыг Батжаргал дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариулна. Хишигбаяр дарга хариулах уу. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

Г.Занданишатар: 83 Хишигбаяр Төрийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэгч.

А.Хишигбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. 2 гэр бүлийн 1 хүн нь бурхан болбол 20 хувийг нь яагаад нэмэгдүүлж олгож байгаа вэ. Яагаад дахиад 30, 40 хувь байж болдоггүй юм бэ гэдэг асуултад хариулъя. Ер нь бол нийгмийн даатгалын сан өөрөө шимтгэл төлсөн орлогоороо буцаад тэтгэвэр авагчийн зардлыг олгож байгаа. Нөгөө талаар даатгуулагч маань өөрөө тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийг 17 хувиар төлж байгаа. Ажил олгогч нь 8,5, даатгуулагч өөрөө 8,5. Нийлээд 17 хувиар төлж байгаа. Буцаад тэтгэврээ бод тооцуулахдаа тухайн цалингийнхаа хамгийн багадаа 45 хувиар буюу 3-аас дээш дахин нэмэгдүүлж тэтгэврээ тогтоолгоод явж байгаа. Ийм учраас бид нар бол нийгмийн даатгалын сан, ялангуяа тэтгэврийн даатгалын санг алдагдалгүй байх зорилгыг тавьж байгаа учраас бол 20, 30 хувь гэж бол шууд нэмэх боломж байхгүй. Ийм учраас бид нар бол тооцоо хийгээд сангийн хувьд бол 20 хувиар тооцох юм бол бас ачааллыг даагаад явах нөхцөл боломж байна гэсэн тооцоо хийсэн байгаа. 20 хувиар

нэмэгдүүлэх тэтгэвэр авагчийн тоо бол жилдээ бол 7275 мянган хүн гарна. 75 хүн ийм нэмэгдэл тэтгэвэр авах боломжтой юм байна. Дундаж тэтгэвэр өнөөдөр 555 мянга байгаа. Ингэхээр бол дунджаар бол 587 мянган төгрөгийн дундаж тэтгэврээс бол 20 хувь нэмэгдүүлд явахад бол сангийн алдагдал, сангийн нэмэлт зардал бол 7,7 тэрбум төгрөг бол зарцуулах юм байна гээд ийм тооцоо хийсэн байгаа. 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүс бас энэ улсын төсвөөс болоод зардлыг нь хариуцаад явдаг. Энэ хүмүүсийн тухайд бол 584 хүн бол бас тэтгэврээ нэмэгдүүлэх байх. Энд бол 700 сая төгрөг бол улсын төсвөөр нэмж зарцуулахаар байна гэсэн ийм тооцоо судалгаа хийсэн байгаа.

2 дахь асуулт нь бол 45 хувь, 0.125%-аар тооцоолол гэж оруулж ирсэн байна. Энийг нэмэгдүүлэх боломж байна уу гэдэг асуулт байсан. Би бас түрүүн хэллээ 17 хувиар шимтгэл төлчхөөд, хамгийн багадаа 45 хувиар тэтгэврээ тооцуулж авч байгаа учраас энийг бол бид нар нэмэгдүүлэх боломж байхгүй байна гэж харж байгаа. Ер нь бол нийт тэтгэвэр тогтоолгож байгаа хүмүүсийн дундаж төлсөн шимтгэлийн хувьд бол 25 жил байдаг Монголд тэтгэвэр авч байгаа хүмүүсийн. Ингээд бодохоор ер нь бол дунджаар тэтгэвэр авагч маань тухайн авч байсан цалингийнхаа 52,5 хувиар бол тэтгэврээ бодуулж авч байна л гэсэн үг. Тэгэхээр энэ бол одоо өнөөдрийн төлж байгаа шимтгэлээ 4 дахин нэмэгдүүлж тэтгэвэр болгож авч байгаа.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя. Би 47 асуултаа бичгээр явуулчихсан байгаа. Хариугаа аваагүй байгаа. Орсон, ороогүйг нь би ойрын үед авах байх. 8 дугаар зүйл дээр тэр цалин тооцох томъёолол дээр 1 үг байна. 27 дугаар зүйлийн 27.8-д жилийн эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүн гээд биччихсэн байна. Жилийн эцсийн

үлдэгдэл гэдэг нь тэгээд мөнгөжсөөгүй гэсэн үг үү. Би их тодорхой хурдан асуугаад явчихъя.

2 дугаар асуулт Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээг 13 дугаар зүйл дээр 70 хувь хөдөлмөрийн чадвар алдах юм бол 100 хувиар тооцож олгож байгаа. 100 хувиар олгож байгаа. 69 хувиар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр гэсэн байна. Өөрөөр хэлбэл яагаад энэ хооронд 31 хувийн зөрүү гарч байгаа вэ. Энэ шударга биш үү. 1 хувиар л хөдөлмөрийн чадвар алдалт буурахад 31 хувийн зөрүү гарч байна. Энэ дээр надад тодорхой хариулт өгөөч.

Дараагийн асуулт бол тэтгэвэр авагчийн.../минут дуусав/

Г.Занданшатар: 81. Ганцэцэг.

Ц.Ганцэцэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөлд энэ инфляцаар өсөх хугацааг бол дараа жилийн 1 дүгээр сарын 1-ээс гээд өөрчлөөд оруулсан байгаа. Тийм учраас жил бүр 1 дүгээр сараас эхлээд л тэтгэвэр авагчдын тэтгэвэр бол инфляцын түвшинтэй уялдаад нэмэгдээд явна.

2 дахь асуултын хувьд тэр хөдөлмөрийн чадвар алдалтаа тэтгэвэр боддог асуудлыг бол тавьж байна. Ер нь бол даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг бүрэн болон хагас гэж ингэж тодорхойлж байгаа. 50-69 хувь болохоороо хагас гэж үзээд, 70-аас дээш болоод 70 ба түүнээс дээш гэхээрээ бүрэн гэж үзэж байгаа. Бүрэн алдсан хүний хувьд бол өндөр насны тэтгэвэр боддог тэр хувь хэмжээгээр 100 хувь бодоод олгодог. Хагасыг яах вэ 1 хувийн асуудал бол гарч байна гэж та хөндөж байна. Гэхдээ энэ маань өөрөө яг эмнэлэг зрүүл мэндийн магадлалын зөвлөл энэ дүрэм журмынхаа дагуу хагас алдсан гэж үзэж байгаа учраас өндөр насны тэтгэврийн хэмжээгээс хөдөлмөрийн чадвар алдсан хувиар нь бодоод энэ

тэтгэврийн бодолт бол хэвээрээ одоогийн хууль тогтоомжийн төсөл дээр бол тусгаж байгаа.

3 дахь асуултын хувьд бол.../минут дуусав/

Г.Занданишатар: 81 гүйцээгээд хариулчихъя. Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Ц.Ганцэцэг: Ганбаатар гишүүний 3 дахь асуулт энэ 8.1 дээр байгаа хуулийн төслийн томъёог бол асууж байна. Тэр жилийн эцсийн үлдэгдэл гэдэг маань үндсэндээ одоогийн нэрийн дансны аргаар бид нар тухайн жилийн орлогоо бүртгээд өмнөх жилийн эхний үлдэгдлээ тооцоод, жилийн эцэст хүүгээ тооцоод гарч байгаа хийсвэр үлдэгдэл юм. Энэ бол бичилтээр хийж байгаа үлдэгдэл. Энэ өөрөө тэтгэвэр бодох арга гэдэг утгаараа энэ томъёо бол үндсэндээ ийм байдлаар явж байгаа. Мөнгөжүүлсэн 2 хувийг мэдээж хийсвэр үлдэгдлээсээ хасна гэсэн байдлаар энэ томъёоллыг шинэчлээд оруулсан байгаа.

Г.Занданишатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Ганбаатар гишүүн манай бас нийгмийн даатгалын багц хуулийн ажлын хэсгийн гишүүн маш чухал асуудлуудыг хөндөж байна. Хөдөлмөрийн чадамж алдсан гэдэг энэ тодорхойлолтыг ер нь бол Эрүүл мэндийн яамнаас гаргадаг. Тэгэхдээ үүнийг бид нар бас дахиж сайн харах хэрэгтэй юм байна лээ. Бид нар намраас халамжийн бас хууль гээд дараах холбогдох хуулиуд дээр энэ асуудлыг ер нь нэг авч харъя гээд. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын ахалдаг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах үндэсний зөвлөл дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс бас энэ асуудлыг ер нь дахиж харах хэрэгтэй байна гэдэг саналыг бас хүргүүлээд байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд

бид нар халамжийн тэтгэмж, байнгын асаргааны тэтгэмжийг нэмэгдүүлэхээс гадна илүү хөдөлмөр эрхлэх боломж бололцоог нь бас давхар нэмэгдүүлэх ёстой, улсын төсвөөс улсаас үүн дээр бас давхар дэмжлэг үзүүлэх ёстой гэдэг энэ асуудлыг бас ярьж байгаа. 20 хувийн хувьд бид нар жишээлбэл сая бол нэлээн консерватив байдлаар энэ 20 хувийг 2 хувийг мөнгөжүүлэх, 20 хувийг үлдсэн.../минут дуусав/

Г.Занданишатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Миний хамгийн гол актуар тооцоо хэрэгтэй л дээ. Энэ бол ер нь сайн хууль шүү. Энэ бол сайн хууль. Маш олон жил зүдэрч гарч ирж байгаа. Тэгээд энэ олон заалтууд хэрэгжээсэй гэдэг үүднээс л би энэ болгоныг асууж байгаа юм шүү. Тэгэхээр 20 хувь гэдэг дээр 30 яагаад байгаагүй юм, 15 яагаад байгаагүй гэдэг тооцоолол бидэнд маш чухал гэсэн санааг би 1 дүгээрт илэрхийлье. 2 дугаарт бол тэр сая Булгантуяа сайд хэлж байна. Яг 70 хувийн хөдөлмөр алдалт байхад чинь 100 хувь тэтгэмж өгөөд, 69 гээд л доошоо ороод ирэхлээр л шууд 31 хувиар, 32 хувиар ингээд буураад явчихаар энэ хоорондын тооцооллын тийм зөөлрүүлэлд байгаа юу гэдгийг л би асуугаад байгаа юм шүү. Тэгэхээр энэ хуулийн цаад санаа нь бол актуар тооцоогоо мэргэжлийн хөндлөнгийн бие даасан шинжээчийн дүгнэлтийг тойрч улс төрчид ярих ёстой болохоос биш, яг дураараа бид өөрсдөө.../минут дуусав/

Г.Занданишатар: Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Пүрэв-Очирын Анужсин хариулна.

П.Анужсин: Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Манай ажлын хэсгийнхэн бас энэ тооцоолол дээрээ тодорхой хариулт өгмөөр байна. Жишээлбэл түрүүнээс хойш асуугаад байгаа Сайнхүүгийн Ганбаатар гишүүний хэлж байгаа энэ

актуар тооцооллын асуудал Дэлхийн банкаар бид нар 2 удаа энэ хуультай холбоотой актуар тооцооллыг хийлгэсэн байгаа. Ганбаатар гишүүн маань ч өөрөө мэдэж байгаа. Энэ бараг санхүү төсөвтэй холбоотой зүйл заалт бүүр өөрөө актуар тооцоолол дээр л явагдаж байгаа. Бид нар бол нэг ард түмний хүлээлтэд нийцүүлээд, сайхан сонсогддог хэрэгжих боломжгүй хуулийн төлөө бол энэ олон сар, жил 2006 оноос авхуулаад бол ажиллаагүй. Энэ бол дандаа актуар тооцоолол дээр таны хэлдгээр явж байгаа. Манай ажлын хэсгийнхэн дараа дараагийн гишүүдийн энэ асууж байгаа актуар тооцоолол дээр яг тодорхой хариулаад явахыг хүсэж байна. Энэ ийм нэг эргэлзээтэй байдлаар ч юм уу хариулаад байгаа байдал бас энэ олон сар ажилласан энэ сайн хуульд бол эргэлзээ төрүүлэх хандлагуудыг бас түрүүнээс хойш гаргаад байна гэдгийг би бас тодруулж хэлэхийг хүсэж байна.

Тэгээд таны асуултад хариулахад Дэлхийн банк 2 удаа.../минут дуусав/

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчихъя. Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: яг таны асуугаад байгаа асуудалтай холбоотойгоор Дэлхийн банк 2 удаа актуар тооцоолол бүрэн хэмжээгээр хийсэн байгаа гэдгийг хэлж хариулъя.

Г.Занданишатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Д.Өнөрболор: Ард иргэдийн дунд маш их хүлээлттэй байсан энэ нийгмийн даатгалын багц хууль орж ирж байна. Тэгээд яг үндсэндээ энэ шинэчлэл гэсэн нэрдээ бүрэн агуулгаараа бас учир дутагдалтай байна гэж бас харж байна. Сая би бас тэр тодорхой хэмжээгээр хэн Чинзориг сайдтай санал нэг байгаад байгаа юм. Ер нь бид нар энэ зарлагын урсгал, төсөв дээр ачаалал бий болгох энэ талаасаа гэхээсээ илүү өнөөдөр орлого,

эдийн засгийн эргэлт талаасаа бас энэ асуудал дээр цогцоороо дээрээс нь бас хариуцлагын тогтолцоог бас давхар ингэж цуг оруулж ирж байж энэ бүрэн шинэчлэл болох байсан юм болов уу, суурь шинэчлэл болох байсан юм болов уу гэдэг асуудал байгаа юм аа.

Сая зөвхөн төсвийн тодотголоор л ингээд аваад үзэхэд жилдээ ойролцоогоор 1 их наяд төгрөгийн татаасыг нийгмийн даатгалын санд хийхээр болж байна гэж би ойлгож байгаа. Тэгээд яг энэ шинэчлэлээр ер нь яг хэд болж байгаа вэ гэдгийг би асуумаар байна.

Тэтгэвэр тэтгэмж 2020 оноос хойш ер нь тэтгэврийг 2 удаа нэмлээ. Тэтгэвэр нэмэгдсэн ч гэсэн ер нь үнийн өсөлтийг бол давж чадахгүй байна. Тэтгэврийн энэ худалдан авалтын чадвар бол маш муу байна. Тэгээд амьжиргаандаа бол хүрэлцэхгүй байна гэсэн асуудал нийтлэг ард, иргэдийн хувьд бол маш шүүмжлэл дагуулж байгаа. Тэгээд иргэдийн зүгээс энэ тэтгэвэр хуримтлагддаг болох хэрэгтэй байна, тэтгэвэр өвлөгддөг болох хэрэгтэй байна, инфляцын өсөлттэй уялдааг байх хэрэгтэй байна гэсэн тодорхой асуултууд дээр л маш их хүлээлттэй байгаа асуудал байгаа. Тэгэхлээр яг хэзээнээс хэдэн хувиар ингээд хуримтлуулж эхлэх юм бэ. Тэрийгээ тодорхой хэлмээр байна. Хэзээнээс хэдэн хувиар хэнд өвлөгддөг болох юм бэ. Энэ инфляцын өсөлтийг тэтгэвэр дээр ер нь хэрхэн тооцож байгаа юм бэ. Яг энэ дээр тодорхой тооцоололтой хариу авмаар байна.

Дараа нь энэ өөрчлөлттэй холбоотой энэ төсөв дээр ирэх зардлын тооцооллыг асуумаар байна л даа. Хуримтлал энэ өв 2-т шилжүүлэхээр дутагдсан эх үүсвэрийг хэрхэн, яг яаж шийдэж байгаа юм бэ. Ер нь бид нар бас нэг асуудал дээр бас маш тодорхой анхаарлаа хандуулахгүй бол болохгүй юм байна Булгантуяа сайд аа, та бас энэ

дээр анхаарлаа хандуулаарай гэж би бас танаас хүсье. Энэ залуу үе бид нарыг бас харж байгаа. Энэ ажиллах хүчний хувьд манай залуу үе бол энэ цонх үед ажиллаж байгаа. 10-аад жилийн хугацаа ч хүрэхгүй энэ хугацаанд алдагдах эрсдэл үүсэж байгаа гэж ойлгож байна. Тэгэхээр энэ хөдөлмөр эрхэлж байгаа 10 хүн тутмын 10 хүн 3 хүний тэтгэврийг төлж байгаа. Энэ цонх үе дуусах үед 10 хүн 8 хүний тэтгэврийг төлөх ийм эрсдэл ойрхон байгаа. Тэгээд хөдөлмөрийн насны 1,2 сая хүний ойролцоогоор 56 хувь нь л өнөөдөр НДШ-д хамрагддаг юм байна лээ шүү дээ. Тэгээд энийг бүрэн, шударга хүртээмжтэй болгох тал дээр та нар хамрагдалтыг нь нэмэгдүүлэх ямар бодлого зохицуулалт хийж байна. Өнөөг хүртэл ер нь нийгмийн даатгалын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар л маш их төлж байгаа хүмүүс дээрээ ачаалал үүсгэх замаар хийж ирж байсныг бол хүмүүс маш их шүүмжилж байгаа. Энэ дээр бол анхаарлаа хандуулах ёстой. Өнөөдөр 200 гаруй мянган хүн ажилгүй байна Монгол Улсад. 2018 оны судалгааг ингээд аваад үзэхээр 5 хүн тутмын 1 нь ажилтай ядуу байсан байгаа юм. Одоо энэ бол бараг л өнөөгийн нөхцөл байдал 3 хүний 1 нь ажилтай хэр нь ядуу байх ийм нөхцөл байдал руу орсон байх гэж би бол харагдаж байна.

Тэгээд залуус ер нь ажил хийснээрээ амьдралын асуудал шийдэгдэхгүй байна гэдэг асуудлыг л ярьж байгаа шүү дээ. Тийм ч учраас энэ хөдөлмөрийн үнэлэмж муу байхаар иргэд ер нь гадаад орныг зорьж байгаа. Тэгээд энэ дээр ямар бодлого зохицуулж байгаа юм бэ. Энэ ажиллах хүчин хөдөлмөрийн зах зээл дээрээ цогц бодлого авч хэрэгжүүлэх, дээрээс нь хөдөлмөрийн үнэ цэнийг бодитоор үнэлэх асуудал. Бид нар өнөөдөр зах зээлийн нийгэм рүү шилжсэн л гээд л яриад байгаа боловч яг өнгөрсөн төвлөрсөн төлөвлөгөөт нийгмийнхээ тогтолцооноос.../минут дуусав/

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин ажлын хэсгийн ахлагч асуултад хариулна.

П.Анужин: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Өнөрболор гишүүний хэлж байгаа олон саналуудтай бас санал туйлын нэг байна. Ер нь энэ удаа бид нар хуулийн шинэчилсэн найруулга дээр ажиллаж байх хугацаанд ч биш ер нь үе үеийн 1995 онд анх удаа энэ багц хууль маань хэлэлцэгдэж батлагдах үед ч гэсэн тэр үеийн ажлын хэсгийнхний тэр үед ажиллаж байсан хүмүүсийн гол асуудал ерөөсөө л энэ НДШ сангийн алдагдалгүй байх, орлого, зарлагын тэнцлийг хэрхэн хангах вэ гэдэг энэ асуудал бол байсаар ирсэн. Ер нь хэлэхэд энэ НДШ-ийн хувь хэмжээ бас дэлхийн дунджаар авч үзэхэд тийм бас өндөр биш. Энэ бол харьцангуй дундаж хэмжээг барьж явдаг.

Та шинэчлэл сайн харагдахгүй байна гэж байна. Тогтолцоо маань бүрэн шинэчлэгдэж байхад энийг шинэчлэл гэж үзэхгүй бол яг юуг бид нар шинэчил гэж үзэх вэ. Монгол улс өнөөдрийг хүртэл 30 жил хуваарилалтын тогтолцоонд байсан. Өнөөдрөөс энэ хууль хэрвээ батлагдвал бид нар хагас хуримтлалын тогтолцоо руу буюу нөгөө эв санаанд суурилсан эв санааны зарчмын маань суурь зарчим аажим аажмаар өөрчлөгдөөд, ерөөсөө хувь хүн өөрийнхөө төлсөн шимтгэлийн хэмжээгээр л өөрийнхөө өмнө хариуцлага хүлээдэг. Энэ тэс өөр тогтолцоо руу шилжиж байгаа. Энэ бол үнэхээр суурь том реформ шинэчлэл гэж үзэх бүрэн үндэслэлтэй гэж үзэж байна.

2 дахь энэ хуулийн том шинэчлэл бол хувийн нэмэлт тэтгэврийг бид нар анх удаа Монгол Улсад анхдагч хууль гаргаж ирж, энэ хувийн байдлаар өөрийнхөө авч байгаа тэтгэвэр дээр хүсвэл нэмэлт тэтгэврээ төлөөд өөрийнхөө ирээдүйн амьдралын суурь баталгааг нэмж хангах энэ тогтолцоо бүрэн бий болох энэ анхдагч хууль бол өргөн баригдаж байна. Өнөөдөр бас аж

ахуйн нэгжүүд боломжтой том аж ахуйн нэгжүүд өөрийнхөө компанийн ажилтны энэ амьдралын амьжиргааны бас эх үүсвэрийг дэмжиж энэ бас үйл ажиллагааг хий гэж байсан ч гэсэн хууль эрх зүйн платформ нь байгаагүй. Ямар нэгэн эрсдэл үүсэх юм бол хуулийн өмнө хариуцлага хүлээх ийм тогтолцоо бол байгаагүй. Тэгэхээр үүнийг хуульчилж өгч байгаагаараа энэ бол эрс шинэчлэл мөн гэж үзэх үндэслэлтэй.

Та сая хэлж байна. Монгол Улсад өнөөдөр нэг тэтгэвэр авагчийн тэтгэврийг төлөх гэж 3 хүн ажиллаж байна гэж. Яг статистик аваад үзэх юм бол 2,5 хүн гэж байгаа. Энэ удахгүй хүн амын дундаж наслалт ингэж өсөж байгаа үед 1/1 цаашилаад Япон улс шиг бүр ингэж өсөх хандлагатай байгаа. Ийм л учраас залуучууд нийгэмд энэ хуваарилалтын тогтолцоогоо болиоч ээ. Хувь хүн өөрийнхөө өмнө хариуцлага хүлээдэг, төлсөн шимтгэлтэйгээ уялдуулаад тэр хэмжээгээрээ тэтгэвэр авдаг шударга тогтолцоо руугаа шилжье гэж нэрийн дансны энэ тогтолцоо руу шилжиж байгаа. Тэгэхээр нийгэмд энэ хүсэн хүлээлттэй мөн энэ ойлголтын эв санааны зарчим гэдгийг бол бас олон хүн зөвшөөрөхгүй байна. Энэ зарчимтай уялдаж орж ирсэн хуулийн бас заалтуудыг ч гэсэн ард иргэд олон нийт дэмжихгүй ийм заалтууд бас олон байна гэдгийг танд тайлбарлаж хэлье. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хүний нөөцийн бодлогоо хэрхэн цаашиа авч явах талаар Булгантуяа сайд хариулаад, тооцоололтой холбоотой 1, 2 асуулт дээр манай Хишигбаяр дарга гүйцээгээд хариулья.

Г.Занданишатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулна.

Х.Булгантуяа: Эв санааны зарчим дээр ийм л асуудал үүсээд байгаа юм. Хэрвээ улс төрчид өөрснөө улс төр дагасан шийдвэрүүд гаргахгүй байсан бол энэ сан асуудалгүй байх байсан. 2012 онд тэтгэврийн шимтгэлийг нөхөж төлөх

тухай хуулиар 608 мянга орчим хүмүүс нөхөж төлөөд, 38 орчим тухайн үед тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Түүнээс хойш 1,5 бараг 2 их наяд төгрөг зарлагадсан байна. Үүнээс нөхөн төлсөн хүмүүсийн бараг тал нь тэтгэвэр авч эхэлсэн гэсэн үг. 2015 онд Эдийн засгийн өршөөлийн тухай хуулиар мөн адилхан нөхөн төлөөд л дараа нь ингээд л авчаж байгаа юм. Мөн малчны НДШ-ийг нөхөж төлөх тухай хуулийг 2 жил дараалан хэрэгжүүлсэн. Мөн тэтгэвэрт гарах насыг нь нааилуулсан гээд ингээд нөгөө энэ сан руугаа нийтдээ 11 удаагийн шийдвэрээр нийтдээ 5 их наяд орчим төгрөгийн зарлагыг энэ сангаас нөгөө ямар нэгэн хөнгөлөлттэй нөхцөл байдлаар ингээд гаргаад байгаа юм. Тэгэхээр дундын юм гэдэг бол дундын л байгаад байна гээд өнөөдөр НДШ төлж байгаа хүмүүс бухимдаад байгаа байхгүй юу. Бид нар энэ бүх шийдвэрүүдийг нь заримыг нь бол хүлээн зөвшөөрөхгүй байхад яагаад НДШ төлж байгаа би энэ бүх зарим нэг улс төржсөн шийдвэрүүдийг санхүүжүүлэх болчхов гэж яриад байгаа юм. Одоо 2040 оноос бүрэн хуримтлалын тогтолцоо руу шилжихээр 7 жил, 5 жил ч чухал биш болно. Би өөрөө хэчнээн их НДШ, тэтгэврийн шимтгэл миний нэрийн данс дээр бичигдэж нөгөөдөх нь мөнгөжиж байгаа. Би түүнийгээ л актуар тооцоогоор тооцоод л, би түүнийгээ л тэтгэвэр хэлбэрээр авна. Өндөр төлөх юм бол өндөр авна, олон жил төлөх юм бол их авна ийм л тогтолцоо руу бид нар ер нь явж байна гэсэн үг. Яг одоо ийм байдлаар яваад, энэ хууль дээр жишээлбэл жил болгон итгэлцүүрийг бид нар шинэчлэн батална. Жил болгон инфляцтай уялдуулж тэтгэврийг нэмэгдүүлнэ гээд. Энэ нөгөө улс төр дагасан шийдвэр биш, хууль дагасан хуулийн дагуу жил болгон болдог болчих юм бол энэ тэтгэврийн тогтолцоо гэдэг асуудал маань улс төржсөн ийм л тогтолцооноос л бид нар гарах ёстой л гэж л үзээд байгаа юм.

Тэгэхээр энэ бол магадгүй энэ удаагийн хуулийн хамгийн том шинэчлэлийн нэг байгаа болов уу гэж харж байгаа юм. Мэдээж зардал талдаа бол ачаалалтай зүйлүүд байгаа төсөв дээр. Тэгэхдээ яах вэ өнөөдөр бол манай тэтгэврийн сан, НДШ-ийн сан бол иргэд төлөөд, эргэж гараад, дээрээс нь нэмээд төрөөс хариуцдаг НДШ-ийг нь хариуцдаг иргэдийн шимтгэлийг төлөөд л энэ 2-ын дундаас одоогоор бол нэг баланстай л явж байгаа. Гэхдээ эс үгүй бол бид нар энэ зарлагаа бууруулах том арга хэмжээнүүдийг бусад хуулиудаар авах ёстой юм байна лээ. Бусад хуулиудаар. Одоо энэ хуулийг дагуулаад нэлээн олон хуулиуд орж ирэхэд жишээлбэл дуртай, дургүй байгаа салбарынхан жишээлбэл зөндөө байгаа. Тэгэхээр үүнтэй адилхан бид нар зарлагаа эс үгүй бол огцом бууруулах, орлогоо эс үгүй бол огцом нэмэгдүүлэх л арга хэмжээг авах ёстой. Тэгэхээр орлогоо нэмэгдүүлнэ гэхээр эс үгүй бол НДШ-ээ нэмнэ, эс үгүй бол хүмүүсийн цалин огцом нэмэгдэнэ. Эс үгүй бол хөдөлмөр эрхэлж НДШ төлж байгаа хүмүүсийн тоо өнөөдөр огцом нэмэгдэх ёстой байхгүй юу?. Цалин нэмэгдэнэ, шимтгэл нэмэгдэнэ, эс үгүй бол хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэнэ. Энэ 3 л нэмэгдэхгүй бол гурвуулаа нэмэгдэхгүй л бол. Тэгэхдээ Монгол Улс хүн ам бас харьцангуй залуу хүн амтай улс. Энэ бол ингээд хэрвээ зөв бодлого бариад явах юм бол нэмэгдэх боломжтой. Цалинг бол бид нар зах зээлийн эдийн засаг, чөлөөт эдийн засагт шилжсэн улсад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам ч гэдэг юм уу, Засгийн газар шууд тогтоох боломжгүй. Бид нар төрийн албан хаагчдынхаа цалинг л тогтоох боломжтой. Энийг нь бол төсвийнхөө орлоготой уялдуулаад л тогтоодог. Сая манай төрийн албан хаагчдын цалин дунджаар 40 гаруй хувиар бол нэмэгдсэн. Тэгэхээр энэ бол бид нар ингээд төсвийнхөө орлоготой уялдуулаад, ингээд Монгол Улсын эдийн засаг хөгжих юм бол, тэлэх юм бол хувийн хэвшил ч гэсэндээ бид нараас 20 гаруй хувиар төрийн албан хаагчдаас бол

20 гаруй хувиар илүү хувийн хэвшлийн дундаж цалин явдаг байж байгаа.

Г.Занданшатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн тодруулж асууна. 1 минут Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Миний хувьд мэдээж суурь шинэчлэл дээр бас учир дутагдалтай байна гэдэг нь энэ орлого, зарлагын тэнцэлтэй холбоотой энийг хангах ёстой асуудал дутмаг байгаа учраас энэ дээр ингэж байр сууриа илэрхийлээд байгаа юм. Тэгээд энэ бусад өөр амжилттай хэрэгжүүлж байгаа улс орнуудын тогтолцоог ч гэсэн та нар хэр хэмжээнд судалсан юм байгаа юм. Тэгээд энийг Монгол Улсын энэ тогтолцоонд ямар хэлбэрээр нь авч хэрэгжүүлэх юм бол илүү энэ орлого тал дээрээ, нэн ялангуяа эдийн засгийн эргэлт тал дээрээ ач холбогдолтой байна вэ гэдгийгээ бас үзэж ярилцах нь би зүйтэй гэж үзэж байна. Тэгэхгүй бол дандаа л ингээд л зарлагаа л нэмэгдүүлэх урсгалаа л нэмэгдүүлэх, төсөвт ачаалал үзүүлэх ийм л хэлбэрээр энийг шинэчлэл гэж бол үзэж болохгүй шүү дээ. Нөгөөтээгүүр энэ өнгөрсөн 30 жилийн хугацаанд БНСУ-д бараг манай нэг аймагтай дүйцэхүйц хэмжээний Хөдөлмөрийн хүчин.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэлсэн үү. Жамбын Батсуурь гишүүн алга байна. Хаслаа. Сандагийн Бямбацогт гишүүн алга байна. Хаслаа. Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: Монгол Улсыг 2050 он хүртэл хөгжүүлэх алсын хараа хөгжлийн баримт бичигт бол нийгмийн даатгалын тогтолцоог энэ амьдралын баталгаажих баталгааг хангах энэ хэмжээнд хүртэл шинэчилнэ гэсэн нэг ийм заалтыг оруулж байсныг санаж байна. Энэ орж ирж байгаа хуульд бол бас нэг энэ хувийн даатгалын тогтолцоог бас нэвтрүүлэх юм байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ хэд байдаг юм 100 даатгуулагч гэдэг юм

уу хэд гэдэг юм 100 даатгуулагчид оногдох тэтгэвэр авагчдын тоо яг өнөөдөр хэд байна. Цаашдын чиг хандлага ер нь ямархуу байна. Ийм эхний асуулт байна.

Тэгээд энэ тоо ер нь цаашидаа яг өнөөдөр хэд байна. 2025 он ч юм уу, 2030 он хүртэл ямар байна гэсэн. Ер нь энэ улс орнуудад тэтгэвэр тогтоолгосны дараа хүний амьдралын амьдрах насны хэмжээ гэдэг юм уу даа хэчнээн байна. Өнөөдөр яг Монголд. Цаашидаа мэдээж өсөж таарах байх. Энэ тооцоо, судалгаанууд ер нь юу байдаг юм бэ гэсэн дараагийн асуулт байна. 2 дахь асуулт.

Энэ 7 жилийг 5 жил гээд явж байгаа. Тэгэхээр энэ дээр яах вэ, ард иргэдийн дунд бас нэг тийм яриа байна л даа. Сүүлийн 5 жилд өндөр тэтгэвэртэй, даатгалд өндөр мөнгө төлж байгаад тэгээд их өндөр тэтгэвэр тогтоолгоод нийгмийн даатгалын сан хоосорно гэсэн нэг ийм эрсдэл ярьж байгаа байхгүй юу. Тэр ч бас ортой байж магадгүй. Өнөөдөр ингээд 7-г 5 жил болсноос урьд нь тэтгэвэр тогтоолгочихсон Монгол Улсын бүтээн байгуулалтад оролцож явсан энэ ахмадуудын юунд ашиг муутай юм. Тийм учраас энэ харьцааг яаж төлөвлөж байна гэсэн ийм асуултууд байдаг юм. Тэгээд энэ дээр ямар эрсдэл байна гэсэн.

Тэтгэвэр өвлөгдөнө гэж байгаа тийм ээ. Хамтран амьдрагчид нь өвлөгдөнө гэж байгаа юм. Энд ер нь жилд ямархуу хэмжээний хүн өвлөгдөж болох вэ, ямар тооцоо байна.

Дараагийн асуулт малчдын нийгмийн даатгалын хамрагдах юм бол 50 хувийг нь төр даана гэж байгаа юм. Энэ дээр ямар тооцоо байна. Жилд ямар хэмжээний мөнгө энэ сангаас гарахаар байна.

Хамгийн сүүлчийн асуулт ер нь бол аливаа зүйл эдийн засгаараа баталгааждаг. Сангийн яам энэ

тэртэйгээ яриад орж ирж байгаа гэж байгаа. Энэ ирэх жилүүдэд бол манай Монгол Улсын эдийн засгийн өсөлт хамгийн дээд тал нь 4-4,5, 5 орчим хувь өснө гэсэн ийм тооцоолол байгаа. Тэгэхээр энэ нийгмийн даатгалын сангийн зарлагын өсөлт маань эдийн засгаараа ер нь яаж баталгаажиж байгаа юм бэ. Эдийн засгаар баталгаажиж байгаа ямар ч ажил бол амь сүнсгүй байдаг шүү дээ. Тэгээд баахан юм нэмнэ, ингэнэ тэгнэ гээд ингээд шийдвэр гаргачихдаг. Сан маань даахгүй болдог. Төсвөөс татаас авдаг ийм хэлбэр лүү орчих юм биш байгаа гэсэн ийм болгоомжлолууд байна. Ийм асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин. Ажлын хэсгийн ахлагч хариулна.

П.Анужин: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн нэг шимтгэл төлөгчдөд хэдэн тэтгэвэр авагч ноогдож байна вэ гэж та асууж байна. Өнөөдрийн байдлаар 2,5 хүн 1 тэтгэвэр авагчийн тэтгэврийг төлж байна гэсэн ийм судалгаа бол Монгол Улсад байна. Энэ дундаж наслалтын талаар 1995 онд нийгмийн даатгалын багц хууль батлагдах үед тэр үеийн хүн амын дундаж наслалт өнөөдөр бид нар энэ 30-аад жилийн дараа Нийгмийн даатгалын энэ багц хуулийг хэлэлцэгдэх үеийн хүн амын дундаж наслалт бол 7,5 хувиар нэмэгдсэн байгаа. Тийм учраас бид нар цаашидаа урт хугацаанд тэтгэвэр авагчдаа дэмжсэн, тэтгэврийн насыг бас бага багаар, аажим хугацаандаа бас уртасгах энэ бодлогыг бас баримтлах зайлиггүй ийм шаардлага үүсэж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Ер нь олон гишүүд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын талаар хэтэрхий алдагдалтай ажиллаад байгаа юм биш үү гэдэг асуултыг асууж байна. Ер нь хатуу хэлэхэд нийгмийн даатгалын сан бол улс төрөөс хол байх хэрэгтэй. Олон жил амласан худлаа үнэн тооцоотой, тооцоогүй сонгуулийн өмнөх амлалтаас болж энэ нийгмийн

даатгалын санд асар их урьдчилсан актуар тооцоололгүй ийм гарлагууд гарч ирсэн. Мөн улс төрчдийн хий попорсон амлалт нийгмийн дунд, ард түмний дунд өндөр хүлээлт үүсгэчихдэг. Тэр хүлээлт нь биелэхгүй болохоор муу хууль гэж үздэг. Тэгэхээр эдгээр бүх л тохиргоонуудыг, эдгээр олон жилийн улс төрийн завхралыг засахын төлөө ажилласан, шударга зарчим дээр үндэслэсэн ийм л хууль дээр бид нар ажилласан. Ийм хуулийг бол бас Засгийн газраас өргөн барьсан гэж үзэж байгаа. Хүмүүс бол энэ реформыг бүх хүнд таалагдаж, бүх хүнд таалагдсан, сайхан энэ бүхэл 3, 4, 5 нийгмийн бүхий л оролцоог хангасан ийм хуулийг бас хүсэж байна. Аливаа реформбас өвдөлтгүй гардаггүй. Аливаа реформд бол бид нар өөрчлөх, шинэчлэх, ялангуяа шударга ёсны зарчимд үндэслэсэн энэ зүйлийг бас нийгмээрээ хүлээн зөвшөөрч байж бид нар энэ нийгмийн даатгалын реформ гэдгийг хийх ёстой гэдгийг бас хэлье.

Тэтгэвэр өвлөгдөх талаар бол энэ хуульд маш тодорхой суусан. Тэтгэвэр ямар нөхцөлд өвлөгдөх вэ гэхээр бид нар энэ хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлал үе шаттайгаар бүрэн хуваарилалтын хуримтлалын тогтолцоо руу шилжих гэж байна. Үүнийгээ бас бид нар хуульдаа маш тодорхой заасан. Нэрийн дансыг бид нар мөнгөжүүлж, өөрийн нэрийн данс дээр байгаа энэ мөнгөн хуримтлалаа эргэн 2030 оноос, мөн энэ маань бас хэрэгжилт нь Ирээдүйн өв сантайгаа уялдаж байгаа юм. Ирээдүйн өв сангаас орж ирэх орлоготойгоо уялдаж байгаа. Ингээд иргэн маань өөрийнхөө ипотека, эрүүл мэнд, боловсролдоо бас зарах ийм бүрэн эрх нь энэ хуулиар бас үүсэж байгаа юм.

Тэр малчдын 50 хувь ямар тооцоолол байгаа юм бэ гэдгийг манай Хишигбаяр дарга тодорхой хариулъя.

Г.Занданшатар: 83 Хишигбаяр. Төрийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэгч.

А.Хишигбаяр: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Монгол Улсад 220 гаруй мянган НДШ төлөх малчид байна. Үүний 25 хувь нь өнөөдөр НДШ төлж байна. Бусад 75 хувь нь өнөөдөр шимтгэл төлөхгүй болохоор ирээдүйд тэтгэвэр тогтоолгох нөхцөл, өнөөдрийн бас нийгмийн хамгааллын асуудал бол баталгаа алдагдаад байгаа. Энэтэй холбоотой бид бол бас малчид ялангуяа хамгийн их эрсдэлтэй цаг уурын нөхцөл байдалд эрсдэлтэй ийм ажлын байранд ажилладаг учраас ямар нэгэн байдлаар бол НДШ төлж, нийгэм баталгаагаа хангуулах нь шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ учраас бид нар нийгмийн даатгалын багц хуулийнхаа төсөлдөө бол малчдын шимтгэлийн 50 хувийг төр хариуцахаар, 50 хувийг өөрөө хариуцахаар хуулийн төсөлд оруулж ирсэн байгаа. Ингэснээр бол улсын төсвөөс жилдээ 25 тэрбум төгрөгийн зардал Нийгмийн даатгалын сан руу малчдын шимтгэлд төлөх нь. Гэхдээ малчин өөрөө 50 хувиа төлөх учраас нийгмийн даатгалын сан бол 50 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого нэмэгдэнэ гэсэн ийм байдлаар бол тооцоод явж байгаа. Энийг тооцохдоо бол нийтдээ 88,9 мянган малчны НДШ-ийг бол улс төлөхөөр байна гэсэн ийм тооцоолол хийсэн байгаа.

Мөн нийгмийн даатгал тэтгэвэр авагч эмэгтэй хүн хэчнээн жил тэтгэвэр авч байна вэ, эрэгтэй хүн хэчнээн жил тэтгэвэр авч байна вэ гэсэн ийм асуулт байсан. Нийгмийн даатгалын сангийн тоон мэдээлэл дээр бид нар тооцоолол хийгээд үзэхэд бол эрэгтэй хүн 15 жил тэтгэвэр тогтоолгосноосоо хойш 15 жил тэтгэвэр авч байгаа. Эмэгтэй хүн бол 22 жил тэтгэвэр авч байна гэсэн ийм тооцоо судалгаа бол байгаа.

Мөн нийгмийн даатгалын сангийн чадавч ялангуяа тэтгэврийн даатгалын чадавч хэр байна вэ. Та бүхэн тооцож үзсэн үү гэж асууж байна. Бид нар бол аль болох бас Нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх дээр илүү

бас ажилласан байгаа. Яагаад гэвэл ирээдүйд бол Монгол хүний насны бүтцэд өөрчлөлт орох гэж байна. Тэтгэвэр авагчийн тоо маш ихээр нэмэгдэх гэж байна. Тийм учраас аль болох шимтгэлийн хувь хэмжээг нэмэхгүй байдлаар хамралтаа нэмэх асуудлыг бол бид нар ялангуяа энэ малчин, хамрагдахгүй байгаа ажилгүй хүн энийг хэрхэн яаж хамруулах вэ гэдэг дээр хуулийн төсөл дээрээ бид нар бол илүү нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлах хэрэгтэй байна. Тодорхой хэмжээгээр НДШ төлөх хөшүүргийг бол оруулж ирэх ёстой байна. Тэтгэврийн насны тухайд бас бид нар 2018 онд өөрчлөлт оруулчихсан. Шимтгэлийн болзол хангахгүй бол насыг 3 сараар нэмэгдүүлж байгаа. Шимтгэлийн болзлоо хангахгүй хүн бол эмэгтэй хүн 55, эрэгтэй хүн 60 насандаа тэтгэвэр тогтоолгох нөхцөл маань хэвээрээ байгаа гэх зэргээр бол шимтгэлийн насыг нэмэгдүүлэх байдлаар бид нар 2018 оноос бол шинэчлэл хийгээд явчихсан байгаа.

Мөн ахмад настны тоо нэмэгдэх гэж байгаа учраас цаашидаа бол ахмад настнаа илүү урт хугацаанд ажиллуулах, олон жил ажилласан, илүү урт хугацаанд ажилласан ахмад насныхаа тэтгэврийг нэмэгдүүлэх байдлаар тэтгэврийн бодолтдоо бол бид нар үе шаттай бас шимтгэлийн тэтгэвэр бодох аргачлалаа өөрчилж бол илүү олон жил ажилласан ахмадын тэтгэвэр өндөр байх, цөөхөн жил ажилласан, шимтгэл төлсөн хүний тохиолдолд тэтгэвэр нь бага байх ийм шударга тогтолцоо руу оруулахаар бол аргачлалаа бол оруулж байгаа. Гэхдээ бол өнөөдөр хууль хэрэгжээд шууд хэрэгжүүлээд явах юм бол хүний бас нийгмийн баталгаа дордох асуудал үүсэж байгаа учраас 2029 оноос бол яг шударга тогтолцоо руу оръё, шударга бодъё гэдгээ бол хуульчлаад явж байгаа.

Мөн шинэ актуар тооцооллыг бол бид нар бас Дэлхийн банкаар 2 удаа хийлгэсэн. Бүх параметрүүдээ өгөөд, энэ параметрээр бид нар хуулиа өөрчилбөл даатгалын сан цаашидаа хэрхэн, яаж явах

вэ гэдэг энэ заалтуудыг бол бүгдийг нь өгч бодуулж үзэж байгаад бид нар даатгалын сан дээр хэтэрхий их ачаалал гарч байгаа энэ параметрийг бол та нар хэрэглэх хэрэггүй гэдэг зарим зүйл заалтуудыг бол бид нар бол бас хасаад найруулаад явсан байгаа.

7 жилийн цалингийн дунджаар тэтгэвэр тогтоолгож байгаа асуудлыг бол бид нар энэ хуулийн төсөл дээр бол 5 болгож оруулж ирж байгаа. Тэгэхдээ энэ бас яагаад 7 байж байгаад 5 болж байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: 83 гүйцээгээд хариулчих. Яагаад 7 байж байгаад 5 болж байгаа биш. Ямар эрсдэл үүсэх вэ гэж асуугаад байна шүү дээ. Товч тодорхой хариул.

А.Хишигбаяр: 7 жилийн дунджаар тэтгэвэр тогтоолгох анх бол энийг яагаад нөгөө 5 жил байсныг 7 жил болгосон бэ гэх юм бол илүү нөгөө сайн дурын даатгуулагч ялангуяа эхний жилүүдэд, ихэнх жилээ бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу хамгийн бага шимтгэл төлж байгаа. Тэгж байгаад сүүлийн 5 жил маш өндөр хамгийн дээд хэмжээгээр төлж өндөр тэтгэвэр авч байна. Энэ нь өөр өөрөө шударга биш байна гэдэг асуудал яригдаж байсан. Ийм учраас бол бид нар 5-ыг 7 болгож оруулсан байсан. Одоо бол цаашидаа бид нар бол 7 буцаагаад 5 жил болгож энэ хуулийн төсөлд оруулж ирж байгаа. Гэхдээ бид нар дахиад шударга байдлыг бол бас зохицуулах ёстой гэж үзсэн. Ийм учраас сайн дурын даатгуулагчийн төлж байгаа дээд хэмжээ өнөөдөр 5 сая 500-аас тооцож шимтгэлээ төлөөд буцаагаад тэтгэврээ тогтоолгож байгаа энэ өндөр төлж байгааг нь тодорхой хэмжээгээр шимтгэлийн хувь хэмжээтэй нь уялдуулан бууруулсан байгаа. Тийм учраас цаашидаа бол шударга байдал бол харьцангуй бол тогтоод явах боломжтой гэж харж байгаа. Тэгээд 7-г 5 болгож бууруулсан байгаа.

Г.Занданишатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асууя. Нэмэлт асуулт 1 минут.

Б.Баттөмөр: Тэр 7-оос 5 болоход асуусан асуултад онож хариулахгүй л байна л даа Хишигбаяр аа. Хамгийн гол нь яах вэ, энэ шинээр тогтоож байгаа хүмүүс энэ дээр бас өөрчлөлт гарна. Тогтоолгочихсон, урьд нь байсан энэ ахмадууд, санд чинь ямар нөлөөлөл үүсэх вэ гэдгийг тэр дараагийн юм дээр хариулчхаарай. Энд бол Нийгмийн даатгалын сан улс төрөөс ангид байна гэдэгтэй санал нэг байгаа юм. Улс төрөөс ангид байхын тулд өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг байх ёстой байхгүй юу. Улсаас татаас аваад байх л юм бол улс төрөөс ангид байж чадахгүй шүү дээ 1 дүгээрт.

2 дугаарт энэ энэ нийгмийн даатгалын сан бол юу гэхээр энэ бүтээмж гэдэг юмтайгаа их уялдаж байх ёстой. Ялангуяа аж үйлдвэрт гарч ирэх энэ бүтээмжийн өсөлттэй бол шууд холбоотой. Уул уурхайгаас бол хамгийн гол нь ажлын байр бага бий болгодог шүү дээ. Энэ утгаараа бол аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлд их зүйл л хийх шаардлага байгаа юм л даа.

Г.Занданишатар: 83. Ямар эрсдэл байна гэхээр эрсдэлгүй л гээд байна.

А.Хишигбаяр: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Өргөн барьсан хуулийн төсөлд бид бол өмнө 2009 оноос хойш 7 жилээр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг нь дахин шинэчилж бодож болно гэдэг заалт бол оруулсан байгаа. Харин нөхөн олгоно, тэтгэврийг нь нөхөн олгоно, зөрүүтэй хүнийг нь нөхөн олгоно гэдэг ийм хуулийн заалт бол байхгүй байгаа энэ хууль дээр. Гэхдээ бид бол тооцоо бодсон байгаа юм. Хэрвээ бид нар нөхөж олгохоор бол хэчнээн төгрөгийн зардал гарах юм бэ гэдгийг бол тооцсон байгаа. Нийтдээ 58 мянган тэтгэвэр авагч бол 6, 7 жилээр тэтгэврээ бодуулсан байна. Хэрвээ

нөхөж олгох юм бол 91 тэрбум төгрөгийн зардал гарна шүү гэдэг ийм тооцоог бол хийсэн байгаа.

Г.Занданишатар: Пүрэв-Очирын Анужсин гишүүн хариулъя.

П.Анужсин: Гишүүдийн асуултад бас нэг зүйлийг тодруулж хэлэх нь зөв байх. Улсаас авч байгаа татаас нь их, нийгмийн даатгалын сан алдагдалтай гээд яриад байдаг. Жишээлбэл энэ жилийн хувьд бол нийгмийн даатгалын сан алдагдалгүй байгаа. Энэ улсаас авч байгаа татаас гэдэгт ерөөсөө гуравхан зүйл ойлголт байгаа юм.

1 дүгээрт 1995 оноос өмнө НДШ төлж байсан хүмүүсийн шимтгэлийг улс хариуцдаг. Энэ шимтгэлийг.

Хоёрдугаарх нь цэрэг. 21 мянган орчим цэргийн асуудал байгаа. Зарим хүмүүс гээд бас улс төрийн шийдвэр гаргаж байсан ийм хүмүүсийн НДШ-ийг бол улс хариуцаж, улсаас энэ нийгмийн даатгалын сан руу оруулдаг. Тэгэхээр энийгээ улсын татаас гэж бас хольж яриад байгаа нь өөрөө Нийгмийн даатгалын сан улсаас татаас авч алдагдалтай ажилладаг юм шиг харагдаад байдаг. Тэгэхээр энийг манай яамныхан өнөөдрийг хүртэл бас хүрч ирсэн нийгмийн даатгалын сангийн тогтолцоо маань өөрөө сайн тогтолцоо байсан гэдгээ бас тайлбарлаж өгөх ёстой шүү. Болохгүй, бүтэхгүй юм болчхоод өөрчлөх гээд байгаа биш, улс төрөөс ангид байж улс төрийн энэ огцом шийдвэрүүд гараагүй.../минут дуусав/

Г.Занданишатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Нийгмийн даатгалын багц хуулийг Байнгын хорооны дарга бол нэлээн тийм реформын шинжтэй гээд байна л даа. Би бас эргүүлж тойруулж харж үзлээ. Үнэхээр эндээс тийм реформын шинжтэй юм бол би харсангүй. Яагаад гэхээр энэ яг нийгмийн

даатгал юм уу, энэ бараг төрийн татвар юм уу, аль эсвэл энэ төрөөс олгодог гэдэг халамж юм уу гэдэг нь үнэндээ энэ хууль урьд нь ч тэгж явж ирсэн. Одоо яг энэ дээр эцсийн хариулт байхгүй. Нийгмийн даатгал гэдэг чинь төлсөн хэмжээгээрээ, аливаа даатгал гэдэг чинь төлсөн хэмжээгээрээ эрсдэлээ буцаагаад ирээдүйгээсээ эрсдэлээ хамгаалуулдаг тэр зүйлийг хэлдэг. Тэгвэл энэ манай тогтолцоо ийм билүү. Энэ даатгал мөн үү. Нөгөө талаасаа 20 хэдэн хувиар хурааж аваад тэгшитгээд хуваагаад эв хамт гээд явж байгааг нь харахаар энэ улсын зүгээр даатгал биш татвар юм шиг. Бас нөгөө талаасаа тэр тогтоолгож байгаа, шимтгэл төлж байгаа хүмүүсийг хэдэн хүүхэдтэйгээр нь, нийгмийн аль бүлгээр нь, аль эсвэл ямар ажил мэргэжил, цэрэг, цагдаад ажилладаг гэдгээр нь шимтгэл авдаг, буцааж тэр тооцдог аргачлалууд нь ялгаатай байдлуудыг нь бодохоор зүгээр нийгмийн халамж юм шиг. Яг л энэ хэвээрээ л байгаа. Тэгснээ зарим зарим зүйл дээр төрөөс дааж байгаа, улсаас төлнө гэдэг. Ер нь төрийн мөнгө, улсын мөнгө гэж байхгүй шүү дээ. Сангийн яамны зооринд баахан сейфт мөнгө хийчихсэн улсын мөнгө өгч байгаа зүйл хаана ч байхгүй шүү дээ. Нэг бол иргэдийн даатгал, шимтгэл байгаа, нөгөө бол татвар байгаа. Бүтэн жилээрээ урсгал зардлаа тооцоод мөнгөн урсгалаа тооцоод, орлого, зарлагаа тооцоод л явж байгаа. Тэнд хурааж хуримтлуулчихсан нь улсын мөнгө гэдэг зүйлээс, төрийн мөнгө гэдэг зүйлээс хэн нэгэн гаргаж өгөөд тэрийг нь төлчихдөг тийм зүйл үүний цаана ямар ч мөнгө байхгүй шүү дээ. Тэгэхээр татвар ч юм шиг, даатгал ч юм шиг, нийгмийн даатгал юу аль нь бүү мэд. Тэгээд цаана нь баахан улсын мөнгө, төрийн мөнгөөр төлчихнө, нөхчихнө, тэрийг нь хариуцаж байна гэдэг ийм үзэл санаа хэвээрээ явж байгаа энэ тогтолцоо чинь яг л хэвээрээ байна шүү дээ. Тэгэхэд энийг реформ энэ тэр гээд гоё үгээр цаана нь юм яриад байх юм. 2 хувийн асуудлыг тэр реформ мөн үү, биш үү бүү мэд.

Харин зүгээр авууштай зүйл, хөгжих ёстой зүйл нь энэ дээр тэр хувийн тэтгэврийн сангийн тухай асуудлын тэр боломж бололцоо нээгдэж байгааг ямар ч байсан энэ хуулийн бас нэг тодорхой хэмжээний дэвшил гэж үзэхээс аргагүй. Тэгэхээр үнэхээр энэ дээр реформын шинжтэй ямарваа нэгэн зүйл алга. Даатгал, татвар, халамж 3-ыг дунд нь холиод базаад гаргачихсан зүйлийг ямар юмны реформ хаана нь юу байдгийг би бол эндээс олж харсангүй.

Г.Занданишатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн

П.Анужин: Одонгийн Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Таны шүүмжлээд байгаа наад шимтгэл төлөөд л байдаг, тэгээд өөртөө ямар ч үр дүнгүй байдаг. Өөрөө тэгээд хэрэглэдэг ч юм уу бусдын юмыг төлөөд байдаг гэсэн энэ эв санааны зарчим дээр үндэслэсэн хуваарилалтын тогтолцооноосоо л өөрчлөгдөх гээд, хуримтлалын тогтолцоо руу шилжих гэж байгаа шүү дээ. Яг таны наад шүүмжлээд, дургүйцээд байгаа юмыг чинь өөрчлөх гэж байгаа, тогтолцоог өөрчлөх гэж байгаа энийг бол шинэчлэл гэж харж байгаа. Хуулийн шинэчлэл мөн. Эндээс тэдэн төгрөг, эдэн төгрөг авна гээд яриад байгаа юм ерөөсөө биш. Тийм дампуу хууль шинэчлэл гэж байхгүй. Энийг бол тийм зүйлийг хэлээгүй. Реформыг хийхэд тодорхой төсөв шаардлагатайг та бол хэнээр ч хэлүүлэлгүй мэдэж байгаа. Ард иргэдийн дунд, таны сонгогдсон сонгогчдын дунд бид нарын тэтгэвэр үнэ цэнтэй болж чадах юм уу, жил бүр өсөн нэмэгдэж байгаа инфляцаа дийлэх юм уу, инфляцтай уялдах юм уу. Бид нарын энэ арай гэж насаараа тогтоолгосон тэтгэвэр чинь худалдан авалтаа дийлэхгүй байна гэдгийг энэ хууль зохицуулж өгч байгаа. Монгол Улсын Нийгмийн даатгалын багц хууль бол инфляцтай уялдуулж жил бүр тэтгэврийг шинэчлэн тогтооно гэсэн энэ зоригтой зүйлийг хуульд бол анх удаа

хуульчилж өгч байгаа шүү. Энэ бол олон жил ажилласан, зүтгэсэн, хуримтлуулсан мөнгөө яг тэр өнөө үеийнхээ үнэ цэнтэй дүйцүүлж авдаг ийм том шинэчлэл байгаа гэдгийг бас хэлье. Тэгэхээр энэ олон параметруудийг тооцож хийсэн актуар тооцооллыг бас та бас хараахан тэгж бүрэн хэмжээгээр нь үгүйсгэж болохгүй ээ гэдгийг хэлэх гэсэн юм.

Ер нь энэ хүмүүс халамж юм уу, тэтгэмж юм уу, даатгал юм уу гээд байна. Энэ чинь тэтгэврийн, тэтгэмжийн хууль бас хамт орж ирж байгаа шүү дээ. Энэ багц хуульд чинь тэтгэмжийн хууль байгаа. Тийм учраас бид нар тэтгэмжээ ярина. Энэ дотор чинь тэтгэврийн хууль байгаа. Тэгэхээр бид нар тэтгэврээ ярина. Эд нарыг хольж яриад байгаа юм байхгүй. 5 хууль зэрэг орж ирж байгаа гэдгийг бас танд хэлье.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас үлдсэн зүйлд нь Хишигбаяр дарга хариулъя.

Г.Занданшатар: Хишигбаяр 83.

А.Хишигбаяр: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгалын тогтолцоо өөрөө хуваарилалтын, хуримтлалын гэх зэрэг олон тогтолцоо байдаг. Монгол Улс бол 1995 оноос эхлээд хуваарилалтын тогтолцоо буюу эв санааны нэгдлийн зарчимд үндэслэсэн энэ тогтолцоог бол сонгож авсан байгаа. Энэ хуулийн төсөл дээр бид нар цаашидаа хагас хуримтлалын тогтолцоог үе шаттай ороод, цаашидаа 2040 оноос бол бүрэн хуримтлалын тогтолцоо руу орно гэдэг энэ хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд бид нар оруулж өгч байгаа. Энийг өнөөдөр шууд хуваарилалтын тогтолцоо руу шилжинэ гэвэл Монгол Улсын нөхцөл байдал эдийн засгийн хувьд бид нар бол хийх боломжгүй. Монгол Улс яагаад гэх юм бол бүх хүний өнөөдрийн тэтгэврийг бүгдийг нь бид нар бэлэн мөнгө болгож хадгалаад, тэгээд тэр

хүмүүсийнхээ ирээдүйд тэтгэвэр гарах асуудлыг шууд шийдээд явна гэвэл өнөөдрийн тэтгэвэр авагчийн тэтгэврийн зардлыг бид нар хэрхэн хаанаас яаж бүрдүүлэх вэ гэдэг асуудал бол гарч байгаа. Тэгэхээр Монгол Улс өнөөдөр 30 жил хуримтлалын тогтолцоогоор явчихсан, хуваарилалтын тогтолцоогоор явчихсан. Мөн 1995 онд тогтолцоо үүсэхээс өмнө маш олон хүн ажил хөдөлмөр эрхэлсэн тэр хугацаагаараа өнөөдөр тэтгэвэр тогтоолгочихсон байна. Тэр хугацаагаараа өнөөдөр нийгмийн даатгалын тогтолцоо үүсээгүй үед ажил хөдөлмөр эрхэлж байсан хүмүүс тэр хугацаагаараа өнөөдөр бас дахиад тэтгэвэр тогтоолгохоор хүлээгээд явж байгаа учраас бид бол шууд хуваарилалтын тогтолцоо руу ороод өнөөдрийн шимтгэл төлөгчийн мөнгийг шууд өөрт нь хадгалуулаад явах юм бол өнөөдрийн тэтгэвэр авагчдын зардлыг бид нар төлөх боломж байхгүй ээ. Ийм учраас бол бид нар үе шаттай орох нь бол зүйтэй гэж байгаа. Монгол Улсын урт хугацаа, богино, дунд хугацааны бүхий л бодлогын бичиг баримт дээр бол цаашидаа үе шаттайгаар хагас хуримтлал, бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжинэ гэсэн ийм зорилго зорилт тавьж ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Тэгээд энд ер нь байна шүү дээ. Мэдээж нийгмийн бодлогын чиглэлээр бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ажлын хэсэг сайн ажилласан байна. Тэгэхдээ улс төрждөггүй байж байгаад илүү улс төрийн шийдвэр гаргаж байгаа шүү. Энэ төсвийн дарамт ачаалал байдаггүй гэж ярьж болохгүй. Төсвийн татаас алдагдлаар нөхөж энэ санхүүжилт явж байгааг тоон дээр бүгд баталж байгаа. Төсөв батлахдаа

татаас батлаад явж байгаа шүү дээ. Тэгээд тэтгэвэр гэдэг бол урт хугацаанд авч үздэг нарийн тооцоолол. Яг өнөөдөр таалагдах гээд Пүрэвдорж гишүүний 7-оос 5 жил болгоно гэдэг хүмүүст ингээд таалагдаад байгаа юм шиг энэ маш эрсдэлтэй алхам хийж байгаа шүү энэ. Хожим бол энэ тэтгэврийн даатгалын сан даахад маш их эрсдэл үүснэ. Эийг бүрэн актуар сууриар тооцож үзсэн юм уу гэдэг нь эргэлзээтэй хариултууд өгөөд байна шүү. Яг бодоод үзэхээр. Тэгээд 2029 оноос шударга болно ч гэх шиг. Энэ актуар суурь гэдэг чинь 50 жилийн дараа ийм тэтгэврийн зардал гаргахад одоо ямар хуримтлал үүсгэх юм бэ гэсэн тооцоолол байхгүй юу. Энд 40 жил ажилласан хүн байна шүү дээ.

Цэвэрлэгчтэйгээ адил 40 жил багшаар ажилласан Долгорсүрэн гэдэг хүн 2008 онд тэтгэвэр гарахдаа 593 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа одоо. Одоо бол 5 жилээр тооцоход 1 сая 370 мянган төгрөгийн тэтгэвэр авах юм байна. 2008 онд тэтгэвэрт гарсан. 7 жилээр тооцоод 800 мянгаас дээш тэтгэвэр авч байгаа хүмүүс бүүр илүү их нэмэгдэнэ. Сүүлийн ер нь жилд дунджаар 40 мянган хүн тэтгэвэрт гаргагдаас 3 мянга нь сүүлийн 5 жилд 7 жилд өндөр төлөөд, насаараа 40 жил багш хийж байгаад гарсан хүмүүсээс сүүлийн 5 жилд ер нь ингээд бусад жилийн шаардлагуудыг ингээж НДШ төлж явж байгаад энийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн сайн дурын даатгал 7 жил нэмэгдүүлснээр хязгаарлана гэвэл бүтэхгүй ээ. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ чинь өссөөр л байх болно цаашдаа. Энэ дээр актуар суурийн тооцоолол нь шал худлаа. Ирээдүйд нийгмийн даатгалын санг энд дампууруулах юм хийж байгаа шүү. Өнөөдөр ингээж Пүрэвдорж гишүүний энэ санал зөв юм шиг санаж дагаж бид нар попорч байгаад, Нийгмийн даатгалын санд маш том эрсдэл учруулах алхам хийх гэж байгаа юм. Хамгийн том эрсдэл нь энэ. Бусад

чиглэлээр тодорхой ахиц дэвшил байгааг үгүйсгэхгүй. Тэгээд бүр хуримтлал руу шилжинэ гэдэг бол энэ солидарнст буюу Бисмарк Германы тэр эв санааны нэгдлийн зарчим бол нийгмийн чиг баримжаатай, нийгмийн хамгааллын зөв бодлогын суурь философи байсан. Эндээс хуримтлал руу буюу илүү капиталист зарчим руу шууд шилжиж чадахгүй, манай нийгмийн даатгалын сан даахгүй, алдагдалтай байгаа. Энийг чинь суурийг нэмэгдүүлэх юм хамгийн гол та нар хийх ёстой байсан юм бол индексжүүлээд, зарлагаа нэмэгдүүлээд байдаг, тэтгэврээ нэмэгдүүлээд байдаг, тэр орлогыг өсгөх юмыг хэзээ ч хийхгүй хуримтлуулна гэдэг чинь өсгөх юмыг санг өсгөн арвижуулах юмыг дандаа хулгай нүүрлэж, банканд хүүтэй, хүүгүй хадгалуулсан хэлбэрээр суурь биш, Нийгмийн даатгалын сангаа цөлмөсөнд нийгмийн даатгалын сангийн хамаг том проблем байгаа байхгүй юу. 1990 онд төлж байсан цалингийн хэмжээ одоо болтол тэр индексээрээ өсөж, хуримтлал нь тооцогдож л байх ёстой байсан байхгүй юу. 1995 оноос хойш. Нийгмийн даатгалын санд чинь орчихсон байгаа хулгайнхаа нүдийг хааж энийг өсгөн арвижуулдаг систем тогтолцоо хийхгүйгээр нийгмийн даатгалын сан хэзээ ч үр ашигтай болохгүй. Энэ дээр хамгийн том реформ хийх ёстой заалтууд байхгүй. Энэ 3 талт хяналт тавих зорилгоор 3 талт хороо гэж байгуулсан чинь тэр нь бас үр ашигтай биш. Хулгайны тогтолцоо бараг болчихлоо. Нийгмийн даатгалын сан яаж байришиж байгаа, үлдэгдлээс яаж шимтгэл хураамж банканд хадгалуулж мөнгө цохидог байсан чинь шалгагдаж байгаа шүү дээ.

Улсын мөнгө гэж байхгүй, татвар төлөгчдийн мөнгөөр нийгмийн даатгалын сангийн алдагдал тэтгэврийн сангийн даатгалаас төлөх гээд байгаа энэ систем дээр чинь хамгийн том асуудал байна л даа. Энийгээ бид нар засаж залруулж чадахгүй бол нийгмийн даатгалын реформ хийж чадахгүй. Тийм учраас энэ хуримтлал болохоосоо илүү

тэнд хулгай нүүрэлдэх системээ хаах хэрэгтэй. Хамгийн гол юм нь бид нарын энэ 7-оос 5 жил болоход бол маш их эрсдэл гарна шүү. Тооцоолж чадахгүй эрсдэлүүдээ та нар хялбараар тайлбарлаж байна шүү.

Ер нь манай нийгмийн даатгалын газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд актуар тооцоолол хийдэг хүн байдаг юм уу гэдэг эргэлзээ төрчихлөө надад. Энд хариулж байгаа бүх байдлыг харахад актуар тооцооллоо ойлгож байгаа, мэддэг хүн байгаа юм уу гэдэг асуудал эргэлзээ төрчихлөө. Дэлхийн банкны судалгаа яриад байгаа. Дэлхийн банкны судалгаа чинь 2030 онд нийгмийн даатгалын сан 30 их наядын алдагдал хүлээнэ гэсэн тооцоо байгаа шүү. Өмнө нь хийж байсан тооцоолол.

Тэгээд дандаа түр орлон гүйцэтгэгч нар байгаа учраас хоноцын сэтгэлгээгээр түр байж байгаа юм чинь гэдэг сэтгэлээр хандаад байдаг юм шиг сэтгэгдэл төрж байна. Ирээдүйд нийгмийн даатгалын сангаа яаж зөв үр ашигтай болгох вэ гэдэг тогтолцоонд бага л анхаарсан байна. Ингээд Байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 33 санал байгаа.

Мөнхбаатар дарга ирцээ бүрдүүлээд, саналаа хураа.

Ер нь бол энэ тэтгэвэр тогтоолгох 7 жилийг 5 жил болгож байгаа нь Монгол Улсын Их Хурлаас баталсан Төрөөс тэтгэврийн шинэтгэлийн талаар баримтлах бодлоготой нийцэхгүй байгаа юм. Энэ чинь яагаад 7 жил болгосон гэхээр 5 жил байсныг 2030 онд, 2025 онд 10 жил болгохоор 10 жилийн цалин хөлсний дунджаар тооцохоор тийм чиглэл, бодлого баримтлаад дунд нь 7 жил болгосон байхгүй юу. Одоо замын дундаас эргээд 5 жил рүү буцаж байгаа юм. Ер нь зөвхөн 10 жилээр ч биш, ер нь нийт цалингийн дунджийг

индексжүүлсэн хувь хэмжээг бодож олохдоо л хамгийн шударга байсан байж магадгүй. Зүгээр сүүлийн 5 жил өндөр төлөөд л, нийгмийн баян чинээлэг хэсэг өндөр төлөөд л илүү тэтгэвэр тогтоолгодог тийм тогтолцоо руу л орж байгаа юм. Үгүй ээ, 10 жилээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бас нэмэгдээд л байна шүү дээ. Одоо 540 мянга болж нэмэгдсэн. 10-аар бодоход 5 сая 400 мянган төгрөг шүү дээ. 7-оор бодоход 3 сая, 4 сая төгрөг шүү дээ. Тэгээд 3, 4 сая төгрөгийн тэтгэвэр авдаг цөөхөн хэсэгт л нөлөөлнө. Яах вэ та тэгээд сүүлд нь хариуцлагыг нь хүлээх юм байгаа биз. Ингээд санал хураалт явуулъя.

Л.Мөнхбаатар: Санал хураалтаа явуулъя гишүүд ээ. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “даатгуулагч” гэсний өмнө “нийгмийн даатгалд даатгуулах зорилгоор” гэж нэмж, мөн заалтын “заасан хувь хэмжээгээр” гэснийг “заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 4.1.15 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. 58.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасаж, мөн зүйлийн 7.2.3 дахь заалтын “гадаад орноос Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар” гэснийг “Монгол

Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар” гэж өөрчилж, 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсад байрладаггүй өөрийн төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтан;” Санал гаргасан ажлын хэсэг.

Томьёоллын хувьд гадаадын аж ахуйн нэгж, төлөөний газар гэдэг ийм хууль зүйн нэр томьёо байгаа юу. Нөгөөтээгүүр энэ чинь зарчмын өөрчлөлт хийгээд байгаа юм байна шүү дээ. “Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар” гэснийг “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар” гээд том зарчмын зөрүүтэй 2 агуулгын өөрчлөлт явагдаж байна. Тийм ээ. Энийгээ харсан юм байгаа биз дээ ажлын хэсэг. Энэ бол нэлээн зарчмын шинжтэй 2 өөрчлөлт оруулсан байна шүү. Энийг ажлын хэсэг дараагийн хэлэлцүүлэг дээр анхаараарай. 64.3 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтын “ганц гишүүнтэй ажил олгогчийн захирал,” гэснийг, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн 7.4.5 дахь заалтын “эсхүл эцэг” гэсний дараа “, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч эх, эсхүл эцэг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 59.5 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 7.4.10 дахь заалт нэмж, мөн зүйлийн 7.5.1 дэх заалтын “гэрээ, хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах” гэснийг хасах.

“7.4.10.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 64.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.10 дахь хэсэг нэмэх:

“7.10.Даатгуулагч сайн дураар даатгуулсан хугацаанд энэ хуулийн 19.1.2-т заасан гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол энэ хуулийн 7.9 дэх хэсэг хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.3 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4, 12.1.5 дахь заалт нэмэх:

“12.1.4.энэ хуулийн 13.3-т заасан зөвлөлийн гишүүний урамшуулал, үйл ажиллагааны зардал;

12.1.5.нийгмийн даатгалын сангаас төлөх шимтгэлийн төлбөр;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Содномын Чинзориг гишүүн үг хэлье. Содномын Чинзориг гишүүнд үг өгье.

С.Чинзориг: Гишүүд ээ, энэ 12.1.4, 12.1.5 дахь заалтад би түрүүн Байнгын хороо дээр хэлсэн юм. Тэгээд дэмжлэг аваагүй. Энэ бол зайлшгүй ийм зөвлөл байх хэрэг байна уу, үгүй юу гэж. Одоогийн хуулиараа бол Нийгмийн

даатгалын Үндэсний зөвлөл чинь 3 талын төлөөлөлтэй, Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөлөл оролцсон, үндсэндээ хяналтын чиг үүрэгтэй үндэсний зөвлөл ажиллаж байгаа юм. Одоо тэгээд энэ 12.1.4, 12.1.5-аар дахиад бас тийм хяналтын зөвлөл ажиллавал зөвлөлтэй байна гээд. Санхүүгийн эрсдэл, хөрөнгө оруулах үйл ажиллагааг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ гэсэн заалт дээр энэ агентлагаа хэлж байх шиг байгаа юм. Энэ агентлагийнхаа дэргэд дахиад ийм хяналтын зөвлөлтэй байна гээд, тэгээд энэ хяналтын зөвлөлийн гишүүд нь даатгалын сангаас урамшуулал авч байхаар, үйл ажиллагааны зардалтай байхаар ийм юм орж ирж байгаа юм. Би бол энийг зарчмын зөв зүйтэй санал гэж үзэхгүй байгаа юм. Тэртээ тэргүй 13.2-т энэ үүргийг нь төрийн захиргааны байгууллага нь хэрэгжүүлнэ гээд агентлагаа хэлсэн байгаа юм. Тэгсэн атлаа агентлаг нь дараа нь дахиад хажуудаа ийм хяналтын чиг үүрэгтэй зөвлөлтэй байна. Энэ хяналтын зөвлөлийн гишүүд нь урамшуулал авдаг байна, үйл ажиллагааны зардалтай байна гээд ороод ирж байгаа. Би бол энийг онцын шаардлагагүй гэж. Тэртээ тэргүй Үндэсний зөвлөл гээд Их Хурлаас байгуулагддаг, 3 талын төлөөлөлтэй, хяналт тавих чиг үүрэгтэй зөвлөл шүү дээ Үндэсний зөвлөл чинь. Тэгээд тэр зөвлөлийн гишүүд нь урамшуулал авдаг, үйл ажиллагааны зардал авдаг ийм зөвлөл байтал дахиад агентлагийнхаа дэргэд ийм хяналтын зөвлөлтэй байна, хяналтын зөвлөлийн гишүүд нь сангийн хөрөнгөөс урамшуулал авдаг байна. Бүр үйл ажиллагааны зардалтай байна гээд ийм юм оруулаад ирж байгаа юм. Би бол энийг чухал ач холбогдолтой зохицуулалт биш гэж үзэж байгаа. 13.2 дээр энэ хяналтынхаа чиг үүргийг агентлаг хариуцна, хэрэгжүүлнэ гэж оруулчхаад, дараагийн заалтаа болохоор энэ хяналтын зөвлөлтэй байна гээд ийм юм оруулаад би бол энийг зөв зохицуулалт биш гэж бодож байгаа. Эсвэл тэр

хяналтын чиг үүрэгээ агентлаг хэрэгжүүл, эсвэл тэр агентлаг нь болиод Үндэсний зөвлөлийнхөө дэргэд ийм зөвлөлтэй байх юм уу. Ийм зөвлөлтэй байсан ч энэ нь тэгээд Үндэсний зөвлөлтэйгөө адилхан урамшуулал авдаг байх юм уу, үйл ажиллагааны зардал авдаг байх юм уу гээд ийм асуудал байгаа. Би бол энийг Байнгын хороо дээр дэмжээгүй юм. Тэгээд энийг гишүүд анхаарна биз дээ.

Л.Мөнхбаатар: Чиг үүргийн давхардал байна гэж үзэж байгаа юм байна. Үг авч болно. Асуултад хариулахгүй. Зарчмын зөрүүтэй санал учраас. Санал хураалт явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 50 хувиар санал уначихлаа. Хишгээгийн Нямбаатар гишүүн горимын санал гаргая.

Х.Нямбаатар: Миний төхөөрөмж тэр байтугай миний нэр аль ч талд нь уншигдсангүй. Тэгэхээр саяын саналыг хүчингүйд тооцоод дахин санал хураалгах горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарын горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Хүчингүйд тооцох санал хураалт шүү. 55.8 хувиар санал дэмжигдлээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Үндсэн санал хураалтаа явуулъя. Санал хураалт. 53.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж өөрчилж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “үүрэг бүхий” гэсний дараа “орон тооны бус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. 58.1 хувиар санал дэмжигдээ.

8.Төслийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хувь хэмжээ,” гэсний дараа “хэрэглэх” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Сана хураалт. 58.1 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “бүсийн болон хээрийн нэмэгдэл,” гэснийг хасаж, мөн зүйлийн 19.1.4 дэх заалтын “зүйлийн 19.1.1, 19.1.2-т “ гэснийг “хуулийн 19.1.1-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 62.8 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.28 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 21.31 дэх хэсгийг хасах:

“21.28.энэ хуулийн 7.7-д заасан даатгуулагчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг Төрөөс олгох урамшууллаас эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл суутган төлөх тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалын зохих санд төлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлье.

Б.Пүрэвдорж: Энэ хуулийн 21.23 дээр малчин туслах малчны нийгмийн даатгалын шимтгэлийг 5-аас доошгүй жил 50 хувиар төрөөс төлнө гэдэг ийм заалт орж ирж байгаа. Тэгэхээр энэ бас сайн заалт орж ирж байна л даа. Тэгэхээр энийг малчид маань бас яг энэ асуудал дээр анхааралтай хандах хэрэгтэй байна. 2020 оны 1 сарын 04-ны өдөр батлагдсан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хугацааг 1 жилээр сунгах энэ хуулийг би батлуулсан байгаа. Тэгээд энэ батлуулсан хуульд малчид маань маш хариуцлагагүй ажилсан. Ер нь бол хөдөө орон нутгаас хөдөөгөөс орж ирээд сумын төв дээр очдог, сумын төв дээр очоод ганц 2 өдөр материалаа

хөөцөлдөж байгаад мал нь хэцүүдэхээр буцаад давхидаг. Тэгээд тэндээ очоод сар болдог, 2 сар болдог, мартдаг. Тэгээд нөгөө хуулийн үйлчлэх хугацаа нь дуусдаг ийм л юм болоод байдаг юм. Дээрээс нь манай нийгмийн даатгалын сум дахь мэргэжилтэн ямар ааштай байгаагаас шалтгаалж энэ асуудал явдаг. Өөрөөр хэлбэл малчин хүн чинь бүх бичиг баримтыг бүрдүүлж чадахгүй. Ер нь бол хууль гарлаа гэхэд дагалдах материалыг нь ийм ийм юм бүрдүүлнэ гэдэг юм нь нэлээн гох дэгээтэй юм хийдэг байхгүй юу даа. Тийм учраас тэрийгээ малчин давж чаддаггүй. Тэгээд сумын мэргэжилтэн, байцаагч нь малчин ороод материал энэ тэр гээд асуухаар зарим нь хэдэр ёдор гээд буцаадаг. Гэтэл манай Зэрэг сум, Чандмань сум нэг нь залуухан, нөгөө нь туршлагатай тэр 2 хүн сум дээрээ 100 гаруй малчныг малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуульд хамруулаад тэтгэвэр авах тэр боломжийг нь бүрдүүлж байхад, зарим сум дээр нь 5 хүн, 6 хүн. Тэтгэвэрт гарах гэж байгаа нэг нөхөр хар яар гээд л. Тэгээд малчдыг буцаадаг, тэрнээс болоод төрөөс гарч байгаа сайн шийдвэр дээр манай малчид бүрэн хамрагдаж чадахгүй ийм тал байдаг шүү. Тийм учраас эхнэр, нөхөр 2 энэ хуульд хамрагдлаа гэхэд нэгийгээ бүр 7 хоногоор сум руу явуулаад тэр материал сайн бүрдүүлээд, тэгээд тэр сумын мэргэжилтэн, байцаагч нар нь тэр хүмүүст сайхан туслаад, энэ Монгол Ардын намаас гаргаж байгаа 50 хувийн малчдын төлбөр төлөх энэ асуудалд бүрэн хамрагдаад, ирээдүйгээ бодоод олон жил тэтгэвэр авахаа бодоорой манай малчид. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энэ угаасаа саяхан батлагдан гарсан төрөөс олгох урамшуулалтай холбоотой Туваан гишүүн, Тэмүүлэн, Батжаргал нарын гишүүдээс санаачилсан хууль бол батлагдсан. Тэрэнтэй уялдуулж хийж байгаа заалт юм байна шүү дээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Батлагдан гарсан хуультайгаа л нийцүүлж, оруулж ирж байгаа заалт байна. 71.4 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “4 дүгээр” гэснийг “8 дугаар” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтын “төлсөн” гэсний дараа “тэтгэврийн даатгалын” гэж нэмж, мөн зүйлийн 27.4 дэх хэсгийн “тусгай дансанд” гэснийг “тусгайлан” гэж, 27.7.2 дахь заалтын “системийн ач холбогдол бүхий” гэснийг “Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.2 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “орлогыг” гэснийг “орлогын тодорхой хувийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 29.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.7.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож зөрүүг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Содномын Чинзориг гишүүн үг хэлье. Өвлөхтэй холбоотой заалт байгаа.

С.Чинзориг: Гишүүд ээ, энэ 29 дүгээр зүйлийг бид нар жоохон анхаармаар байгаа юм. Би бас Байнгын хороо дээр яриад яваад байгаа юм. 29 дүгээр зүйл чинь тэтгэврийн нөөц санг

бүрдүүлэх мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх гэсэн ийм заалт байгаа юм. Одоо миний санаа зовж, болгоомжилж байгаа юм нь болохоор энэ хуримтлал үүсэх, сангийн шимтгэлийнхээ 2 хувиар хуримтлал үүсгэж нэрийн дансаа мөнгөжүүлэе гэж байгаа санаа, зарчмыг нь би бол дэмжиж байгаа юм. Гэтэл 29 дүгээр зүйлд орж ирж байгаа юм чинь хэзээ энэ сан нь мөнгөжүүлэх, ирэх жилээс мөнгөжөөд хуримтлал үүсээд эхлэх үү, үгүй юу. Тэр ард нь байгаа заалтууд нь хэзээ хэрэгжих вэ гэдэг нь жоохон эргэлзээтэй. Хамгийн наад тал 2030 он гэж ярьж байгаа манай яамныхан. Миний бодлоор бараг л 2040 оноос наашгүй л юм байгаа байх. Баялагийнхаа сантай уялдуулаад, хуримтлалынхаа нэгдсэн сантай уялдуулж явахгүй бол нэлээн асуудалтай.

Миний хамгийн гол санаа зовж байгаа юм нь энэ 2 хувиар хуримтлал үүсгээд мөнгөжүүлсэн орлогоо эрүүл мэнд болоод эрүүл мэндийн зардалдаа, боловсролын зардалдаа, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтдээ зарцуулж болно гээд ороод ирж байгаа юм.

2 дахь асуудал нь даатгуулагч нь нас барсан бол энэ мөнгөжүүлсэн орлогоос нь хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ гээд ороод ирж байгаа юм. Яах вэ одоо ингээд ярихад бол их сайхан. Олон түмэнд таалагдахаар, хүрэхээр. Энэ мөнгөжүүлсэн орлогоосоо хуримтлал үүсвэл эрүүл мэндийн зардалдаа зарцуулж болно. Боловсролын зардалдаа зарцуулж болох нь. Бүр орон сууцны ипотекийн зээлдээ санхүүжүүлж болох нь. Даатгуулагч нас барвал хууль ёсны залгамжлагчид нь өвлүүлэх гээд. Энэ чинь тэгээд 10 жилийн дараа, 20 жилийн дараа л хэрэгжиж эхлэх юмыг бид нар одоо хуульд оруулаад олон түмнийг маш бухимдал үүсгээд, өнөө маргаашгүй өвлөх юм байна. Орон сууцны зээлдээ өгье, эрүүл мэнд, боловсролын зардалдаа өгье гээд ингээд бүжигнуулсан ийм асуудалд орчихно. Энэ

бол алс ирээдүй, 10 жилийн дараа, 20 жилийн дараа юмыг яриад байгаа юм. Эхний ээлжид би энийгээ энэ хуулиас авчихмаар байгаа юм. Тэгээд тэр 2 хувиараа хуримтлал үүсгээд, мөнгөжүүлээд хуримтлал үүсгэх юмаа эхлээд нэг гарцыг нь зөв олоод явчихъя л даа. Ирээдүйд болох нөгөө алаагүй баавгайн арьсыг хуваана гэдэг шиг, ирээдүйд үүсэх магадгүй 10 жил, 20 жилийн дараа магадгүй болох юмыг одоогийн энэ хууль дээр бичихээр бүгд л иргэд чинь бужигнаад эхэлнэ шүү дээ. Өвлөх юм байна. Ипотекийн зээлд өгөх юм байна. Эрүүл мэнд, боловсролынхоо зардалд өгөх юм байна гээд. Өчигдөр Энх-Амгалан сайд иргэдийг тайван амгалан байлгаад өгөөч гэж байсан тэр шиг л юм болно шүү дээ. Тайван, амгалан байлгамаар байгаа юм. 10 жилийн дараа, 20 жилийн дараа магадгүй гэж байгаа юмыг өнөөдрийн хуульд оруулаад хүлээлт үүсгээд иргэдийг бухимдуулаад явчихна. Тийм учраас би бол даргад юу хэлж байна гэхээр энэ 29 дүгээр заалтыг ажлын хэсэг зөвшөөрч байвал одоо санал хураахгүйгээр, ажлын хэсэгт, Байнгын хороонд гүйцээн боловсруулах гэсэн чиглэл өгвөл сайн байна. Тэгэхгүй бол ингээд дэмжигдээд явах юм бол тэгээд ипотекийн зээлдээ өгөх юм байна маргааш, өвлөх юм байна маргааш, эрүүл мэнд, боловсролын зардалд өгөх юм байна гээд. Энэ чинь 10 жилийн дараа цаад талын хугацаа манайхны ярьж байгаагаар 2040 онд л хагас хуримтлалд шилжинэ гэж яриад байгаа шүү дээ. Ажлын хэсгийн хариулт нь. Тэгэхээр тэр 20 жилийн дараа юмыг бид нар ингээд сайхан таалагдах гэж байгаа юм шиг ийм юм биччихээд хүлээлт үүсгээд, бухимдуулаад. Одоо энийг чинь сонсоод фэйсээр баахан бужигнана шүү дээ. Тэгээд энийг одоо санал хураахгүйгээр Байнгын хороо зөвшөөрвөл дахин гүйцээн боловсруулах чиглэл өгөөд явчихвал яасан юм бэ. Би бол тар 2 хувиар нь хуримтлал үүсгэх механизмыг нь зөв болгоё. Мөнгөжүүлэх асуудлаа зөв болгоё гэдэг юмыг яримаар байна. Тэгэхгүй хий хүлээлт үүсгээд иргэдийг бужигнуулаад

явна. Магадгүй би энийг шуудхан хэлье. Магадгүй өвөл, намар төсвийн тухай хууль орж ирэхдээ энэ ерөөсөө хэцүү, бүтэхгүй зардал гээд хэдэн сарын дараа энийг хүчингүй болгох гээд юм орж ирнэ шүү. Би бол мэдэж байна. Манайх чинь хэд хэдэн юм ингэж хийчхээд тэгээд сүүлдээ болохгүй байна гээд буцаж байгаа шүү дээ. Тийм юм болно. Тэгэхээр ийм саналтай байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгвөл яасан юм.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг үндэслээд эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Байнгын хороо дээрээ сайтар ярилцаад эцсийн хэлэлцүүлэгт оруулж ирье.

Одоо Даргын дэргэдэх зөвлөл хуралдана. 20 минут, 13 цаг 45 минут болж байна. 15 минут түр завсарлуулж байна.

ЗАВСАРЛАГА.

Г.Занданшатар: Санал хураалтыг үргэлжлүүлж явуулна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг үргэлжлүүлж явуулна.

Сая чуулганы завсарлагаагаар. Төслийн 14 дэх зүйлээр санал хураалт явуулна.

14.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.5 дахь заалтын “ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон” гэснийг “ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ болон энэ хуулийн 21.1-д заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. 21.1-ын шигтгэсэн хувилбарыг аваад ир дээ.

Энэ хооронд төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлье. 6 сарын 19-нд Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг

Надмидын Хассуурь, Пүрэвийн Бямбасүрэн нарын бага хүү болж эхээс мэндэлжээ. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягтаа төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн түшиц, ард түмний элч болсон танд болон таны гэр бүлийнхэнд аав, ээжид нь Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Төслийн 14 дүгээр зүйлээр санал хураалт явуулъя. Санал хураалт. 57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтын “үйлдвэрчний эвлэлээс” гэснийг “байгууллагаас” гэж өөрчилж, мөн зүйлийн 35.3 дахь хэсэг, 35.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 35.15, 35.16 дахь хэсэг болгож, мөн зүйлийн 35.9 дэх хэсгийг хасах:

“35.3.Ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллага нээлттэй сонгон шалгаруулах журмаар нэр дэвшигчийг сонгон Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

35.15.Үндэсний зөвлөлийн дүрэм болон энэ хуулийн 35.3-т заасан нээлттэй сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо батална.

35.16.Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгох бөгөөд урамшууллын дээд хэмжээг хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ер нь энэ Германы 3 талт зарчим гээд цэц дээр, үндэсний олон нийтийн радио телевиз дээр, тэгээд энэ үндэсний зөвлөлүүд дээр ч гэсэн хийсэн систем бол

манайд тохирохгүй байгаа юм даа. Бүх газар энэ ажиллахгүй байгаа. Үндэсний олон нийтийн радио телевизээс эхлүүлээд. Тэгээд 3 газраас нэр дэвшүүлээд л.

16.Төслийн 35 дугаар зүйлийн 35.17 дахь хэсгийн “тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын” гэснийг, мөн зүйлийн 35.20 дахь хэсгийн “Энэ зүйлийн 35.14-т заасан” гэснийг тус тус хасаж, 35.17 дахь хэсгийн “аудитын” гэсний дараа “орон тооны бус” гэж, 35.19 дэх хэсгийн “35.17-д заасан” гэсний дараа “мэргэжлийн хорооны ажиллах журам,” гэж тус тус нэмж, 35.17 дахь хэсгийн “ажиллуулж, урамшуулал олгоно” гэснийг “ажиллуулна” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 35.20 дахь хэсэг нэмэх:

“35.20.Энэ хуулийн 35.19-т заасан урамшууллыг мэргэжлийн хорооны гишүүний ажлын үр дүнг харгалзан Үндэсний зөвлөл олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалтын “нормативыг” гэснийг “дээд хязгаарыг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Нормативыг дээд хязгаараар сольдог нь буруу байна даа. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ заалтыг эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулж анхаар. Дээд хязгаарыг үндсэндээ Улсын Их Хурал, Засгийн газраас баталж байгаа шүү дээ. Яам өөрөө батлах. Орон тооны дээд хязгаарыг. Норматив гэдэг чинь өөр ойлголт баймаар юм.

18.Төслийн 37 дугаар зүйлийн 37.3, 37.9, 37.12 дахь хэсгийн “өвчин судлалын” гэсний дараа “төрөлжсөн мэргэшлийн” гэж, мөн зүйлийн 37.12 дахь хэсгийн “нийгмийн хамгааллын”

гэсний дараа “болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ шигтгэсэн дээрээ төрөлжсөн, мэргэжлийн гэж нэмсэн мөртөө эрүүл мэндийн асуудал эрхэлсэн гэж байхгүй байх юм. Энэ яагаад эрүүл мэндийн асуудал эрхэлсэн гэж нэмсэн юм. 37.12 дээр за за. Энийг найруулгаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг авч аль нэгийг батлахгүй бол 2-уулаа батална, эсхүл хамтарч батална гэж байх юм уу. Хамтарч батална гэж найруулах хэрэгтэй юм байна шүү.

19.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1.5 дахь заалтын “, хууль тогтоомж зөрчихийг зөвлөх, тулгах, шаардах” гэснийг хасаж, мөн зүйлийн 39.1.7 дахь заалтыг “39.1.7, 39.1.8, 39.1.9” дахь заалт болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.14 дэх заалтын “хорогдуулах” гэснийг “богиносгох” гэж, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “үүссэн үүргийн дагуу”

гэснийг “тогтоосон” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтын “343 дугаар зүйлд заасан ажил гүйцэтгэх, мөн хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах” гэснийг “343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээ” гэж, 29 дүгээр зүйлийн 29.5.2 дахь заалтын “тусгай” гэснийг “тухайлсан” гэж, 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын “хуулиар тогтоосон” гэснийг “хуулийн 25.1-д заасан” гэж, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 35.6 дахь хэсгийн “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Төв” гэснийг “Магадлалын төв” гэж тус тус өөрчилж, 44 дүгээр зүйлийн 44.6, 44.7 дахь хэсгийг 44.8, 44.9 дэх хэсэг болгон шилжүүлэх.

2.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “(цаашид “Итгэмжит зөвлөх” гэх), (цаашид “Зөвлөх” гэх) (цаашид “Тэргүүлэх” гэх)” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тухай хуульд харшилсан зүйл ярьж болохгүй шүү.

Хоёр.Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.1 дэх заалтын “0-16” гэснийг “0-18” гэж, 37.2.2 дахь заалтын “16” гэснийг “18” гэж, 37.2.2, 37.2.3 дахь заалтын “эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс” гэснийг “эрүүл мэндийн магадлалын зөвлөл” гэж, 37.3 дахь хэсгийн “комисс” гэснийг “зөвлөл” гэж, 37.4 дэх хэсгийн “37.2.1, 37.2.2-т” гэснийг “37.2.1-д” гэж, 37.5 дахь хэсгийн “37.2.1-37.2.3-т заасан комиссын” гэснийг “37.2.1, 37.2.2-т заасан зөвлөлийн” гэж, 37.9 дэх хэсгийн “комиссоос” гэснийг “зөвлөлөөс” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “татварын өрөө барагдуулаагүй татвар” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өрөө барагдуулаагүй татвар, шимтгэл” гэж, мөн заалтын “татварын” гэснийг “татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай хуулийн бас нэг санал хураалт байгаа. 2 дахь санал.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “, 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсгийн “37.2.2” гэснийг, 37 дугаар зүйлийн 37.5 дахь дэх хэсгийн “-37.2.3” гэснийг тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэсний дараа “, ӨӨРЧЛӨЛТ” гэж нэмж, 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын “73.1.4¹” гэснийг “73.1.4.а” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 3, 4 дүгээр зүйл болгох:

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн тайлбар хэсгийг хассугай.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 8.2, 8.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалтын “тэтгэвэр, тэтгэмжийн” гэснийг “тэтгэврийн” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал

хураалт. 75.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсэг,” гэснийг хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 73.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Долоо.Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “гарчиг” гэснийг “нэрийн “ДААТГАЛЫН ТУХАЙ” гэснийг “ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ” гэж, мөн зүйлийн “45 дугаар зүйлийн 45.1.3” гэснийг “44 дүгээр зүйлийн 44.1.3” гэж өөрчлөх.Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “44 дүгээр зүйлийн 44.6-д” гэснийг “43 дугаар зүйлийн 43.5-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Бямбацогт дарга аа, танай Төмөр замын тээврийн тухай хууль ирэх 2, 3 дахь өдөр чуулганд хэлэлцэхээр болсон шүү. Та тэр дээр бэлтгэл сайн хангана шүү.

Дамдинням гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан, Тогтохсүрэн дарга, Боловсролын байнгын хорооны дарга наашаа хүрээд ир. Дараагийн хэлэлцэх асуудлын талаар ярилцъя.

/14.57 цаг/

Дараагийн асуудалдаа оръё.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Ажлын хэсгийг оруулъя. Сая даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хуралдаад энэ үргэлжлүүлж хэлэлцэх асуудал учраас эхэнд орох ёстой байсан. Боловсрол, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Мөнхцэцэгийн саналаар Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар санал хураалт явагдаад энэ асуудал цөөхөн саналтай учраас эхэлж хэлэлцээд дуусгаж ирэх 7 хоногт оруулахгүй бол болохгүй юм байна. Их удаж байгаа хууль.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлэн санал хураана. Ажлын хэсгийн гишүүд Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр нар байна. Бусад хүмүүсийг оруулаарай.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн төслийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлж хураана. 3 дахь санал хураалт дээр зогссон байгаа. 1, 2-ыг хураасан байна.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “3-5” гэснийг “2-5” гэж өөрчилж, 4.7 дахь хэсгийн “сургуульд” гэсний өмнө “ерөнхий боловсролын” гэж нэмж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Сургуулийн өмнөх боловсролыг 4, бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу сургалтыг танхимын бус хэлбэрээр үргэлжлүүлэн” гэснийг “сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.3-т заасан хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 75.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Манай Улсын Их Хурлын хүний эрхийн нэрт зүтгэлтэй Цогтбаатар бол маш хурдан гүйдэг юм байна гэдэг нь сая харагдлаа.

5.Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”**-ийн нэрийг **“ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”** гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “хөгжлийн онцлог” гэснийг “онцлог” гэж, 6.3 дахь хэсгийн “саналыг” гэснийг “санал, зөвшөөрлийг” гэж, 6.5 дахь хэсгийн “Энэхүү тогтоосон хугацаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байна” гэснийг “Энэхүү тогтоосон хугацаа нь ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөгөөр судлах хичээлийн цагийг өөрчлөх үндэслэл болохгүй.” гэж, 6.7, 6.9 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 6.7 дахь хэсгийн “сувилагчтай” гэснийг “сувилагч болон сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх

мэргэжлийн ажилтантай” гэж өөрчилж, 6.1 дэх хэсгийн “Тайлбар”-ыг төслөөс хасаж, 6.4, 6.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Боловсролын ерөнхий хуулийн 8.4-т заасан ганцаарчилсан сургалт зохион байгуулах журам, сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх журмыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “монгол хэлээр” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 6.1-д заасан хэлээр” гэж өөрчилж, 7.4 дэх хэсгийг өөрчлөн найруулж, 7.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.5 дахь хэсэг нэмэх:

“7.4.Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Боловсролын ерөнхий хуулийн 6.6-д заасан суралцагч ерөнхий боловсролыг бичгийн болон монгол дохионы хэлээр эзэмшинэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулна. Гэхдээ энэ Үндсэн хуульд Монгол хэл бол төрийн албан ёсны хэл буюу бүх юмны хэл гэж заасан байгаа шүү. Тэрийг өөрчлөх гээд байдаг. Ер нь Монгол хүн л бэлтгэх ёстой шүү дээ. Дэлхийн түвшний Монгол хүн бэлтгэх ёстой.

Монгол дохионы хэл гэж ямар хэл байдаг юм. Санал хураалт явуулъя. 74.4 хувь.

Ер нь Боловсролын хуулийн эрхэм зорилго бол Дэлхийн түвшний мэдлэг, мэргэжилтэй Монгол хүн бэлтгэх гэж хэлэх хэрэгтэй шүү. Монгол хэлээр гэснийг Боловсролын ерөнхий хуулийн 6.1-д заасан хэлээр гэж яагаад өөрчилж байгаа юм. Яагаад Монгол хэлийг өөрчлөх гээд байна. Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчөөд байна уу, үгүй юу.

Монгол Улсын Үндсэн хуульд цөөнхийн хэл гэж байхгүй. Төрийн албан хэргийг Монгол хэлээр явуулна л гэж байгаа. 74.4 хувиар. Эцсийн хэлэлцүүлэг дээр ингэж Монгол хэлийг өөрчлөөд байхгүй ээ.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “математикийн” гэсний дараа “болон цахим технологийн” гэж нэмж, 8.3 дахь хэсгийн “хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт хөтөлбөр” гэснийг “энэ хуулийн 8.2-т зааснаас гадна нэмэлт үйл ажиллагаа” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Шигтгэсэн хувилбар аваад ир дээ. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн “**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**”-ийн нэрийн “сургалтын” гэснийг “боловсролын” гэж өөрчилж, 9 дүгээр зүйлийн гарчиг, 9.1 дэх хэсгийн “сургалтын” гэснийг , 9.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Ерөнхий боловсролын агуулгыг математик, байгалийн ухааны, нийгэм, хүмүүнлэгийн, хэл, харилцааны, бие бялдрын, урлаг, гоо зүйн, цахим болон зохион бүтээх технологийн, иргэний боловсрол, амьдрах ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр тогтооно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “сайжруулж болно” гэснийг “сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцүүлэн сайжруулж

болно” гэж өөрчилж, 10.1, 10.2, 10.4, 10.6, 10.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслөөс 10.7 дахь хэсгийг хасах.

“10.1.Сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлалтай байна. Үзэл баримтлалыг Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан Үндэсний зөвлөл хэлэлцэж, Засгийн газар батална.

10.2.Сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 10.1-д заасан үзэл баримтлалд үндэслэн энэ хуулийн 8.2, 9.2-т заасан агуулгын хүрээнд боловсруулна.

10.4.Энэ хуулийн 7.4, 10.2, 10.3, 10.10-т заасан сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, Боловсролын ерөнхий хуулийн 14.8-д заасан цахим сургалтын хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөл нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, хичээлийн жилийн бүтцийн талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Зөвлөл нь багш, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны төлөөллийн оролцоог хангасан байна.

10.8.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой тохируулга хийж болно. Санал гаргасан ажлын хэсэг. 87.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энх-Амгалан сайдаа үүгээр л яг шинжлэх ухааны үндэстэй хэдэн наснаас хэнд юу заах вэ, эхлээд Монгол хэл, Монгол хүн болох тэр дээр үндэслээд,

тэгээд нэг саармаг эрлийз аль ч үгүй хүүхдүүд бэлдэхгүй байх тэр шинжлэх ухааны үндэстэй /cognitive science/ энэ бүхний уялдааг хангасан бодлого гарах ёстой шүү дээ. Түүнээс хуулиар биш. Тэгээд багшаа бэлтгэх асуудлууд байна.

10.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэснийг “3 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэж, мөн хэсгийн тайлбарын “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэснийг “Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэж, “0-2 настай” гэснийг “3 хүртэлх насны” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.11, 10.12 дахь хэсэг нэмэх:

“10.11.Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байна.

10.12.Энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт тухайн орон нутгийн түүх, соёл, байгаль, газар зүйн онцлогийг тусган хэрэгжүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 82.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3, 11.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Энэ хуулийн 10.6-д заасан мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн ерөнхий боловсролын сургалтад хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3.Сурах бичиг зохиоход багш, эрдэмтэн, судлаач, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч,

мэргэжлийн холбооны төлөөллөөс санал авна.

11.9.Харааны бэрхиээлтэй, энэ хуулийн 7.2-т заасан суралцагчид зориулан сурах бичгийг хөрвүүлнэ. Үндэстний цөөнх, сонсголын бэрхиээлтэй хүүхдийн эх хэлний сурах бичгийг зохионо.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 77.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “сурах бичиг зохиох турших, сургалтад ашиглахтай” гэснийг “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээхтэй” гэж, 11.6 дахь хэсгийн “хөтөлбөрийн хэрэгжилтийн” гэснийг “сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, 11.7 дахь хэсгийн “үнэ төлбөргүй” гэснийг “төлбөргүй” гэж, “ашиглуулна” гэснийг “ашиглуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол сурах бичгийг худалдан авч болно.” гэж, 11.12 дахь хэсгийн “танин мэдэхүйн” гэснийг “сэтгэхүйн” гэж өөрчилж, 11.4 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмж, 11.10, 11.11 дэх хэсгийг төслөөс хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

13.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “ахиулах зорилгоор” гэснийг “ахиулахад чиглэсэн” гэж өөрчилж, 12.1.3, 12.1.5 дахь заалт, 12.1.6 дахь заалтын “тайван амьдрах” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 87.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь хэсгийн “дэг журмыг” гэснийг “дүрэм, журмыг” гэж өөрчилж, 13.1.1, 13.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.1.бие даан суралцах, хувь хүн, бүлэгтэй хамтран ажиллах, харилцааны ур чадвараа хөгжүүлэх;

13.1.3.бусад суралцагчийг эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 85 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 14.2 дахь хэсгийн “хүүхдийн тооноос” гэснийг “хүүхдийн тоо, ялгаатай хэрэгцээнээс” гэж, мөн хэсгийн “бусад” гэснийг “холбогдох хууль тогтоомжид заасан” гэж, 14.4 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах болон холбогдох хууль тогтоомжид заасан ажилтан” гэж өөрчилж, 14.1 дэх хэсгийн “үйлчилгээний” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эмч” гэсний дараа “номын санч” гэж, мөн доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх.

“14.6.Цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйч ажиллуулж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сая энэ Засгийн газрын гишүүд яасан их сая 5 хүн дугарсны 1 нь сөрөг хүчнийг эс тооцвол дандаа Засгийн газрын гишүүд дугарч байна. Бие Биеэ үгүйсгэж. Танхимын зарчим хаана байна ер нь.

16.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “сургуулийн багш” гэснийг “ерөнхий боловсролын сургуулийн багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 15.1.1 дэх заалтын “сургалтын” гэснийг “боловсролын” гэж, 15.1.3 дахь заалтын “төлөвшил, авьяас чадварыг хөгжүүлэх, амжилттай суралцахад” гэснийг “мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд” гэж өөрчилж, 15.1.5 дахь заалтын “байгуулах” гэснийг, 15.1.1 дэх заалтын “бүрэн” гэснийг, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Багш нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 76.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 15.1.2, 15.1.6 дахь заалт, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.6 дахь хэсэг нэмэх:

“15.1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу арга хэмжээ авахтай холбоотой бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;

15.1.6.хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах.

15.5.Багш нь суралцагчийн хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

15.6.Энэ хуулийн 27.2-т заасан суралцагчийн үнэлгээг бусдад задруулахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 79.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Багш нь” гэсний дараа “дээд боловсролтой” гэж, 16.6 дахь хэсгийн “мэргэжил дээшлүүлсэн” гэсний дараа “магистр зэрэгтэй” гэж нэмж, 16.2 дахь хэсгийн “Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж, 16.7 дахь хэсгийн “түвшин” гэснийг “мэдлэг” гэж, “3-5 жил” гэснийг “3 жил” гэж өөрчилж, мөн зүйлийн

гарчгийн “тасралтгүй” гэснийг, 16.5 дахь хэсгийн “үндэсний, орон нутгийн түвшинд болон ажлын байранд” гэснийг хасаж, 16.4, 16.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.4.Багишийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, орон нутаг, үндэсний түвшинд зохион байгуулна.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн түвшинд зохион байгуулах багишийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 12.12-т заасан нэгж зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 33 гишүүд дэмжиж, 80.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг томилсон этгээд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан байгууллагад хичээлийн жилд тайлагнах, хариуцах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ санал хураалтын 17.1.8-ын санал хураах гэж байгаа өгүүлбэрийн тэр сүүлийн хариуцах гэдэг нь илүүдсэн юм шиг л уншигдаад байх юм. Яагаад гэхээр боловсролын чанар, үр дүнг томилсон этгээд, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэгээд байгууллагад хичээлийн жил тайлагнах л гэж уншигдах гээд байх юм. Суралцагч, боловсролын чанарын үр дүнг хариуцах, эцэг эх хариуцах, асран хамгаалагч хариуцах, харгалзан дэмжигч хариуцах гэж эсвэл ойлгосон юм болов уу. Муу сурсан нь миний буруу биш л гэнэ шүү дээ. Муу сурч байгаа нь багишийн буруу биш. Багш бол энэ чинь өөрөө 00-н ногоон тэг байгаад байгаа юм. Би хариуцахгүй л гэнэ шүү дээ. Хүүхэд бол

би өөрөө хичээгээд байгаа. Манай багш муу байгаа. Багш хариуцна гээд. Намайг 1 дүгээр ангид орж байхад манай аав ээж 2 бол хичээлийн чинь бүх юмыг бүрэн хангалаа. Сайн сурах чинь хэнээс хамаарах билээ л гэсэн. Би бол багшаас хамаарна л гэж хариулж байсан. 7 настай байхдаа. Би бол өөрөө хариуцахгүй л гэж бодож тухайн үедээ бодож л тэгж хариулж байсан юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ сайн сурах, муу сурахыг хэн хариуцах вэ гэхээр нэг уншигдахгүй байгаад байх шиг байх юм. Энийг бас эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарч өгөөч ээ гэж.

Г.Занданишатар: Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр тэр 17.1.8 дугаар зүйлийг анхааръя. Энэ чинь хэнд тайлагнах гээд байгаа гэхээр нутгийн захиргааны байгууллагад тайлагнаж хариуцах гээд байгаа шүү дээ. Энэ чинь нутгийн захиргааны байгууллага даа томилсон этгээд гэж байгаа юм. Ер нь 17.1.8 өөрөө найруулгын хувьд анхаармаар, орчуулгын юм шиг хэл байна. /Responsible/ гэдэг чинь /responsive/ буюу хариу өгөх гэсэн утгатай байдаг. Тэгээд тэр хариуцах гэдэг үгээрээ л бичсэн юм шиг байна. Энийг эцсийн хэлэлцүүлэг дээр 17.1.8 анхаараарай.

Санал хураалт явуулъя. 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8 дугаар бүлэгт заасан нутгийн захиргааны байгууллага л гээд байх юм. Тэгсэн мөртөө томилсон этгээд гэж өгүүлбэр орчихоод байгаа юм.

20.Төслийн **“ЗУРГААДУГААР БҮЛЭГ”**-ийн нэрийн **“СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА”** гэсний өмнө **“БОЛОВСРОЛЫН”** гэж нэмж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “боловсролын болон төсвийн” гэснийг “боловсролын” гэж, 18.3 дахь хэсгийн “үйл ажиллагаандаа баримтлах” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.23-т заасан үлгэрчилсэн дүрэмд нийцсэн” гэж,

18.7 дахь хэсгийн “өөрийн” гэснийг “өөрийн болон хөндлөнгийн” гэж өөрчилж, 18.1 дэх хэсгийн “хүүхдийн” гэснийг, 18.9, 18.10 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.11, 18.12, 18.13, 18.14 дэх хэсэг нэмэх:

“18.11.Ерөнхий боловсролын сургууль дотуур байртай байж болно. Дотуур байрын орчин, үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж, мөрдөнө.

18.12.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа суралцагчид зориулан энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааны хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

18.13.Энэ хуулийн 18.12-т заасан хөтөлбөрийг Боловсролын ерөнхий хуулийн 43.1.2-т заасан зардлаас санхүүжүүлнэ.

18.14.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь номын сантай байх бөгөөд Номын сангийн тухай хуулийн 10.3-т заасан үйлчилгээ үзүүлнэ.” Санла гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Содномын Чинзориг сайд суудалдаа сууя. 75.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон холимог бүлгээр зохион байгуулна.” Санал гаргасан

ажлын хэсэг. Санал хураалт. 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.2.4.10-12 дугаар ангитай ахлах сургууль.

Энэ тэгээд сургалтын үйл ажиллагаа биш, сургалт, үйл ажиллагаа гэж байгаа шүү дээ тээ. 2 өөр юм байх гээд байна шүү дээ. Тэрийгээ сайн үзээрэй.

22.Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийг төслөөс хасаж, 20.14 дэх хэсгийн “энэ хуулийн 8.7-д” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 8.1-д” гэж өөрчилж, 20.4, 20.11, 20.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20.4.Энэ хуулийн 20.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг тогтооход хөгжлийн бодлого, төлөвлөлт, хүн амын нягтаршил, газар зүйн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзана.

20.11.Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салиггүй хэсэг байна.

20.16.Энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааг үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэдтэй хамтран зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.17 дахь хэсэг нэмэх:

“20.2.3.1-12 дугаар ангитай, эсхүл 6-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль;

20.17.Энэ хуулийн 20.11-д заасан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Найруулга нь дугаараар залгагдаж уншигдаад байгаа юм. Дугаараар ер эхлэхгүй байвал зүгээр. 2 дугаарт энэ 10-12 дугаар ангитай гэдэг юмыг чинь найруулгыг нь унших уншилтыг нь янзлах, найруулгыг засах хэрэгтэй. 75.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хууль зүйн техникийн хувьд 6-12 бүрэн дунд, ахлах сургууль гэдэг юмнуудаа ингээд нэр томъёоны хувьд ялгах ёстой байж магадгүй. Ахлах сургууль гэж тэдээс тэддүгээр анги, бүрэн дунд гэж тэд гээд нэр томъёодоо заачихвал дараа нь энийгээ нэр томъёоны тэдийн тэдэд заасан гээд эшлээд явсан ч болно. Ахлах сургууль, бүрэн дунд сургуулиар ч байж болно. Хууль зүйн техникийн хувьд тэгж засна.

24.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь заалтын “сургалт” гэсний дараа “, үйл ажиллагаа” гэж нэмж, 21.1.2 дахь заалтын “дэмжигч /явуулын/ багшийн” болон “нүүдлийн бүлгийн” гэснийг “хувилбарт” гэж, 21.3 дахь хэсгийн “боловсролын болон санхүү, төсвийн” гэснийг “боловсролын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 21.4 дэх хэсэг нэмэх:

“21.4.Хувилбарт сургалтад энэ хуулийн 5.1-д заасан хугацаа хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн суудалдаа сууя. 65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн

заах зээлд ишлжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрээр эзэмшүүлж болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүнээс үг тасаллаа. Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ санал хураах гэж байгаа саналын томъёоллын 22.8 буюу эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрээр эзэмшүүлж болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална гэдгийн холбогдох журмыг Засгийн газар батална гэдэг нь их ерөнхий байна. Хууль тогтоомжийн хууль бид хууль тогтоомжийн хуультай. Хууль тогтоомжийн хуулиар бол Засгийн газар нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журмыг бол гагцхүү хуульд тухайлан нэршилээр нь бичсэн тохиолдолд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам баталж байгаа юм.

Холбогдох журам гэдэг нь маш ерөнхий яг ямар журам бэ гэдэг нь нэрээрээ бичигдээгүй байна. Энийг боломжтой бол яг ямар журмыг Засгийн газар батална гэдгийг хуульд нь эрхийг нь олгож байж сая Засгийн газар батлах эрхтэй болохоор Хууль тогтоомжийн хуулийн агуулга байгаад байгаа юм. Ялангуяа энэ бага боловсролыг гэрээр олгох журам юм уу эсвэл үүний цаана санхүүжилт олгох, хоол юм уу, тэтгэмж юм уу, бүр тэр хүүхдийн аюулгүй байдал юм уу. Бүр энэ гэр орных нь стандарт юм уу. Энэ ингээд ийм том хуулиасаа энэ журмын цаана юу байгаа вэ гэдгийг би бол яг гэрээр эзэмшүүлэх журам гэдэг нэг тийм журам байх гээд байх шиг байна. Эсвэл стандарт байна уу. Хэрвээ стандарт болоод явбал энэ чинь гэрээр олгох гэж байгаа багш нь ийм боловсролтой байна, ийм шаардлагатай байна, урьд нь гэмт хэрэг хийгээгүй байна, энэ чинь бүр цаашаа маш том задарна гэсэн үг шүү дээ. Тийм учраас би бол энэ холбогдох журам гэдэг нь яг ямар журам бэ гэдгийг бүр тодорхой биччихээд сая Засгийн газар тэр журмыг батлах эрхтэй болдог хууль тогтоомжийн стандарттай байгаа юм. Тийм учраас энийг эцсийн хэлэлцүүлэг дээр нь бас яг энэ журмынх нь нэршилийг нь бичихгүй бол зүгээр холбогдох журам гэдэг уут аваад л цаанаа Засгийн газар дахиад хуулиасаа давсан хэм хэмжээ тогтоосон хууль батлаад байж болохгүй. Тэгвэл энэ хууль тогтоох эрх мэдлийн Засгийн газар хууль бусаар булааж авч байгаа хэрэг болдог байхгүй юу. Тийм учраас энийг анхаарч өгөөч ээ гэж.

Г.Занданшатар: Одоо хамгийн эхний гарч байгаа малчдын хүүхэдтэй холбоотой асуудал байна шүү дээ. Гэрээр олгоно гээд л тэгэх юм бол журмыг нь Засгийн газраас баталсан журмаар явах нь байна тийм үү. Тэрэнд хэн, яаж хяналт тавих юм.

Санал хураалт явуулъя. 22.1 дээр сургалтыг бага, дунд, ахлах ангиар

зохион байгуулна гэгчээж байгаа шүү дээ. Тэгээд тэр 21.2 дээр түрүүн бага, дунд, ахлах ангиа томъёолох гээд байгаа. Санал хураалт явуулъя. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ холбогдох журам биш яг журмыг нэрлэн заахыг Энхбаяр гишүүн хэллээ шүү. Тэгэхгүй бол Хууль зүй, дотоод хэргийн яам дээр батлахад хуульчилсан журмыг л батлах хэрэгтэй болно. Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт болохын тулд. 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Боловсролын ерөнхий хуулийн 39.2-т заасан” гэж нэмж, 23.2.1 дэх заалтын “хөгжил, бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх явцад санал, дүгнэлт гаргах” гэж өөрчилж, 23.2.5 дахь заалтын “бүх талын оролцоог хангах” гэснийг, 23.2.4 дэх заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.8, 23.2.9 дэх заалт нэмэх:

“23.2.8.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийг эрэмбэлэх, шийдвэрлүүлэх, санал өгөх;

23.2.9.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарын урилгаар Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1993 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрөлх сургууль, ачит багш, эх нутгаа эргэн дурсаж уулзаж байгаа эргэн дурсахуйн уулзалтын өдрийн мэндчилгээ дэвшүүлье.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе. Санал дэмжигдсэн.

27.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.3 дахь заалтыг нэгтгэн 23.2.2 дахь заалт болгон өөрчлөн найруулж, мөн зүйлийн 23.2.6, 23.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.2.2.суралцагчийн хөгжил, төлөвшилийг дэмжих, сурлагын хоцрогдол үүсэхээс сэргийлэх, сургалтын аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг энэ хуулийн 18.8-д заасан зөвлөлтэй хамтран зохион байгуулах;”

23.2.6.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх;

23.2.7.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан гэрээнд тусгах саналыг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралд хүргүүлэх, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.4 дахь хэсэг нэмэх:

“25.4.Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг энэ хуулийн 16.5-д заасан нэгжтэй хамтран зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн мэргэжлийн” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан” гэж, 26.6 дахь хэсгийн “18.8-д заасан өөрийн” гэснийг “18.7-д заасан” гэж, 26.7 дахь хэсгийн “боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн санд” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага боловсролын цахим мэдээллийн санд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүдээс бас гомдол гараад байгаа. Энд ерөөсөө Пүрэвдорж гишүүн сугалсан байна. 29 дэх саналаар санал хураалт явуулъя. 81.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “1-2” гэснийг “1-3” гэж, 27.4 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд заасан орон нутгийн” гэж, 27.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.6.Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг үндэслэн давтан сурах боломжийг суралцагчид олгож болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 78.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг төслөөс хасаж, 28.3 дахь хэсгийн “заавал хамруулах үүрэг хүлээнэ” гэснийг “хамруулахад захиргааны дэмжлэг үзүүлнэ” гэж, 28.6 дахь хэсгийн “мэдээллийн” гэснийг “цахим” гэж өөрчилж, 28.4 дэх хэсгийн “орон нутгийн” гэсний дараа “цэцэрлэг” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.10, 28.11 дэх хэсэг нэмэх:

“28.10.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний

удирдлагын тухай хуулийн 27.5.2, 27.5.3-т заасан үйлчилгээг төлөөлөн хэрэгжүүлэхээр томилсон этгээдтэй байгуулах гэрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, боловсролын чанарыг ахиулах талаар тусгана.

28.11.Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлэх, холбогдох хуульд заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг эрх бүхий этгээдийн баталсан журмын дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 86.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдийг сургуульд тэгш хамруулна гэж байх ёстой юм уу. Бүрэн хамруулна гэж байх ёстой юм уу. Бүрэн л хамруулах баймаар юм. Тэгш боломж гэдэг юм бол өөр утгатай, тэгэхээр хамралт бол бүрэн л байх ёстой байх гээд байна.

32.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. 89.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 4.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.7.Хөдөө аж ахуйн салбарт ажилладаг өрхийн хүүхэд болон хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдал бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас

хүүхдийг 7 настайд сургуульд элсүүлж болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан. Санал хураалт. 81.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ер нь зарчмын хувьд Цогтбаатар гишүүн бас их зарчмын санал хэлж байна шүү. Эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарна биз. Энэ дотор Дэлхийн түвшний Монгол иргэнийг бэлтгэхийн тулд эх оронч үзлээр хүмүүжүүлэх, Бат-Эрдэнэ аварга гишүүний яриад байгаа ёс зүй, хүмүүнлэгийн боловсрол олон юмыг харгалзахгүй бол яамны хүмүүс чинь ер нь ямар хүмүүс байна гэж хүмүүс гайхаад асуугаад байгаа шүү. Ялангуяа Арьяагийн Цолмон бил үү. Цолмон гуай энэ хууль дээр гол ажилласан хүн үү. Тийм юм шиг байна. Сая ажиглаад байсан чинь.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ.

/15.57 цаг/

Одоо нийгмийн даатгалын хуулиудаа үргэлжлүүлж хэлэлцүүлнэ. Дараагийн хуульд орно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Үүнд:

1 дүгээрт хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр тэтгэвэрт гарч байгаа даатгуулагчийн нөхцөлийг хэвээр үлдээхээр, хөдөлмөрийн хорттой халуун нөхцөл болон газрын доор ажиллаж байгаа даатгуулагчийн тэтгэвэрт гарах насыг нэмэгдүүлэхгүй байхаар,

2 дугаарт 2018 оноос дараалсан 6 болон 7 жилийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 1 удаа шинэчлэн тогтоохоор,

3 дугаарт тэтгэврийн тогтолцоо гэсэн бүлгийг тэтгэврийн төрөл болгон өөрчлөн найрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Чинзориг хуулийн төсөл нь Улсын Их Хурлаас баталсан тэтгэврийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигтэй нийцэж байгаа эсэх талаар, төсөл батлагдсанаар улсын төсвийн ачаалал болон нийгмийн даатгалын сангийн зардал хэрхэн нэмэгдэх талаар, нас барсан тэтгэвэр авагчийн нөхөр эсвэл эхнэрийн тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилтийн талаар, мөн 10 ба түүнээс дээш жил хамтран амьдарсан гэсэн шалгуурыг хэрхэн тооцож гаргасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг хуулийн төсөлд малчдын Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төр хариуцсанаар улсын төсөвт үүсэх ачааллын талаар болон малчдад зориулсан бусад тусгай зориулалтын талаар, хүнд нөхцөлд ажилладаг уурын зуухны галч нарыг нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох боломжийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргилоос хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах зарчмын зөрүүтэй саналыг гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах зарчмын зөрүүтэй саналыг Байнгын хорооны хуралд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Чинзоригоос хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалттай

холбогдуулан нас барсан тэтгэвэр авагчийн 10 ба түүнээс дээш жил хамтран амьдарсан нөхөр эсвэл эхнэрийн тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлж олгоно гэсний 10 жил гэсэн шалгуурыг нэмэгдүүлэх талаар гаргасан зарчмын зөрүүтэй 1 саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хянан шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Амарсайханы Хишигбаяр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн өмчийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга. Ингээд энэ протокол тэмдэглэх нь өглөө Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн ажлын хэсэг, ажил, овог нэр, албан тушаал адилхан. Дараагийн хуулиуд дээр ч гэсэн бас яг энэ ажлын хэсэг нэр овог нь адилхан учраас дахин танилцуулахгүй протоколд тэмдэглэж үлдээлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Сайнхүүгийн Ганбаатар, Хассуурийн Ганхуяг 3-аар тасаллаа. Пүрэвдорж гишүүнийг анхааруулгатай байгаа дээрээс

Б.Пүрэвдорж: 3 жилийн тэмцлийн үр дүн дээр ямар ч байсан Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн дагуу Монгол улсын Засгийн газар үүрэг авч, хэд хэдэн үүрэг авч энэ хөтөлбөртөө өөрчлөлт оруулсан. Засгийн газрын хөтөлбөрт өөрчлөлт оруулсан. Тэгээд үүний дагуу 2018 онд Олон улсын валютын сан гараад явсан. Олон хөтөлбөрөөсөө татгалзсан. Тэгээд ганцхан хөтөлбөрийг нь тэр чигээр нь аваад үлдсэн нь бол 5 жилээр цалингийн дунджаар тэтгэвэр тогтоодог байсан бол тэрийг 10 жил болгох энэ хөтөлбөр үлдчихсэн байсан юм. Тэгээд 3 жил тэмцээний үр дүнд энэ тэмцэл маань үр дүнд хүрч, 2 удаа ахмадууд маань жагсаал хийж, 60 гаруй удаа Улсын Их Хурлын индэр дээрээс үг хэлсний үр дүнд энэ 7 жилийг 5 жил болгож, Нийгмийн даатгалын багц хуульд тусгаж оруулж ирж байна.

Тэгэхээр өнөөдрийн байдлаар бол жишээ нь дунджаар 1 сая орчим төгрөгийн цалинтай гэж үзэхэд 250 мянган төгрөгийн Нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байгаа. Тэгээд 10 жилийн дараа тэтгэвэрт гарахаар нөгөөдөх нь бүр 25 мянга, бүр багасаад 10 мянган төгрөгтэй тэнцэх хэмжээний л ийм хани уналтыг эдийн засгийг буруу удирдсаны үр дүнд энэ улс орон бий болгож байгаа юм. Аль аль нь 2 том нам хоёулаа л энэ улс орныг бас ийм хани уналттай удирдана гэдэг бол аль алиных нь л алдаа байгаа. Тэгээд энэ алдааг өнөөдөр ингээд засаад, дээрээс нь 7 жил, 10 жил 1 газар тогтвортой ажиллана гэдэг бол маш цөөхөн. Суманд бол сургуулийн багш, эмнэлгийн эмч 2 л энэ шалгуурыг хангадаг. Бусад хүмүүс нь

засаг солигдох дээр л бүгдээрээ халагддаг, өөрчлөгддөг. Жишээ нь сургуулийн багш 3 сарын хугацаанд цалингүй чөлөө аваад, Солонгост ажиллачхаад буцаж ирээд тэр нь сүүлийн 7 жил дотор орчихсон байж байхад л тэтгэвэр 30-аад мянган төгрөгөөр доошоо уначхаж байгаа шүү дээ. Тэгэхээр ажилгүй байсан хүмүүс ямар их хохирол учруулах нь энэ 7 жилээс тодорхой харагдаж байгаа юм.

Тийм учраас энэ 5 жил болгох бол шударга ёсны асуудал. Манайх Европын орнууд биш. Европын орнууд чинь 4 ажил хийж байгаа хүнд 10-аад тэтгэвэр авагч ноогддог бол манайх 10 ажил хийж байгаа хүнд ойролцоогоор 4 тэтгэвэр авагч ноогдож байгаа. Тэгээд энэ тохиолдолд бол манай энэ Нийгмийн даатгалын сан бол чөлөөтэй асуудлаа шийдэх ийм 5 жилээр тооцоо явахад бүрэн боломжтой ийм сан байгаа. Харамсалтай нь энэ санг сүүлийн 7 жилийн хугацаанд арвижуулах тэр ажлыг ерөөсөө хийсэнгүй.

Өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкнууд дээр байрлуулдаг байсан. Тэрийгээ больсон. Төрийн сан дээр аваачаад ямар ч хүүгүй байршуулдаг болсон. Үүний эсрэг би жишээ нь 7 жилийг 5 жил болгоход санхүүгийн эх үүсвэрийг нь би бас олоод ирж байгаа юм л даа. Олж ирэх тогтоолын төслийг өргөн барьсан.

Өөрөөр хэлбэл Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг Монгол банкны үнэт цаасан дээр байршуулчихъя. Тэгэх юм бол жилдээ ойролцоогоор 40-өөд тэрбум төгрөг хуримтлаад тэрнээсээ энэ 7-5 жил болох тэр зардлыг нь нөхөөд өгчихье л гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл аливаа нэгэн өөрчлөлт хийж болно. Тэрний эх үүсвэрийг нь олох тэр ажлуудыг нь бас Их Хурлын гишүүд хамтдаа хийх ёстой

байхгүй юу. Тийм учраас энэ 7 жилийг 5 жил болгож байгаа./минут дуусав/

Г.Занданишатар: Асуулт биш үг байна. Гэхдээ дахин тэмдэглэж хэлэхэд байна шүү дээ. Нийгмийн даатгал тэтгэвэр дээр итгэлцүүрийг л зөв тогтоох асуудал хамгийн чухал болохоос биш 5, 7 байх нь чухал биш. 5 жил болсноороо харин ч өндөр тэтгэвэртэй улсуудад л тэтгэврийн нэмэгдэл илүү болж, яг жирийн тэтгэвэр авч байгаад нийт масс, нийт олонход бол энэ бага нөлөөлж байгаа. Нийгмийн даатгалын сангийн хуваарилалтын /солидарность/ буюу эв санааны нэгдлийн зарчим алдагдаж байгаа л ийм өөрчлөлт болох вий гэдэг ийм эрсдэлтэй байгааг бас мэргэжлийн хүмүүс анхааран судална биз дээ.

Ер нь бол өндөр тэтгэвэр авагчид илүү хувиар нэмэгдэнэ. Яг итгэлцүүрийн зарчмаар явбал бүх хүнд нэмэгдэнэ. Энийг бол манай Сайнхүүгийн Ганбаатар гишүүн бол агуард суурь, зарчим, тооцооллыг нь бас аягүй зөв харж хэлээд байгаа байхгүй юу. Яг мэргэжлийн хүний үүднээс. Хэрэглээд ирэхээрээ энэ тэгээд л их л асуудалтай болоод л ийм асуудал гарсан юм байна лээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Энэ нийгмийн даатгалын хууль бол ер нь тэгээд л хамгийн том гол 2 хуулийн л нэг шүү дээ. Ажлын байр, тэтгэвэр 2 л ер нь хүний амьдралд хамгийн чухал. Тэгээд ажлын хэсэг дээр байсан, ажлын хэсэг дээр тавьж байсан саналаа нэг тодруулаад асуучихъя. Надад хариу ирээгүй учраас. Энэ 5.1-д даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний 5 өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх эс үгүй бол хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хугацааны тэтгэмжийг сангаас өгнө гэж байгаа. Энэ санд бол яг ажил олгогч, ажилчин 2 яг адилхан яг хариуцлагаа

үүрээд өгч байгаа. Эхний 5 өдөр яагаад энэ ажил олгогчийг торгож байгаа юм бэ. Ялангуяа энийг бол манай Лхагважав Худалдаа Аж үйлдвэрийн танхимын дарга байсан Лхагважав их ярьдаг юм. Энэ тал дээр та нар нэг ажил олгогч нарт зориулаад та нар эхний 5 өдрийг тэр даатгуулагчийн 5 өдрийг төлөх ёстой юм гэдгийн шалтгааныг надад хэлээд өгөөч ээ 5.1.

Дараагийн нэг миний нэг асуулт байна. 8.2, 8.3 дээр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухайн хуульд заасан тэтгэвэр авч байсан иргэн нас барсан бол түүний гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгоно. Энэ журмыг нь бол 8.3-д нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална гэж байгаа. Энийг бол ажлын хэсэг дээр бид бүгдээрээ л дэмжээд гаргаад ирсэн. Хэзээнээс вэ гэдгийг нь өнөөдөр ард иргэдэд тодруулаад өгвөл их сайн байна. Хэзээнээс. Хууль хэрэгжсэн өдрөөсөө эхлээд өгөөд эхэлнэ биз дээ л гэж зарим хүмүүс ихэнх нь ойлгож байгаа. Та нар мэргэжлийн түвшинд энийг тодруулж өгөөч ээ.

3 дугаар асуулт ажлын хэсэг дээр ажиллаад л байх тусам л тэгээд л бэрхиээлүүд ингээд харагдах юм. 16.1-д даатгуулагчийн үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэмжийг даатгалын улсын байцаагчийн эс үгүй бол мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн тогтоосон бол илүү авсан даатгуулагчаар буцаан төлүүлэх буюу олгочихсон үндсэн тэтгэмжээ суутгана гэж байгаа юм. Мэргэжлийн хяналтын байгууллага байхгүй болчихсон байгаа. Тэгээд яг энийг ямар утгаар ойлгох вэ гэдгээ нэг тодруулж өгвөл хаа хаанаа энэ хууль хэрэгжихэд хялбар болов уу гэдэг ийм 3 асуулт асууя.

Г.Занданшатар: Ажлын хэсэг 81.

Ц.Ганцэцэг: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Эхнийх нь тэр хөдөлмөрийн чадвар түр алдсаны

тэтгэмжийг ажил олгогчоос эхний 5 өдрийн тэтгэмжийг олгоод явж байгаа. Энэ дээр хуулиар зохицуулах боломж байхгүй юу гэж байна. Ер нь бол тэтгэмжийн даатгалын сангийн зардал сүүлийн жилүүдэд бас нэлээн өсөж байгаа. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг жилдээ 80 орчим мянган хүн авч байгаа. Эхний 5 сарын байдлаар 61 мянган хүн аваад явж байна. Ажил олгогчийн энэ 6 хоногт ноогдох тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас өгвөл тэтгэмжийн даатгалын сан маань энийг хариуцах боломжгүй байгаа. Өөрөөр хэлэх юм бол орлого нь зарлагаа хаахгүй ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Энэ анхнаасаа хуулийн үзэл баримтлал бол бас аж ахуйн нэгж, байгууллагуудаас ажиллагсдынхаа эрүүл таатай орчин, ажлын нөхцөлийг сайжруулах, энэ дээр бас анхаарах энэ хариуцлагын үүднээс ажил олгогчдын эхний 5 өдрийн тэтгэмжийг олгох ийм зохицуулалт тухайн үедээ орж байсан. Энэ асуудал энэ хэвээрээ өнөөдрийн хуулийн төсөлд бол явж байгаа.

2 дахь асуудлын хувьд тэр тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа. 2008 оноос эхлээд хуулийн энэ зохицуулалт хэрэгжээд эхэлсэн. Ахмад настнууд, хөгжлийн бэрхиээлтэй иргэд өнөөдөр тэтгэврээ тогтоолгогчлоод ажиллаж байгаа тохиолдолд тухайн ажилласан нийт 12 сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нь 1,5 хувиар тооцоод авч байгаа тэтгэврийг нь нэмэгдүүлээд явж байгаа. Нийгмийн даатгалын сангийн мэдээллээр бол 30 орчим мянган ахмадууд, хөгжлийн бэрхиээлтэй иргэд энэ хуулийн үйлчлэлээр энэ үйлчлэлийг аваад явж байна. Энэ дотроо 15 орчим мянга нь бас хөгжлийн бэрхиээлтэй хүмүүс байдаг. Зүгээр нэг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа бас харьцангуй цахимжааад явж байна. Бид нар нийт үйлчилгээнийхээ 80 орчим хувийг цахим хэлбэрт шилжүүлээд, мэдээллийн сандаа тулгуурлаад энэ тэтгэврийн өөрчлөлт, тэтгэврийг нэмэх,

тэтгэмжийг олгох, өргөдөл авах энэ бүх процесс бол үндсэндээ цахимжсан. Тэгэхээр бас гишүүний хэлж байгаа тэр заавал өргөдөл авах уу, үгүй юу гэдэг дээр бас ярилцаж болно. Зүгээр хүнээс яагаад өргөдөл хүсэлт авах гээд байгаа вэ гэхээр тэр хүн маань хөдөлмөрийн чадвараа алдсан, сэргээгдсэн байна уу, нас барсан байна уу, хэзээ ажлаасаа халагдсан гэдгээ өөрөө тэр мэдээллээ бас өгөх үүрэгтэй учраас ямар нэг байдлаар энэ хүсэлтийг нь аваад байгаа юм. Тэгээд өөрчлөгдсөн тэтгэврийг нь хуулиар зохицуулаад, хэрвээ тухайн сарын 15-аас өмнө өргөдлөө өгсөн бол энэ сарынх нь 1-ээс, 15-аас хойш гэсэн бол дараа сарын 1-ээс өөрчлөгдсөн тэтгэврийг нь олгоё гэдэг энэ хуулийн зохицуулалтаар ингээд явж байна.

Оршуулгын тэтгэмжийн хувьд бол бид нар бас нэр томъёог нь нэлээн өөрчилсөн. Даатгуулагчид өөрт нь бол олгодоггүй ийм тэтгэмж ар гэрт нь олгож байгаа. Тийм учраас ерөнхийдөө бүх хуульдаа энэ тэтгэмжийн даатгалын сангаас олгож байгаа үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгож байгаа оршуулгын тэтгэмжийн нэр томъёог нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж гэж ингэж нэрлэсэн байгаа. Тэгээд энэ хуулийн бүх агуулгаар бол энэ нэр томъёо өөрчлөгдөөд энэ төсөлд орсон байгаа.

Г.Занданишатар: 81.

Ц.Ганцэцэг: Салбарын хяналт яамдад ирсэнтэй холбоотой мэргэжлийн хяналтын байгууллага байх үед энэ сүүлийн 2 хууль Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн хууль өргөн баригдаад, нөгөө буцааж татагдаагүй ийм хууль учраас салбарын хяналт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бид нар энэ нэр томъёог бол өөрчлөөд төсөл дээрээ бол тусгасан

байгаа. Энэ зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор орж ирнэ.

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Надаа нэг асуулт, тэгээд 1 санал байна. Энэ тэтгэврийн нөөц санг бүрдүүлэхдээ Ирээдүй өв сангаас болон Улсын төсвөөс гэж орсон харагдаад байна л даа. Тэгээд ирээдүй өв сан гэдэг чинь өөрөө хуультай 2030 он хүртэл тэндээс чинь мөнгө зарлагдахгүй байхаар хуульчлагдсан байгаа шүү дээ. Тэгээд эндээс яах гэж байгаа юм мөнгийг нь авч, энэ тэтгэврийн сан руугаа нөхөж оруулдаг болгох гээд байна уу. Ямар учиртай юм энэ дээр тайлбар авчихмаар байна.

2 дугаарт энэ малчин, туслах малчин даатгуулах буюу 50 хувийг нь улсын төсвөөс төлнө гэгчихсэн нэг ийм заалт яваад байгаа юм. Тэгээд яана гэсэн үг юм бэ. Энэ хувиараа бизнес, аж ахуй эрхлээд явж байгаа хүний тэтгэврийг нь 50 хувийг нь төсвөөс төлөөд байдаг байх юм уу. Тэгээд тариаланчийг яах юм. Одоо эсвэл ТҮЦ ажиллуулж байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг яах юм. Энэ чинь зүгээр л сайн дураараа нийгмийн даатгалыг төлдөг л иргэн. Тэгж ойлгож байна шүү дээ. Эсвэл тусдаа энэ анги бий болгоод байгаа юм уу. Малчин гэдэг маань бол өнөөдрийн юунаас харахад бол малчин чинь бол дундаж ангид орчхоод байгаа шүү дээ. Ер нь бол. Тэгээд энэ дээр бол би энд яг яагаад энийг оруулсан гэдгийг нь асуучихмаар байна. Эсвэл энийг буцаагаад татмаар байна. Энэ чинь бол шударга бус шүү дээ. Тэгээд нийгмийн даатгалын сан, Тэтгэврийн сан гэдэг чинь бол тэр иргэдийн төлсөн нийгмийн даатгалаас бүрддэг сан болохоос биш, тэгээд хэн нэгний өмнөөс ингээд нийгмийн даатгал нь төлөөд яваад байдаг хуримтлал үүсгэдэг сан бол биш шүү дээ энэ чинь.

Г.Занданишатар: Ажлын хэсэг. Хэн хариулах уу. Хишигбаяр 83. Төрийн нарийн бичгийн дарга.

А.Хишигбаяр: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Тэтгэврийн даатгалын тогтолцоог хуваарилалтын хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу буюу хагас хуримтлалын тогтолцоо руу шилжүүлэхийн тулд бол хэд хэдэн арга хэмжээ авна гэдэг байдлаар бол хуулийн төсөл томъёолсон байгаа. Нэгд өнөөдрийн шимтгэл төлж байгаа даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг бол бид нар цаашидаа бэлэн мөнгө болгоод хадгалаад, хөрөнгө оруулаад ингээд явна.

Мөн өнөөдрийн нэрийн дансны үлдэгдэл буюу 1,4 сая хүний нэрийн дансны үлдэгдэл хийсвэрээр бол бүртгэгдсэн байна. Энэ бол өнөөдрийн байдлаар 27 их наяд бүртгэгдсэн байна. Энэ 27 их наядыг бас тодорхой хэмжээгээр бид нар мөнгөжүүлж явах нь зүйтэй гэдэг байдлаар хуулийн төсөлдөө бол оруулж ирсэн. Ингэхээр бол 2 арга замаар бол мөнгөжүүлнэ гэж үзсэн байгаа.

1-д Ирээдүйн өв сангийн тухай хуульд 2030 оноос Засгийн газар руу бас тодорхой хэмжээний зардал гаргана. Тэгэхээр 2030 оноос хойш энэ зардлаас бол тодорхой хэмжээгээр нэрийн дансны хийсвэр бичилтийг мөнгөжүүлнэ.

2-т. Засгийн газар тухайн үед бас тодорхой хэмжээгээр боломжоороо бас нэрийн дансны мөнгийг бас мөнгөжүүлээд явах нь зүйтэй гэдэг байдлаар бол хуулийн төсөлд тодорхойлсон байгаа. Энэ Ирээдүй өв сангийн хуулийн 2030 оноос хэрэгжинэ гэдгийг бол энэ хуулийн төслийн 46.2 дээр бол бид нар хэрэгжүүлэх хугацааг нь тусгаад өгчихсөн байгаа. Тусгай. Тэр нь бол 2030 оноос эхэлнэ гээд тодорхой тусгаад явчихсан байгаа.

2 дахь асуудал бол малчдын асуудал байгаа. Өнөөдөр бас энэ нийгмийн даатгалын багц хуулийг боловсруулахдаа бид нар тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого буюу 2030 он хүртэл баримтлах бодлого гэдэг дээр үндэслэж байгаа. Энэ бодлогын тухайд бол малчдыг бол тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн даатгалд хамруулна. Ер нь бол албан журам байна гэдэг агуулгаар бол бодлого дээр бол тусгагдсан байгаа. Өнөөдөр бол Нийгмийн даатгалын шимтгэлийг малчдаас шууд албан журам болгоод ингээд явахад бас цаг хугацааны хувьд бас боломжгүй байна гэж харж байгаа. Яагаад гэвэл малчдын Нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн шимтгэлийг нөхөн төлүүлэх хууль 2020, 2021 онд хэрэгжүүлсэн. Энэ дээр малчид маань ерөөсөө 30 мянган малчин л нөхөн төлсөн. Тэгээд дандаа тэтгэвэр нь ойртсон малчид л төлсөн болохоос яг залуу малчид бол төлөөгүй. Тэгэхээр өмнө нь бас мөн 2012 онд бас тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх тухай хуулийг бас хэрэгжүүлсэн байгаа. Энэ дээр ч гэсэн малчид маань бас бүрэн хамрагдаж чадаагүй байгаа. Тэгэхээр ингэж боломж 2, 3 удаа хууль батлаад байгаа хэдий ч малчид маань өнөөдөр хамрагдахгүй байна. Ийм учраас шууд ийм албан журам бол болох юм бол яг байнгын орлого олж чадахгүй. Зөвхөн улирлын чанартай орлого олдог энэ даатгуулагчдыг бол шууд албан журмаар сар болгон та нар шимтгэлээ төл гэдэг асуудлыг тавих юм бол өнөөдрийн хувьд бол цаг хугацааны хувьд бас болоогүй байна гэж үзээд ямар ч байсан 5 жил малчдын Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийг төр хариуцаад, тэгээд 50 хувийг нь өөрөө хариуцсан явна. Гэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хамгийн доод талын хэмжээгээр бол шимтгэлийг нь 50 хувийг нь хариуцна. Хэрвээ малчин өөрөө хүсээд дээшээ өндрөөр бол төлнө гэвэл тэрийгээ

бол өөрөө 100 хувь хариуцаад явахаар бол хуульд зохицуулалт оруулаад явчихна.

Г.Занданишатар: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулъя.

Х.Ганхуяг: Тэгээд ирээдүй өв сангаас яагаад мөнгө авах гээд байгаа гэдэг шалтгаанаа та өөрөө ингээд энэ хуульд оруулчхаад байгаа байхгүй юу. Малчдын 50 хувийг нь төлнө гээд. Тэр нийгмийн даатгалын сан гэдэг чинь хүн болгоны өөрийн төлж байгаа хуримтлуулж байгаа сан болохоос биш тэнд хэн нэгний өмнөөс өөр эх үүсвэрээр нийгмийн даатгалыг нь төлөөд явна гэсэн утгатай бол биш шүү дээ. Та халамж, тэтгэвэр гэдгээ ялгамаар байна шүү дээ. Яагаад талаараа дүүрэн малтай, мянгад малчны тэтгэврийг, ипотекийн зээлтэй, лизингтэй иргэд төлж байх ёстой юм. Татварын мөнгөөр төлж байх ёстой юм. Та юу яриад байгаа юм бэ. Наадхаа болимоор байна шүү дээ Булгантуяа сайд аа. Боль, боль. Энийгээ татаж авмаар байна.

Г.Занданишатар: Зочид танилцуулъя. Баянхонгор аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Тэгээд эх нутаг, төрөлх сургууль, ачит багш нараа эргэн дурсаж гээгээн дурсамжийн эргэн уулзах уулзалт хийж байгаа өдрийнх нь мэндчилгээг та бүхэнд дэвшүүлээд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе, дурсамж дүүрэн сайхан өдрийг өнгөрүүлээрэй.

Улсын Их Хурлын гишүүн бол бүрэн эрхийнхээ хүрээнд асуулт асууж, санал дэвшүүлж болно. Тэгэхдээ дэгийн тухай явах ёстой. Тэгэхдээ байна шүү дээ, Ганхуяг гишүүн ээ, таны хэлж байгаа энэ агуулга байна шүү дээ нийгмийн даатгалын шимтгэлийн сан гэдэг маань шимтгэлээр санд мөнгө хуримтлуулаад, тэрийг өсгөж арвижуулаад тэгээд ирээдүйд ингээд төлж байгаа л хэлбэр

шүү дээ. Татвар төлөгчдийн мөнгөнөөс санхүүжүүлдэггүй гэж ярих юм бол 3,5 их наяд төгрөг, үндсэндээ улсын төсвийн татвар төлөгчдийн мөнгөөр ингээд санхүүжүүлээд, тэгээд яг ингээд сангийн үндсэн агуулга, зорилго, эв санааны зарчим, хуримтлалын сан болох нь битгий хэл ийм зарчимтай болчихоод, тэгээд хуримтлалын зарчимд орж байна гээд философи агуулга нь ихээхэн зөрчилтэй. Мэдээж манай ажлын хэсэг бол маш няхуур хандаж санал хураалт бол аягүй сайн ажилласан. Манай ажлын хэсэг сайн ажилласан. Яам ч гэсэн сайн ажилласан. Ойлгож байна. Тэгэхдээ энд улс төргүй болчихсон гэж хэлэх гээд байгаа юм. Тэгээд улс төрийн шалтгаан хамгийн гол юм нь байна шүү дээ менежмент нь сангийн орлого тал нь дандаа depreciation төгрөгийг depreciation болгоод энийг хадгалж үржүүлж байх ёстой юм чинь. 1990 оны 1000 төгрөгийн цалин авч байсан хүн 10 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 20 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан чинь одоо тэр үнэлгээгээр үнэлээд итгэлцүүр нь буруу л байгаад байгаа байхгүй юу. Тэгтэл сүүлийн 5 жил маш өндөр цалин нь одоо ингээд 40 жил ажилласан Долгорсүрэн гэдэг багш 593 мянган төгрөгийн тэтгэвэр авч байна. Тэгтэл 20 жил ажиллаад өндөр цалинтай байсан бол 1 сая 380 мянган төгрөгийн тэтгэвэр авч байгаа байхгүй юу. Тэрнээс доод албан тушаалын багш ч юм уу ажил хийж байсан хүн. Энэ нөгөө тэгш шударга, ёсны зарчим, эв санааны зарчим энэ тэр гэдэг үндсэн зарчим алдагдаад, тэгээд ингээд нэг янз янзын юм хөнгөлөөд нэмээд нөгөө халамжийн бодлого энэ тэртэй холилдоод төсвөөс ингээд татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг. Татвар төлөгчдийн мөнгө чинь шал өөр зорилготой мөнгө. Нийгмийн даатгалын сангийн шимтгэл чинь энд ирээдүйд мөнгөө авах гэж байгаа тэр тэтгэврийн сан нь үржиж байх ёстой. Энэ тэтгэврийн санг нь яаж орлогоо нэмэгдүүлэх юм гээд байгаа юм. Орлого нэмэх мэдээж бааз суурь

шимтгэл төлөгчдөө нэмэгдүүлэх эдийн засаг өсөх олон асуудалтай холбоотой. Гэхдээ тэр орж ирсэн мөнгөө хулгайд алддаггүй, банканд хийгээд алдчихдаггүй үржээд байдаг, өсөж байдаг, ядаж хүүгээрээ өсөж байдаг тийм систем хийхгүй бол энэ чинь дандаа ингээд сангаа хоосолчихоод яваад байсан. Тэгэхээр энэ үндсэн шаардлагатай их үндсэн философи реформ нь ингээд л. Тэгэхээр энэ бол бас Ганхуяг гишүүний хэлээд байгаа яг эдийн засгийн агуулга талаасаа энэ бас уг нь зөв байхгүй юу. Тэгээд л бид нар яах вэ, улс төр гээд л 5 жил болгоод л, 10 жил болгоод л. 5 жил байна шүү дээ 126 тэрбум болохгүй ээ, 10 дахин их болгоно гэж. Тэгээд мал аж ахуйн татварыг албан журмын болгох юм бол байнгын мөнгөн орлогогүй улсуудаас яаж авах вэ гээд л олон асуудал үүснэ л дээ. Яах вэ ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үгүй ээ яах вэ, нэг асуудал нь татвар төлөгчдийн мөнгө байхгүй өөрөө ингээд санхүүжүүлээд явна гээд цөөхөн татвар хэлээд байгаа юм. Яг үнэндээ 4,1 их наядын нийт зарлагатай шүү дээ. Нийгмийн даатгалын сангийн олгож байгаа тэтгэвэр. Үүний 774 тэрбум төсвийн татаас байгаа юм. Татвар төлөгчдийн мөнгө байгаа юм. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тэгэхдээ ерөнхийдөө дэвшил ахиц бол бий. Зүгээр энэ Пүрэвдорж гишүүний 5 жил болгодог бол тэгээд энэ саналыг ингээд дагаад явдаг бол өндөр тэтгэвэр авагчдад л илүү сайн үйлчилнэ. Нийт тэтгэвэр авагчдад нөлөөлөхгүй бөгөөд татвар төлөгчдийн нуруун дээрх ачааллыг нэмэгдүүлнэ. Дараа нь дээр нь хамгийн гол юм нь энэ итгэлцүүрийн асуудлыг л хаягдуулж байгаа юм. Итгэлцүүр л хамгийн чухал байгаа юм. Уг нь итгэлцүүрийг л зөв тогтоож чадвал тэтгэвэр нийт иргэдэд, нийт тэтгэвэр авагчдаа зөв нөлөөлөх ийм асуудал байгаа юм.

Одоо энэ Төв аймагт яг анхан шатад ажиллаж байгаа хүн бол яг хэлнэ. Итгэлцүүр чухал биз тийм ээ. Ингээд 2015 оны тэр тэтгэврийн шинэтгэлийн зарчим чинь нэмэгдүүлэхэд чиглэж байсан шүү дээ. 5, 7, 10 жил болгох гэж. 10 жил болгох юмыг л ингээд эргээд буцаж байгаа юм. Тэгээд яах вэ, 10 жилдээ гол биш. Итгэлцүүрийн л асуудал байгаа юм.

Чинзориг сайд л уг нь яг энийг яриад л байгаа юм. Одоо асуулт, хариулт дуусчихсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Ер нь Анужин гишүүнтэй ажлын хэсэг болон үг үсэг, найруулгыг бол их сайн ажилласан юм байна лээ. Энэ дээр бол боловсролын хуулийг бодох юм бол их чамбай ажилласан байгаа юм.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг суурь болгож, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нараас өргөн мэдүүлсэн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэх. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин, Жигжидийн Батжаргал, Сайнхүүгийн Ганбаатар, Тогмидын Доржханд, Бадарчийн Жаргалмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Цэндийн Мөнх-Оргил, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Сандаг-Очир, Батсүхийн Саранчимэг, Цэвэгдоржийн Туваан, Содномын Чинзориг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/. Санал хураалт. Санал хураалт хүчингүй

болсон. Ирц байхгүй болсон учраас энэ асуудлыг хойшлууллаа.

Хурал тасалсан гишүүдийг ирцэд бүртгэе. Ингэд явуулахгүй бол тэр л биз. Ингээд саяны асуудал хойшилсон учраас дараагийн асуудалд орёе.

16.29 цаг.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь

хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд ажлын хэсгээс нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 9 санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 1 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөхтэй мөн адил. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд

байна уу. Алга байна. Санал хураалтад орно. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 10 санал байгаа. Гишүүд суудалдаа суугаарай.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрх үүсэх нөхцөл, хэмжээ, хугацаа,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, С.Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/. Санал хураалт.

2.Төслийн 2 дугаар зүйлийн гарчгийн “хөнгөлөлт” гэсний дараа “, шимтгэлийн төлбөр” гэж нэмж, мөн зүйлийн 2.1 дэх хэсгийн “тэтгэмжийг” гэснийг “тэтгэмж, шимтгэлийн төлбөрийг” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.1.4 дэх заалт нэмэх:

“2.1.4.гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн төлбөр.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтын урилгаар Ховд аймгийн 4 дүгээр 10 жилийн 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ховд нутгийн сайхан нутгаа эргэн дурсаж, төрөлх сургууль, ачит багш нарынхаа гэгээн дурсамжийн уулзалт хийж байгаа та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Саяын санал 52.6 хувиар дэмжигдсэн.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн хөлс” гэснийг

“цалин хөлс” гэж, мөн хэсгийн “3-60” гэснийг “3-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баярлалаа. Дандаа 3-аар төгссөн, 93, 2003 оны төгсөгчид орж ирээд байгаа. Манай Бямбацогт сайд хуралдаа байнга суудаг гайгүй сайд байгаа шүү. Хурал, чуулганд идэвхтэй оролцож байгаа. Харьцангуй томоотой. Уг нь Чинзориг сайд идэвхтэй суудаг. Гэхдээ жооохон сахилгагүй.

4.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Энэ зүйлийн 9.1-д заасан нөхцөлийг” гэснийг хасаж, мөн хэсгийн “нөхцөлийг” гэснийг “эрхийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санад хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан” гэснийг “Даатгуулагчид олгох ажилгүйдлийн тэтгэмжийг түүний шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн” гэж, мөн хэсгийн “24-60” гэснийг “24-59” гэж, “61-120” гэснийг “60-119” гэж, “121-180” гэснийг “120-179” гэж, “181” гэснийг “180” гэж, мөн зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

7.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах.Санал гаргасан ажлын

хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хүсэлтээ” гэснийг “хүсэлт, ажил идэвхтэй хайж байгаа тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын тодорхойлолт болон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 71.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна. Санал хураалт явуулах бололцоотой гэж үзвэл түрүүчийн саналыг эргүүлж явуулъя.

Санал хураалтын хэд дээр явж байлаа. Одоо нэг санал хураалт явуулна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

Нэг.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг, 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухай хуулиар.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулж дууслаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан байгаа. Одоо санал хураалт явуулна. 24 саналтай. Ингээд л буруу юм яриад байгаа юм даа. Машиндана гэхээр чинь л. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Ер нь ажлын хэсэг улс төрийн шийдвэр гаргаад дээрээс нь л шахаж байгаа болохоос эд нарт ч бас нэг их 10, 5 тоондоо буруу ч юу байх вэ дээ. Хамгийн гол нь тэр 50 жилийн дараах хуримтлал үүсгээд, тэрнээс төлөх ёстой гэсэн тэр актуар хуримтлалын тооцооллын тооцооллоо маш сайн нарийн хийж л сурмаар байгаа юм. Тооцоолол бол дандаа алдаатай тоонууд хэрэглэгдээд байгаа. Зөрүүтэй тоонууд л яригдаад байгаа учраас гайхаад байгаа юм л даа.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

Томъёоллыг унисан, ажлын хэсгийн гэдгийг хэлсэн. 2 саналыг нийлүүлж уншиж байгаа юм. Энэ санал хураалтыг

явуулна. Энэ санал дэмжигдэхгүй бол нэгтгэж хэлэлцэхгүй, салгаж хэлэлцэх нь. Санал хураалт. Доржханд гишүүн. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлд доор дурдсан 2.1.6 дахь заалт нэмэх:

“2.1.6.”хүндэтгэн үзэх шалтгаан” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.41-д заасныг.” Санал гаргасан ажлын хэсэг. 5 жилээр тооцогддогийг буцааж үйлчлэх үү Пүрэвдоржоо. 65.8 хувиар санал дэмжигдлээ.

2019, 2020 онд тэтгэвэрт гарсан хүмүүст үйлчлэх үү. Тэр гарах маргааныг л хэл амыг чи дараа нь хариуцах нь байна шүү дээ. Тэнгэр, газар шиг ялгаатай тэтгэвэр тогтоно шүү дээ.

3.Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн “ТОГТОЛЦОО” гэснийг “ТӨРӨЛ” гэж өөрчилж, төслийн 3 дугаар зүйлийг 4 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хувийн нэмэлт тэтгэвэр

4.1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.2-т заасан даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болно.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэврийн харилцааг Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиар зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгон дугаарыг өөрчилж зүйлийн гарчгийн “тэтгэвэр” гэснийг “тэтгэврийн төрөл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Манай хүн амын цонх маш ашигтай үед яваа байхгүй юу. Япон энэ тэр шиг өндөр настны улс болсон биш. Энэ үедээ реформ хийж амжсан бол ирээдүйд ирэх

дарамтыг их бууруулах байсан. 50 жилийн дараа.

57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “55” гэснийг “50” гэж, “50” гэснийг “45” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.1.4 дэх заалтад хамаарах тайлбарыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Даатгуулагч” гэснийг хасаж, “төрсөн,” гэсний дараа “мөн энэ хуулийн 5.1.3, 5.1.4, 5.1.5, 5.1.6, 5.1.7-д заасан даатгуулагч” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн томъёоны “НДс₂” гэснийг “НДс₃” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Чинзориг сайд үг хэлье гэсэн үү. Больсон байна. Ер нь Ганцэцэг бол 7-г 5 болгох нь зөв гэж бодож байна уу. Итгэлцүүрийг зөв болгох нь зөв гэж бодож байна уу. Яг хувь хүний бодол. Итгэлцүүрээ цэгцлэх нь л зөв шүү дээ тээ. Саяны итгэлцүүр цэгцэлдэг бол маш сайн алхам болсон. Булгантуяа сайдын хийдэг. Энэ ахиад ингээд баахан л зөрүү гарах болж байгаа юм. Ер нь гол нь л итгэлцүүр л дээ. Сая бол харьцангуй итгэлцүүрээр овоо цэгцэлсэн. Ахиад задлаад хаячихаж байгаа юм даа. Одоо цаг хугацааны хувьд эргэж үйлчилэхгүй бол 2021 онд гарсан, 2020 онд гарсан хүмүүсийн тэтгэвэр яг адилхан ажил

хийж байсан 2 хүний тэтгэвэр маш зөрүүтэй болно.

9.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “04” гэснийг “01” гэж өөрчлөн, мөн зүйлд доор дурдсан 27.2 дахь хэсэг нэмэх:

“27.2.Энэ хуулийн 27.1-д заасны дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлалыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“29.1.Энэ хуулийн 27.1 дэх хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан 29.3 дахь хэсэг нэмж, 29.3 дахь хэсгийн дугаарыг “29.4” болгож, мөн хэсгийн “25.1-д” гэснийг “25.1, 29.3-т” гэж өөрчлөх.

“29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодно.” Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Бид нар бол нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль дээр 29.3 гэж заалт шинээр нэмэх гэж байгаа юм байна. Энэ заалт нь юу байна вэ гэхээр энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан 6, 7 жилийн

цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр бодуулсан тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-т заасны дагуу нэг удаа өөрчлөн бодно гэдэг ийм заалт нэмье гэж байгаа юм байна. Хууль зүйн техникийн хувьд бол энэ тэтгэврийн тухай материаллаг хуульд суух харилцаа биш байна гэж хэлэх гэж байгаа юм. Энэ бол дагаж мөрдөх журмын хуульд ордог процессын шинжтэй асуудал байна. Материаллаг хууль буюу тэтгэврийн хууль бол нэг удаагийн харилцааг зохицуулж байгаа хууль бол биш. Энэ хууль өөрчлөгдөхгүй бол энэ тэтгэврийн хууль бол 100 жилийн дараа ч хүчин төгөлдөр үйлчилж байна. Үйлчлэх хууль байхгүй юу. Энэ нэмэх гэж байгаа 29.3 бол нэг удаа үйлчлэх гэж байгаа нийгмийн харилцааг зохицуулсан шилжилтийн процесс бичсэн асуудал байна. Ийм харилцаа бол материаллаг хуульд ордоггүй. Дагаж мөрдөх журмын хуулиар зохицуулагддаг. Тийм учраас би энэ материаллаг хуульд буюу эх хуульд нь орох харилцаа бол биш байна. Энэ харилцааг дагаж мөрдөх журмын хуулиар зохицуулах ёстой харилцаа юм биш үү гэдэг хууль зүйн цэвэр техникийн шинжтэй зүйлийг хөндөж байгаа юм. Тэрнээс биш би тэр 5 нь байна уу, 6 байна уу, 7 байна уу. Тэр нь нэг удаа өөрчлөх байна уу, өөрчлөхгүй байна уу гэдэг би агуулга руу нь огт байр суурь илэрхийлэхгүй байгаа шүү гэдгийг ойлгож хүлээж авахыг хүсье. Энийг яах ёстой юм бол. Энэ яг цэвэр дагаж мөрдөх журмын процесс яваад байгаа юм.

Г.Занданиатар: Тэгэхдээ энэ хууль зүйн техникийн хувьд Баттөмөрийн Энхбаяр гишүүн ээ, энэ нөгөө ерөнхий хууль дээрээ ч гэсэн энэ хууль дээрээ 29 дүгээр бүлэг нь юу байхгүй юу. Дагаж мөрдөх журмын тухай хууль гэж гараагүй. Дагаж мөрдөх журмын зохицуулалт гэсэн бүлэг байгаа 29 нь. Дагаж мөрдөх журмын зохицуулалт дээрээ 1 нь 2025 оны 1 сарын 01-ээс мөрдөнө, Нийгмийн

даатгалын ерөнхий хууль дээр ч гэсэн 2024 оны 1 сарын 01-ээс дагаж мөрдөх. Тэгэхээр дагаж мөрдөх журмын зохицуулалт дээрээ орчиход бол болно. Гэхдээ ганцхан энэ материаллаг зохицуулалт нь буцаж үйлчлэх л тэрний яг тооцооллыг хийсэн юм болов уу. Энэ бас л их ярвигтай л асуудал байгаа. Хууль зүйн техникийн хувьд бол болох байх. Яг санхүүжилтийн хувьдаа л асуудал гарч магадгүй.

Тэгэхээр шинэчлэн тогтоож болно гэдэг чинь үндсэндээ нэмүү тэтгэвэр авахаар хүн бол дахиж тэтгэврээ тогтоолгож болно гэсэн үг байна шүү дээ тээ. Гэхдээ энэ бол одоо морал хозард үүсэхгүй юм чинь юу нь гайгүй байх л даа. Энэ болох байх. Өөрчилж бодох л юм байна. Санал хураалт. 55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Сая би дарсан. Минийх асахгүй байсаар байгаад өнгөрчихлөө. Би уг нь дэмжээд дарсан юм. Тийм учраас саяын саналыг хүчингүй болгож, дахиад санал хураалгаж өгнө үү гэсэн санал гаргаж байна.

Г.Занданиатар: Төхөөрөмж бас хаяа тэгээд байгаа юм. Нямаагийн Энхболд гишүүний гаргаж байгаа горимын саналаар санал хураалт явуулъя. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо гишүүд анхааралтай байгаарай. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна шүү.

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “10” гэснийг “20” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг. Содномын Чинзориг гишүүн үг хэлнэ.

С.Чинзориг: Энэ хууль дээр ийм 1 шинэ зохицуулалт орж байсан юм байна лээ. Бас л гадна талын юм. Бараг л Эрдэнэ-ийн боловсруулж оруулж байсан нөгөө хамтын тэтгэвэр гээд юм байсныг бид нар 2016 онд Засгийн эрх аваад ийм юм байж болохгүй гээд буцаасан шүү дээ. Тэрний л нэг хувилбар. Хамт амьдарч байсан гэр бүлийн 2-ын 1 нь бурхан болбол үлдсэн хүнд нь нөгөө хүнийх нь тэтгэврийн 20 хувийг нь нэмэгдэл болгож олгоно гээд. Тэгээд Монголчууд чинь бол уламжлалт гэр бүлийн харилцааг дэмждэг ард түмэн. Нөгөө талаас гэр бүл бол нэлээн урт хугацаанд бат бэх байх нь чухал. Тийм учраас 10 жилээс дээш хамт амьдарсан гэр бүлийн 2-ын 1-нд үйлчлэхээр байгаа юм. Би бол 10 жил нь арай бага байна гээд байгаа юм. Ядаж 20-оос дээш жил хамт амьдарсан 2-ын 1-нд нь энэ тэтгэврийн 20 хувийг. Энэ бол уламжлалт гэр бүлийн харилцааг дэмжсэн, нөгөө талдаа гэр бүл бат бэх байх энэтэй холбоотой, тогтвортой байх энэ бодлого нь байх ёстой гэж бодсон Тийм учраас 10 гэдгийг 20-оос дээш жил болгоё гэж зарчмын зөрүүтэй санал гаргасан юм. Тэгээд Байнгын хороо дээр олонх дэмжлэг аваагүй. Тийм учраас энийг анхаарч үзээд санал хураалтаа бодооч гэсэн саналтай байгаа юм.

Г.Занданиатар: Санал хураалт явуулъя. Нийгмийн бодлогын байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. Улсын Их

Хурлын гишүүн Содномын Чинзоригийн санал босож ирлээ. Дэмжигдлээ гэсэн үг.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн 29 дүгээр зүйлд доор дурдсан 29.3 дахь хэсэг нэмэх:

“29.3.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө дараалсан зургаа, долоон жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр авагчийн тэтгэврийг түүний хүсэлтэд үндэслэн энэ хуулийн 20.1-д заасны дагуу нэг удаа өөрчлөн бодож зөрүүг буцаан олгоно. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр тэтгэврийг бодохдоо цалингийн 7 жилийн дунджаар боддог байсныг нь 5 жил болгож өөрчилж байгаа. Тэгэхээр ирээдүйд тэтгэвэрт гарах гэж байгаа хүмүүс бол энэ ямар ч асуудалгүй байна гэсэн үг. Тэгэхээр 2018 оноос хойш 6 жил, 7 жилээр бодуулсан энэ хүмүүсийн хувьд тодорхой зурвас хугацаанд хохирч үлдэх ийм нөхцөл байдал бий болж байна. Өөрөөр хэлбэл энэ бол тэдний буруугаас биш, төрийн буруу бодлогын үндсэн дээр энэ асуудал болсон. Тийм учраас энэ хугацаанд өөрсдөө шимтгэлээ 24, 25 хувиар төлчөөд авах болохоороо бага тэтгэвэр авдаг энэ зүйл маань 7 жил болсноор бүр их хатуу болж байгаа. Тийм учраас энэ хүмүүс ингэж хохирч үлдэх ёсгүй. Тийм учраас энэ зөрүүг нь буцаан олгох ёстой. Буцаан олгох ёстой. Энд бол ойролцоогоор 91 тэрбум төгрөг шаардлагатай гэж ажлын хэсгийнхэн үзэж байгаа юм байна. Тэгэхээр энэ хүмүүсийг хохироогоод үлдчих юм бол зурвас хугацаанд л хэдхэн хүн 5 жилийн хугацаанд хэдэн хүн л насаараа гомдолтой үлдэх ийм нөхцөл байдал руу орж байна л даа. Би хэрвээ жоохон өндөрхөн шиг тэтгэвэр авч байсан бол ийм ийм орлого илүү олох байсан гэдэг л ийм бодолтой үлдэх байхгүй юу даа. Тэгээд нэг зүйлийг хэлэхэд түүний

хүсэлтэд үндэслэн гэж байгаа шүү. Энэ хүсэлт нь бол мэдээж 7 жилээр бодуулсан тэр хүмүүс хамгийн өндөр цалинтай тэр хэсгээ л сонгож авсан байж таараа. Тэгэнгүүт энэ нийгмийн даатгалын байцаагч нар яав вэ гэхээр та энэ 7-ынхоо алийг нь авах юм бэ гэдэг ийм хүсэлтийг л авах юм байна лээ. Өөрөөр хэлбэл танаар сонголт хийлгэнэ гэсэн үг. Тэгэхээр энэ дээр манай хүмүүс автоматаар бодогдчих юм шиг битгий бодоорой. Тийм учраас заавал хүсэлт өгнө. Тэр хүсэлтийн дагуу шийдэгдэнэ. Тийм учраас энэ дээр нэлээн хариуцлагатай байгаарай гэж хэлье. Тэгээд энэ санал бол Байнгын хороо дээр унасан. Тэгэхээр энэ саналыг кноподоо гар хүрэхгүй байгаад дэмжиж өгөөрэй гэж та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналыг дэмжинэ. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Сая уншиж танилцуулсан. Санал хураалт. Гэхдээ энэ яах вэ 5 жил яг энэ хугацаанд тохиолдож байгаа нь илүү эрсдэлтэй байгаа нь инфляцаас шалтгаалаад юмны ханих их унасан, тэрийг дагаад цалин нэмэгдсэн. Үүнээс дагаар гарах тэтгэврүүдийн чинь инфляцын нөлөөлөл нь орлого тал нь depreciation болоод одоо сангийн орлого нэлээн өсөж байгаа харагдаж байгаа нь ч гэсэн инфляцтай нөлөөтэй, энийг дагаад цалин хөлстэй холбогдоод жоохон өсөлт бий болно. Энийг дагаад гарах эрсдэл нь их байгаа байгаа юм л даа. Одоо сүүлийн 5 жилээр бодоод явахаар энэ цалингийн суурь өссөн нийт нийгмээрээ. Статистикаар ганцхан жилийн, хэдхэн жилийн өмнө дундаж цалин 1 сая байсан бол одоо 1 сая 800 мянга болчихлоо шүү дээ.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд, гишүүн.

Л.Энх-Амгалан: Их Хурлын дарга аа, сая би санал өгсөн боловч миний санал өгдөг төхөөрөмж ажилласангүй.

Тэгээд хүчингүй болгох санал гаргаж байна.

Г.Занданишатар: Хүчингүй болгох горим гаргаж байна тийм үү. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүний горимын саналаар санал хураалт явуулна. Саналаа татаж авч байна гэж ойлгож болох уу. Яагаад гэвэл энэ дэгийн зөрчилтэй санал хураалт байгаа байхгүй юу. Иймд төсөв болон төсөв чинь нийгмийн даатгалын сан ч гэсэн төсөвт ордог. Төсөвт үзүүлэх нөлөөлөл заавал Засгийн газрын саналыг сонсох ёстой. Төсөвт шууд нөлөөлнө шүү дээ.

Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энх-Амгалан гишүүний гаргасан санал байгаа. Горимын санал гэж байхгүй. Дэмжсэн санал дээр горимын санал байхгүй.

Санал хураалт явуулъя. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Байнгын хорооны санал дэмжигдлээ. Цаашаа явъя.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” болон “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гурав.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар” гэж, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3-т” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д” гэж, 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тахир дутуугийн” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж, 24 дүгээр зүйлийн “нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Содномын Чинзориг гишүүн, сайд. Санал хураалт. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн “3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэснийг “4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дөрөв.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил. Байнгын хороо дэмжсэн санал байна. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил. Санал хураалт. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зургаа.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,” Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах.Санал гаргасан ажлын

хэсэг. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлбэ.

Б.Пүрэвдорж: Би түрүүчийн зөрүүг буцаан олгоно гэдэг дээг үг авах гээд арай гэж энэ дээр авлаа. Тэгэхээр энэ хуультай холбоогүй. Тэгэхээр энэ 2018 оноос хойш тэтгэврээ 7 жилээр, 6 жил, 7 жилээр бодуулсан тэр хүмүүс энэ зурвас хугацаанд хохирч, гомдолтой үлдэх ёсгүй. Тэгэхээр энд бол нийтдээ 58 мянган иргэн энэ 6 жил, 7 жилээр бодуулсан байна. Энд бол 91 тэрбум төгрөгийн зардал гарах байсан байна. Тэгэхээр би энэ. 91 тэрбумыг дахиад суулгахын төлөө зүтгэнэ ээ. 2024 оны улсын төсөв дээр суулгах гэж үзнэ. Болохгүй бол тэгээд 2024 онд манай нам ялахаар нь би суулгаад өгнө. Та нар итгэл найдвараа алдалгүй хүлээж байгаарай.

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн энэ Одонтуяа гишүүн, Цогтгэрэл гишүүн 2-н суудлыг заагаад энд би сууна гэж байна. Тэрийгээ та нар дотооддоо яриарай.

Долоо.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хуульд” гэснийг “хуулийн” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найм.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай:

1.“Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энхбаяр гишүүн ээ, Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг чинь Засгийн газар санаачлах эрхгүй шүү дээ. Буцаачхаж байгаа тээ. 63.2 хувиар буцаана.

Ес.Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай:

1.Төслийн 2, 3 дугаар зүйлийг нэгтгэн холбогдох техникийн засварыг хийж, төслийн 2 дугаар зүйлийн “заалтыг” гэсний өмнө “хэсэг, “ гэж нэмэн “өөрчилсүгэй:” гэснийг “өөрчлөн найруулсугай:” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил. Санал хураалт. 1 гишүүн дэмжсэн байна. Тэгэхээр энэ Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй. Цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууссан уу. Залуучууд суугаарай. Дамдинням, Амартүвшин, Энх-Амгалан сайд нар сууя.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

17.20 цаг.

**Дараагийн асуудалд орё.
Нийгмийн даатгалын сангаас олгох**

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй бөгөөд ажлын хэсгээс Нийгмийн

даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 17 санал, найруулгын шинжтэй 1 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж санал, хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаар Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөхтэй нэр, овог, албан тушаал нэгэн адил. Протоколд тэмдэглэсүгэй.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Гишүүд суудалдаа суугаарай. Санал хураалт явуулна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 22 санал байгаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэг, мөн зүйлийн 3.1.3, 3.1.5 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Даатгуулагч дараах нөхцөл байдалд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгоно:”

3.1.3.ажлын цагаар ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд ажил үүргээ гүйцэтгэхээр явж байх үед;

3.1.5.ажилдаа ирэх, буцах зам, ажил үүргийн дагуу сургалтад оролцох болон Хөдөлмөрийн тухай хуулийн 93.1.1-д заасан амрах, хооллох завсарлагын үед;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэв-Очирын Ануужин, Жигжидийн Батжаргал, Сайнхүүгийн Ганбаатар, Тогмидын Доржханд, Бадарчийн Жаргалмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Цэндийн Мөнх-Оргил, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Сандаг-Очир, Батсүхийн Саранчимэг, Цэвэгдоржийн Туваан, Содномын Чинзориг /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Энэ дээр тэр хурц хордлого гэдэг төсөл дээр байсан уу. Санал хураалт явуулъя. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Миний төхөөрөмж ажилласангүй дарга аа, Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалгаж өгөөч баярлалаа.

Г.Занданишатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт.

Манай Сайнхүүгийн Ганбаатар гишүүн жинхэнэ үйлдвэрчний хүн дээ бас. Нийгмийн даатгалын юмыг яс сууж дэмжиж байгаа. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулъя. Дахиж явуулъя санал хураалтыг. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гэхдээ энэ дээр хамгийн их асуудал гарч эрүү үүсээж шалгагдаж байгаа юмнууд бас байгаа шүү дээ. Хурц хордлого гээд юмнууд орчихоор тэр эмч нар тодорхойлолт гаргасан юмнууд гараад байдаг. Тэр чинь энэтэй холбогдох байх. Энийг л хэлэлцүүлэг дээр сайн анхаарвал зүгээр байна.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “ноцтой” гэснийг хасаж, 3.1.8 дахь заалтын “зэрэглэлтэй дотоодын спортын тэмцээн, уралдаанд” гэснийг “хэмжээний спортын тэмцээнд” гэж, 3.2 дахь хэсгийн “тохиолдолд үйлдвэрлэлийн осолд тооцохгүй” гэснийг “нь нотлогдсон тохиолдолд энэ хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохгүй” гэж, 3.3 дахь хэсгийн “ослыг” гэснийг “осол, хурц хордлогыг” гэж, 3.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас” гэснийг “дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос” гэж, 5.3 дахь хэсгийн “Эрүүл мэндийн магадлалын” гэснийг “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37.7-д заасан” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн, 5.4.1, 5.4.2, 5.4.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 5.4.1 дэх заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 12-т хуваасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.5.Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлсөн сар тутамд 0.125 хувиар, 2029 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 0.167 хувиар тооцон тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “6 сарын дотор” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “17.1-д” гэснийг “16.1-д” гэж, мөн зүйлийн 7.3, 7.4 дэх хэсгийн “хөдөлмөрийн” гэснийг “цалин” гэж, 7.7 дахь хэсгийн—“тэтгэврийн ердийн” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас

олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “6.1.1-д заасан хэмжээтэй” гэснийг “21.1.1, 21.2-т заасан хэмжээтэй тус тус” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийн, 9.3.2, 9.3.3 дахь заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “цалин хөлс” гэж, 9.3.1 дэх заалтын “хөдөлмөрийн хөлс” гэснийг “дундаж цалин хөлс” гэж, мөн заалтын “дундаж” гэснийг “нийлбэрийг 3-т хуваасан” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “Даатгуулагчийн” гэсний дараа “тэтгэмж бодох” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “/байцаагч/-д” гэснийг хасаж, 11.1.3 дахь заалтын “мэргэжлийн” гэснийг “хөдөлмөрийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бейсен гишүүн энэ хуулийн талаар сайн мэдэж байж магадгүй юм байгаа юм.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Шимтгэлийн” гэснийг “Тэтгэврийн даатгалын шимтгэлийн” гэж өөрчилж, мөн хэсгийн “хэмжээгээр тооцож” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “даатгалын” гэсний өмнө “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс

шалтгаалсан өвчний” гэж нэмж, 13.3 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.7, 14.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.1.Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дараах эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөрийг олгоно:

14.7.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.

14.9.Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Засгийн газраас өргөн барьсан төсөлд бол тэр 14.9 байхгүй байгаа юм шиг байна. Байнгын хорооноос тэр 14.9 буюу даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журмыг нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэдэг заалт нэмэх гэж байгаа юм байна. Би энийг бол дэмжихгүй л байна. Энэ бол сайдад лай л болох байх. Одоо Эрдэнэ

сайд бол энэ Хөдөлмөрийн сайд байхдаа өөрийнхөө ахмадын амралтын газарт нийгмийн даатгалын сангаас ахмадуудыг амрааж, санхүүжилтийг нь олгодог гээд, үүнээсээ болж өөртөө давуу байдал олгосон гээд албан тушаалын хэрэг яригддаг. Энэ юм нь одоо дууссан ч юм уу, дуусаагүй ч юм уу үе үе гарч ирээд яригдаад л байдаг юм. Тэгэхээр энийг нь сайд өөрөө аль сувилалд яаж мөнгийг нь өгөх вэ, тэгээд тэр дээрээ хэн хяналт тавих вэ гэдэг журмыг сайд батална гэдэг энэ сайдад дараа нь тэгээд насаараа л хонгилын хаалга сахих байх. Тийм учраас би энийг бол Булгаа сайд бол өөрөө ингэж авъя гэж оруулж ирээгүй юм байна шүү дээ уг нь. Энэ ядаж хамтын удирдлагатай нийгмийн даатгалын үндэсний зөвлөлдөө байвал уг нь хэрэгтэй дээ. Тэгээд сайд шийдвэр гаргасан гээд л Номтойбаяр сайд чинь тушаал гаргаад л хамтын удирдлагатай этгээдээр орсон. Тэгсэн тушаал гаргасан гээд л чирээд аваад явсан шүү дээ. Энэ бол яг энэ сувиллыг яаж сонго гэдэг гэсэн гээд гудчаад л явна л даа. Би бол шийдвэр гаргаж байгаа хүмүүсийн нэг хүн энэ шийдвэр гаргана гэдэг бол их асуудал. Ядаж хяналт тавих нэг ингээд гэрээ байгуулах эрх, хяналт тавих эрх 2-ыг 1 хүн журмыг нь гаргаад байна гэдэг чинь өөрөө бас *check and balance*-ийн хувьд болохгүй байхгүй юу. Ялангуяа нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг. Тэр сувиллыг яаж сонгох вэ, яаж гэрээг нь байгуулах вэ, хэн хяналт тавих вэ гэдэг журам байгаа. Ядаж хяналт тавих журмыг нь Үндэсний зөвлөл нь батлах хэрэгтэй тэгвэл ядаж. Сангийн эзэн чинь бол Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байхгүй юу. Сайд бол нийгмийн даатгалын мөнгө чинь ганцхан Засгийн газрын хөрөнгө буюу төрийн мөнгө биш шүү дээ гол онцлог нь. 3 талын оролцоотой. Энэ мөнгийг хэрхэн яаж зарцуулах вэ гэдэг бол ганцхан Засгийн газрын төлөөлөл дангаараа шийддэг асуудал бас биш. Энийг яаж санхүүжүүлэх вэ гэдэг энэ 3 төлөөллийн оролцогч 3-уулаа оролцож шийддэг байх нь л өөрөө зарчим нь уг нь зөв байгаад

байгаа юм л даа. Тийм учраас би энийг бол уг нь Үндэсний зөвлөл нь бараг энэ журмыг нь баталчихвал аль алиндаа л хэрэгтэй юм шиг санагдаад байх юм.

Г.Занданшатар: Энэ санал зүйтэй гэж Засгийн газар ч гэсэн үзэж байгаа учраас журмыг төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэндийн болон хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална гэсэн агуулгаар байж болох юм. Гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Энэ чинь сэргээн засах төв, сувилал чинь танай харьяатай болчихоод байгаа. Тэгвэл тэр саналыг үндэслээд тэгээд явчихъя.

13.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “сэргээн засах болон” гэж, 14.1.3 дахь заалтын “рашаан,” гэснийг “сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн “Даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг нийгмийн даатгалын” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж, 14.3 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид протез” гэснийг “Протез” гэж, мөн зүйлийн 14.5 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч” гэснийг “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч” гэж, 14.6 дахь хэсгийн “Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид” гэснийг “Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас сэргээн засах төв болон” гэж, мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн “Рашаан болон мэргэжлээс шалтгаалсан өвчтөний” гэснийг “Сэргээн засах болон” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.9 хувийн

саналаар санал дэмжигдлээ. Энэ бол 22 байх аа. Одоо удахгүй дууслаа.

14.Төслийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн” гэснийг “хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан” гэж, мөн хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 15.7 дахь хэсгийн “нийгмийн даатгалын” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “бөгөөд” гэсний дараа “үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний” гэж нэмж, 16.3.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 16 дугаар зүйлийн 16.3.2 дахь заалтыг хасах:

“16.3.1.ажил олгогчийн шимтгэл төлөлт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас даатгуулагчид олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр болон ажил олгогчид үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт, мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо, холбогдох бусад мэдээллийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3.3 дахь заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны” гэж, мөн зүйлийн 16.4 дэх хэсгийн “нийгмийн даатгалын болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар” гэснийг “хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ дахиад сайд руу ирүүлчих шиг

болох юм. Санал хураалт. Засгийн газар баталдгийг сайд гэсэн байна. Санал хураалт. 52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо найруулгын саналаар санал хураалт явуулна. Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг сайд буцаж орж ирнэ үү. Санал хураалт явуулах гэж байна.

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал:

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “биелүүлэх үед” гэснийг “гүйцэтгэх явцад” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “тогтоолгоход” гэж, 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсгийн “авах өргөдөл гаргахад” гэснийг “авахад” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “/байцаагч/” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Энэ чинь найруулгын санал шүү дээ.

Х.Булгантуяа: Их Хурлын дарга аа, сая тоног төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулж өгнө үү.

Г.Занданишатар: Булгантуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. 55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн учраас саяны найруулгын саналаар санал хураалтыг дахиж явуулъя. Санал хураалт. 57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Нэг.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1.Төслийн 2 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын ерөнхий” гэснийг “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Г.Занданишатар: 1.Төслийн нэрийн “ХУУЛЬД” гэсний дараа “НЭМЭЛТ,” гэж, 2 дугаар зүйлийн ““хөдөлмөрийн чадвар алдсаны” гэж” гэсний дараа “, ““тахир дутуугийн тэтгэвэр” гэснийг “хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр” гэж тус тус” нэмж, 1 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлнэ” гэснийг “заасан мэдээллийг бүрдүүлнэ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дуусав.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

17.53 цаг.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 20223 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүд Н.Учрал нарын 5 гишүүнээс 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийг нэгтгэн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Үүнд:

Нэг.2022 онд батлагдсан Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцүүлж, нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн үйл ажиллагааг эрхлэх этгээдэд олгох тусгай зөвшөөрлийг олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг нарийвчлан зохицуулахаар,

Хоёр.Төрийн үйлчилгээг цахимжуулах зорилтын хүрээнд нэмэлт тэтгэврийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаа болон хөтөлбөр бүртгэхтэй холбоотой баримт бичгийг цахимаар хүлээн авах, шийдвэрлэх зохицуулалтыг тусгалаа.

Ажлын хэсгээс Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 54 санал, найруулгын шинжтэй 1 санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 1 санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрийн гишүүнчлэлтэй ажилтан, гишүүд өөр байгууллагад шилжсэн тохиолдолд тэтгэврийг шилжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтын талаар болон ажил олгогчийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт хамрагдсан ажилтны сар төлөх шимтгэлийн доод хязгаарыг хөтөлбөрт хамрагдсан ажилтны сар төлөх шимтгэлийн доод хязгаарыг тогтоосон нь сайн дурын даатгалын зарчимтай нийцэж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нараас өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгтгэн явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданишатар: За баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Баасангийн Батжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Ренчиндорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Өлзийбаярын Бодьгэрэл Бодьгэрэл, Санхүүгийн зохицуулах хорооны даатгалын газрын дарга З.Батболд, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх Алтанбулагийн Нинжсин.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүнийг оруулъя. Үгээ дараа хэлье гэж байна.

18 цаг болсон байна. Бямбацогт гишүүн нэрээ татсан. 18 цаг болсон. 57 саналтай. Зарчмын зөрүүтэй саналтай.

Энэ асуудлыг нарийн сайн үзэх ёстой байх аа. Хуулийн төслийн талаар нарийвчлан судлах санал, шаардлагуудыг

Чинзориг нарын гишүүдээс тавьж байгаа учраас өнөөдрийн нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хойшиллоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаан өндөрлөхийн өмнө эцсийн найруулгууд, сая баталсан тогтоол уншиж танилцуулъя.

Сая хуулийн төслүүдийг буцаахаар олонхын саналаар шийдвэрлэсэн.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэж нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай. Тогтоолын төсөл санал хураалтаар дэмжигдсэн учраас тогтоол батлагдсанд тооцлоо. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга

байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн тогтоолын төслийг батлагдсанд тооцсон.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасугай. Тогтоол батлагдсанд тооцлоо. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай. Олонх дэмжсэн учраас энэ тогтоолын төслийг батлагдсанд тооцсугай. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд 5 хууль буцсан.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдаж гарсан:

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр

саналтай гишүүн байна уу. Алга байна.
Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна.
Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Хууль, тогтоолын төслүүдийн эцсийн найруулгыг сонслоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаа хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

18.05 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ